

ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНКНЫ БАРИМТ БИЧИГ

МОНГОЛ УЛСАД БАРИМТЛАХ СТРАТЕГИ

Энэхүү баримт бичгийн эх хувийн орчуулгыг ЕСБХБ-наас зөвхөн уншигчдын ая тухад зориулан гаргаж байгаа болно. Хэдийгээр орчуулгын үнэн зөв байдлыг хангах талаар ЕСБХБ зохих анхаарал тавьсан хэдий боловч, түүний үнэн зөвийг баталгаажуулахгүй, мөн нотлохгүй. Орчуулгын эх сурвалжид тулгуурлан ажиллах эсэх нь тухайн уншигчийн өөрийнх нь эрсдэл болно. Орчуулгын аливаа буруу зөрүү, алдаа, орхигдуулсан, дутуу зүйл, утга агуулга гажуудсан, өөрчлөгдсөн тохиолдлын төлөө, тэдгээрээс үүдэн гарч болзошгүй аливаа хор хохирлын төлөө, түүний учир шалтгаанаас үл хамааран, ЕСБХБ, түүний ажилтнууд болон төлөөлөгчид уншигчийн болоод өөр хэн нэгний өмнө хариуцлага хүлээхгүй. Баримт бичгийн англи эх болон орчуулсан хувилбарын хооронд аливаа зөрүү, зөрчил гарсан тохиолдолд англи эх давамгайлна.

АГУУЛГА

ТОЙМ	3
1 БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ.....	6
1.1 БАНКНЫ ОДООГИЙН САНХҮҮЖИЛТЫН БАГЦ	6
1.2 ӨМНӨХ СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ	6
1.3 ГОЛ СУРГАМЖУУД	10
2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЧИН.....	11
2.1 УЛС ТӨРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	11
2.2 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	12
2.3 БҮТЦИЙН РЕФОРМ ХИЙХ НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	15
2.4 САНХҮҮЖИЛТ ОЛОХ ГАРЦ	16
2.5 БИЗНЕСИЙН ОРЧИН БА ЭРХ ЗҮЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	18
2.6 НИЙГМИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	20
2.7 НОГООН ЭДИЙН ЗАСАГТ ШИЛЖИХ НЬ	22
3 СТРАТЕГИЙН ЧИГ БАРИМЖАА	24
3.1 СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛҮҮД	24
3.2 ГОЛ ГОЛ СОРИЛТУУД БА БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА	26
3.3 ОРНЫ СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ГАРЧ БОЛЗОШГУЙ ЭРСДЛҮҮД	36
3.4 БАНКНЫ САНАЛ БОЛГОЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ҮР ДАГАВАР	37
3.5 ЕСБХБ-НААС БУСАД ОЛОН ТАЛТ ХӨГЖЛИЙН БАНКУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ НЬ	40
ХАВСРАЛТ 1 – УЛС ТӨРИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	42
ХАВСРАЛТ 2 – ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	50
ХАВСРАЛТ 3 – ШИЛЖИЛТИЙН ҮЕИЙН СОРИЛТУУДЫН ҮНЭЛГЭЭ.....	51
ХАВСРАЛТ 4 – ХУУЛЬ ЭРХЗҮЙН ШИНЭЧЛЭЛТ	57
ХАВСРАЛТ 5 – ЖЕНДЭРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	61
ХАВСРАЛТ 6 – ЕСБХБ БА ХАНДИВЛАГЧИД	64

ТОЙМ

Монгол Улс тус Банкыг үүсгэн байгуулах тухай Хэлэлцээрийн Нэгдүгээр зүйлд заасан нөхцлийг хангасаар ирсэн. Тус улс шилжилт хийж эхэлснээсээ хойшхи 20 гаруй жилд олон ургальч ардчилал болон нээлттэй, зах зээлийн чиглэлтэй эдийн засагт хүрэх замд ихээхэн дэвшил хийлээ.

2016 оны 6 дугаар сард болсон парламентын сонгуулиар Монгол Ардын Нам (МАН) үнэмлэхүй ялалт байгууллаа. Сонгуулийн дараа МАН Сангийн сайд асан Ж. Эрдэнэбатын тэргүүлсэн Засгийн газрыг дангаараа бүрдүүлэв.

Шинэ Засгийн газрын нэг үндсэн сорилт бол эдийн засгийн байдлыг тогтворжуулах явдал байх болно. Сүүлийн жилүүдэд түүхий эдийн үнэ унасан, монгол төгрөг суларсан, хөрш орнуудын эдийн засгийн өсөлт удааширсан, төрийн тогтворгүй бодлого зэрэг хүчин зүйлсийн улмаас гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхол хумигдсан нь Монгол Улсад хохирол учруулаад байна. Засгийн газар 2016-2020 оны Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртөө дээрх асуудлуудын заримыг нь шийдвэрлэхэд чиглэсэн тэргүүлэх гол зорилтуудаа тодорхойлсон.

Хэдийгээр Монголын урт хугацааны төлөв байдал найдвар төрүүлж байгаа боловч эдийн засаг нь богино хугацааны ноцтой хомсдол (дефицит)-той тулгарч байна. 2016 оны 12 дугаар сарын байдлаар тус улсын нийт гадаад өр ДНБ-ний 155%-тай тэнцсэн байна. Эдийн засгийн өсөлт саарч, 2015 онд 2,4% болж бууран, улмаар 2016 онд 1% болсон байна. Мөн 2016 оны төсвийн алдагдал 15% орчим болж нэмэгдсэн ба энэ нь Төв Банкнаас өмнө нь төсвөөс гадуур хэрэгжүүлж байсан санхүүжилтын хөтөлбөрүүдийг тайлан тэнцэлд оруулж тооцдог болсноос зарим талаар үүдэлтэй. Цаашдаа Засгийн газар төсвийн алдагдлыг ДНБ-ний 10.4%-д хүргэн бууруулах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд энэ нь төрийн санхүүжилттэй хөтөлбөрүүдийн зарлагыг ихээхэн хумьж, төрийн захиргааны зардлыг багасгахад хүргэнэ. Эдийн засгийн өсөлт сайжирч, 2017 онд 1.4%, цаашдаа 2018 онд 2,8%-д хүрэх төлөвтэй байна. Үүнд гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО), түүний дотор Оюу Толгойн уул уурхайн төслийн хоёрдугаар үе шат болон түүхий эдийн үнэ сайжрах төлөв түлхэц болох юм.

Гэхдээ 2017 онд тооцоолсон өсөлтийг хангах, цаашдаа өсөлтийг эрчимжүүлэх чадвар нь тус улс орны туйлын хэрэгцээтэй байгаа бүтцийн реформ хийх чадвар, түүний дотор төсвийн илүү тэнцвэртэй байдалд хүрэх үйл ажиллагаа, уул уурхайн салбарын орлогыг эдийн засгийн өсөлтийг дэмжих, тэсвэрлэх чадавхийг нь сайжруулахад зарцуулах стратегиас онцгой хамаарах болно. Олон улсын валютын сан (ОУВС) 2017 оны 5 дугаар сард 440 сая ам.долларын Өргөтгөсөн санхүүжилтын хөтөлбөр баталсан нь нь чухал боллоо. Тус хөтөлбөрт төсвийн нэгдмэл байдал, мөнгөний бодлого, банкны салбарын реформын холбогдолтой нөхцлүүд тусгагдсан байна.

Ерөнхийдээ тус орны эдийн засаг Хятадтай нягт уялдаатай, түүхийн эдийн үнийн мөчлөгөөс гүнзгий хамааралтай байсаар байна. Тиймээс улс орны байгалийн ихээхэн баялгийг ил тод удирдан зохицуулах, түүний хажуугаар илүү тэсвэртэй, төрөлжсөн, өрсөлдөх чадвартай эдийн засагт хүрэх бодлогоо тодорхойлох явдал Монголын урт хугацааны ирээдүйд амин чухал болоод байна. Монгол дахь хамгийн том гадаадын хөрөнгө оруулагчийн хувьд ЕСБХБ нь байгалийн баялгаа илүү үнэ цэнэтэй болгох, эдийн засгийн тэсвэрлэх чадавхиа бэхжүүлэх, өргөн суурьтай, нийтийг хамарсан өсөлт бий болгоход нь тус оронд туслах онцгой боломжтой юм.

Энэ утгаар дараагийн стратегийн хугацаанд Банкны зүгээс Монгол Улстай хамтран ажиллах явдлыг удирдан чиглүүлэх дараахь стратегийн чиглэлүүдийг санал болгож байна. Үүнд:

- **Олборлох бус салбарын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, санхүүгийн эх үүсвэр олох гарцыг хялбаршуулах замаар Монголын тэсвэрлэх чадварыг сайжруулах:** Монгол улсын хөрөнгө оруулалтын орчин (бүс нутагтаа шилдэгүүдийн тоонд орно) инноваци болон энтрепренёр санаачилгад таатай боловч эдийн засагт нь дийлэнхдээ боловсруулаагүй ашигт малтмал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн зэрэг үнэ цэнэ бага нэмсэн үйлдвэрлэл давамгайлсан байдаг учир гадаад зах зээлийн шок, түүхий эдийн үнийн мөчлөгт маш их эмзэг байдаг. Компаний засаглал, бизнес удирдлагын стандарт нь доогуур түвшинд, үнэ өртөг ахиулсан гинжин сүлжээ муу хөгжсөн, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь муу чанар, эрүүл ахуйн тааруухан стандартаас хохирол амссан байдалтай байна. Ийм нөхцөл байдалд тус Банк Монголын эдийн засгийн суурийг өргөтгөх, эдийн засгийг илүү өрсөлдөх чадвартай, тэсвэртэй болгоход туслах зорилгоор олборлох бус салбарыг дэмжиж ажиллах болно. Ялангуяа инноваци, мэргэжлийн чадвар дамжуулалтыг дэмжсэн, хүнсний үйлдвэрлэл, барилгын материал, хөнгөн үйлдвэрлэл, үйлчилгээг онилсон санхүүжилтын төслүүд хэрэгжүүлэх замаар орон нутгийн компани, ЖДҮ-ийн өрсөлдөх чадварыг сайжруулах талаар ажиллана. Мөн тус Банк санхүүжилт олох, ялангуяа үндэсний валютаар олох гарцыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх ба үүний тулд түнш банкууддаа зориулан зээлийн дагнасан шугам, эрсдэл хуваалцах механизм ажиллуулан, ЖДҮ, үнэ өртөг ахиулсан гинжин сүлжээний санхүүжилт, эрчим хүчний хэмнэлтийг онилон ажиллах болно. Мөн эдийн засгийн тэсвэрлэх чадварыг цаашид нэмэгдүүлэх үүднээс үндэсний валют, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд идэвхтэй оролцож ажиллах болно.
- **Тогтвортой ажиллагааг бэхжүүлэх, үнэ өртөг нэмэгдүүлэх ажлыг дээд хэмжээнд хүргэх зорилгоор сайн засаглалтай уул уурхайн салбарын үр ашгийг нэмэгдүүлэх:** Өргөтгөл, хайгуулын томоохон төслүүдийг хөгжүүлэх явдал ирэх жилүүдийн эдийн засгийн өсөлтийн үндсэн хөдөлгөгч хүч байх болно. Гэхдээ үнэ өртөг нэмэгдүүлэхийг дээд хэмжээнд хүргэх, тогтвортой, бүгдэд хүртээлтэй өсөлтийг хангахын тулд тус салбарт реформ, хөрөнгө оруулалт нэмж хийх шаардлагатай болно. Мөн уул уурхайн салбарын төслүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь ханган нийлүүлэх гинжин сүлжээгээр тус салбарт холбогдсон дотоодын үйлдвэрийн газруудын өрсөлдөх чадвар, үнэ өртөг нэмсэн агууламжийг сайжруулах бололцоо олгох болно. Тиймээс тус Банк ялангуяа гадаадын хөрөнгө оруулалтын замаар хариуцлагатай уул уурхайг дэмжиж, доороос дээш чиглэсэн санхүүжилт (үнэ өртөг нэмэх гинжин сүлжээ, факторинг санхүүжилт) болон дээрээс доош чиглэсэн гүнзгий боловсруулалт хийх замаар үнэ өртөг нэмсэн гинжин сүлжээний боломжуудыг бий болгохыг эрмэлзэж ажиллахаа үргэлжлүүлнэ.
- **Үр ашгийг нэмэгдүүлэх, арилжааны хэлбэрт оруулах, “ногоон” шийдэл олох замаар дэд бүтцийн үйлчилгээний салбарын чанар, тогтвортой байдлыг сайжруулах:** Монголын дэд бүтцэд модернизаци хийх, цаашид хөгжүүлэх нь уул уурхай болон бусад салбарын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг

хангах, ашигт малтмалын экспортыг хөхиүлэн дэмжих, олборлох бус салбарыг дэмжихэд амин чухал юм. Тээвэр, хот суурин газрын болон эрчим хүчний дэд бүтэц бүгд сайн хөгжөөгүй хэвээр байгаа бөгөөд хууль эрх зүй, зохицуулалтын хүрээ сул, төрийн мэдлийн компаниуд үр ашиггүй боловч зах зээл дээр давамгайлсан хэвээр, үнэ тариф бага, хувийн хэвшлийн оролцоо хязгаарлагдмал байсаар байна. Тус Банкнаас Улаанбаатар хот зэрэг зээлжих чадвартай субъектүүдэд засгийн газрын шууд болон дамжуулан зээлдүүлэх санхүүжилтын бүтэц бий болгохыг эрмэлзэж ажиллана. Хоёрдугаар зэрэглэлийн хот суурин газрын дэд бүтцийг санхүүжүүлэхэд засгийн газрын баталгаа шаардлагатай хэвээр байх ба засгийн газрын зээл авах орон зай байгаа эсэхээс санхүүжилт хамаарна. Тус Банк мөн төмөр зам болон авто замын төслүүдээр хэлхээ холбоо, бүс нутгийн интеграцийг хөгжүүлэх, эрчим хүчний салбарт төр, хувийн хэвшлийн түншлэл (PPP)-ийг дэмжих, чингэхдээ орчин үеийн технологи, сэргээгдэх (салхи, нарны) эрчим хүчийг нэвтрүүлэхийг эрмэлзэнэ.

1 БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ

1.1 Банкны одоогийн санхүүжилтын багц

Хувийн хэвшлийн санхүүжилтын багцын харьцаа: 100%¹, 2017 оны IV сарын 30-ны байдлаар

Салбар	Санхүүжилтын багц				
<i>Дүн сая Евро</i>	Төслийн тоо	Санхүүжилтын багц	Багцын %	Урсгал хөрөнгө	Урсгал хөрөнгийн %
Эрчим хүч	11	629	70%	610	71%
Байгалийн баялаг	8	571	63%	564	66%
Цахилгаан, эрчим хүч	3	58	6%	46	45%
Санхүүгийн байгууллагууд	14	105	12%	92	11%
Депозит зээл (банкууд)	11	102	11%	89	10%
Лизингийн санхүүжилт	1	1	0%	1	0%
Депозит бус зээл (банк бус)	2	1	0%	1	0%
Хөрөнгө оруулалт, худалдаа, ХАА (ICA)	21	167	19%	158	18%
Агробизнес	6	38	4%	31	4%
Хөрөнгө оруулалтын сан	2	9	1%	6	1%
Мэдээлэл, харилцаа холбооны технологи	1	5	1%	5	1%
Үйлдвэрлэл, үйлчилгээ	12	115	13%	115	14%
Дэд бүтэц	1	0	0%	0	0%
Хот суурин газар, байгаль орчны дэд бүтэц (MEI)	1	0	0%	0	0%
БҮГД	47	901	100%	860	100%

Эх сурвалж: EBRD Business Performance Navigator

1.2 Өмнөх стратегийн чиглэлүүдийн хэрэгжилт

Монгол Улсын одоогийн стратегийг Захирлуудын Зөвлөл 2013 оны 6 дугаар сарын 25-нд батлан гаргасан бөгөөд дараахь эн тэргүүний зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Эдийн засгийн төрөлжүүлэлтийг түүхий эдийн бус салбаруудыг дэмжих замаар урагшлуулах;
- Тогтвортой өсөлтийг санхүүгийн эх үүсвэр олох гарцыг нэмэгдүүлэх замаар дэмжих;
- Хариуцлагатай уул уурхайг дэмжих, засаглалын институциудыг бэхжүүлэх; мөн
- Дэд бүтцийг орчин үежүүлж шинэчлэх, хувийн хэвшлийг татан оролцуулах.

Одоогийн стратегийн явц хугацаанд Монгол улс хөрөнгө оруулалтын сонирхлыг унагасан улс төр, эдийн засгийн эрс тогтворгүй байдлыг туулж ирлээ. Засгийн газар Ерөнхий сайдын болон сайдын түвшинд хэд хэдэн удаа өөрчлөлт хийсэн бөгөөд тэр нь томоохон нөлөө бүхий уул уурхай, дэд бүтцийн төслүүдийн асуудлаар шийдвэр гаргах процесст саад болсон юм. Энэ нь Хятадын эдийн засгийн удаашралын улмаас түүхий эдийн үнэ унаад байсантай хавсран, макро эдийн засгийн орчинг ихээхэн муутгаж, тус

¹ Бизнесийн нийт хэмжээ: 5 жилийн эргэлдэх суурь дээр тулгуурласан.

Банкны уул уурхайн салбар дахь чухал түншүүдийн заримд нь сөрөг нөлөө үзүүлсэн юм.

Нөхцөл байдал ийм хүнд байсан хэдий боловч тус Банк санхүүжилтын багцаа нэмэгдүүлж, 2013-2015 онуудад орны стратегийн дагуу нийт €648 сая еврогийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Жишээлбэл, Банк эдийн засгийг төрөлжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоо хэрэгжүүлэх үүднээс олборлох бус салбарын хувийн хэвшлийг санхүү, зөвлөх үйлчилгээ, техник тусламжийн янз бүрийн арга хэмжээгээр дэмжиж, 2013 оноос хойш 22 төсөлд 182 сая еврогийн хөрөнгө оруулалт хийлээ. Олборлох бус салбарт оруулсан Банкны хөрөнгө оруулалт нь хэмжээний хувьд харьцангуй их биш боловч тийм төслүүдийн ач холбогдлын талаар хөрөнгө оруулагч нарт чухал дохио өгч, цаашдын хөгжлийн болоод илүү тэнцвэртэй өсөлтийн суурь болсон арга хэмжээ байлаа. Онцлох үйл явдлуудаас дурдвал:

- Тус Банк үйлдвэрлэл, жижиглэн худалдаа, харилцаа холбоо, хүнсний боловсруулалт, эрүүл мэнд, аялал жуулчлал зэрэг салбарт дараалсан хөрөнгө оруулалт хийх замаар Монголын хувийн хэвшлийн салбарт үйл ажиллагааны шилдэг практик, эрчим хүчний хэмнэлт нэвтрүүлэх ажлыг хөхиүлэн дэмжиж ирлээ. Тухайлбал, Өмнөговьд хамгийн орчин үеийн цементийн үйлдвэр барьж байгуулах, Улаанбаатар хотоос гадуур супермаркетын сүлжээг өргөжүүлэх, орон нутгийн компани мөхөөлдөс үйлдвэрлэхэд Банк санхүүжилт хийлээ.
- Мөн тус Банк стратегийн эхний гурван жилд Жижиг бизнест зөвлөгөө өгөх хөтөлбөрийн хүрээнд оролцоог хангах өндөр түвшний ажиллагаа явуулж, Улаанбаатар хот болон орон нутгийн 200 гаруй бичил, жижиг, дунд үйлдвэр (БЖДҮ)-ийн газруудад хүрч ажиллалаа. 2015 оны 11 дүгээр сар гэхэд бидний харилцагч ЖДҮ-үүд дунджаар жилийн бараа эргэлтээ 75%, хөдөлмөрийн бүтээмжээ 58%-иар өсгөжээ.
- Монгол төгрөг (₮)-ийн ханш унахтай холбоотой үндэсний бизнес салбарынхны эмзэг байдлыг багасгах зорилгоор Банкны зүгээс урт хугацааны шууд санхүүжилтийг үндэсний валютаар олгож эхэлсэн. Тухайлбал, төгрөгөөр нэрлэсэн анхны бондоо (АНУ-ын \$7 саятай тэнцэх 3 жилийн оффшор хувийн хэвшлийн зээл) гаргасан нь нэгэн хөдөлгөөнт утасны операторын төгрөгийн санхүүжилтын зардлыг багасгахад тус нэмэр болсон.
- Банкны Арилжааны зуучлалын төслийн шугамаар Улаанбаатар хотын Худалдааны танхимд зуучлалын чадавхи бий болгож, орон нутагт нэг төв байгуулан, 17 зуучлагчийг сургаж, үйлчилгээний салбарын маркетинг амжилттай эхлүүлэх төлөвлөгөө гаргасан байна. Өнөөдрийн байдлаар олборлох бус салбарт гарсан бизнесийн 9 маргааныг амжилттай зуучилсан бөгөөд энэ нь дунджаар ердийн хуулийн тогтолцоогоор явахад 3 жил болдог байсантай харьцуулбал 2 сард нэг удаа болдог болсон байна.

Мөн **санхүүжилт олох гарцыг** өргөжүүлэх, үндэсний валютын зах зээлийг хөгжүүлэх талаар тус Банк хүчин чармайлтаа нэмэгдүүлсэн. Үүнд:

- ЕСБХБ түнш хоёр банк, банк бус санхүүгийн нэг байгууллага (ББСБ) болон хэд хэдэн бизнесийн харилцагчиддаа 108 сая ам.доллартай тэнцэх төгрөгийн санхүүжилт олгосон. Хэдийгээр түнш банкуудын тоо хэмжээ хязгаарлагдмал боловч ЕСБХБ нь урт хугацааны төгрөгийн санхүүжилт хийдэг цорын ганц олон улсын санхүүгийн байгууллага (ОУСБ) байсан хэвээр байгаа бөгөөд одоогийн байдлаар 50 сая ам. доллартай тэнцэх төгрөгийн санхүүжилт хийсэн ба энэ нь

ЖДҮ-ийн валют арилжааны алдагдлыг багасгаж, бизнес байгууллагуудыг тогтворжуулсан байна. Хэдий тийм боловч, үндэсний валютаар санхүүжилт хийхийн үнэ өртөг (түүний дотор Банкны хувьд ч гэсэн) Банкны илүү их зээл олгох чадварт саад тотгор болсоор байна.

- ЕСБХБ-ны Монголын тогтвортой эрчим хүчний санхүүжилтын анхны хөтөлбөр (MonSEFF)-ийн хүрээнд 10 сая ам. доллартай тэнцэх (₮ болон \$-оор) санхүүжилтыг хувийн үйлдвэр, аж ахуйн газарт дамжуулан зээлдүүлэхээр эрчим хүчний хэмнэлтийн хөрөнгө оруулалтад оролцож байгаа түнш банкуудад чадавхи бий болгох тусламжийн хамт олгосон. MonSEFF нь хэдийгээр эрчим хүчний үнэ тариф бага байгаагаас удаан урагшилж байгаа боловч мэргэжлийн зөвлөгөө авах, боломжийн урт хугацааны төгрөгийн санхүүжилт авах боломжийг орон нутгийн компаниудад олгож байна. Нийтдээ ЕСБХБ-ны 2013-2015 оны үйл ажиллагаа нь жилд 22000 тонн нефтэтэй тэнцэх хэмжээний эрчим хүчний хэмнэлт гаргахад хүргэсэн байна.
- Тус Банк мөн Үнэ өртөг нэмэх гинжин сүлжээний санхүүжилтын зээлийн шугам зэрэг зорилтот зээлийн шугамыг түнш банкууддаа олгосон бөгөөд ингэснээрээ уул уурхайн нэр хүнд бүхий томоохон компаниудад гэрээгээр үйлчилдэг дотоодын ЖДҮ-үүдэд боломжийн хүүтэй зээл авах гарцыг нэмэгдүүлсэн болно. Орон нутгийн жижиг болон төрөлжсөн 60 гаруй бизнесийн байгууллага энэ бүтээгдэхүүний ашиг тусыг хүртэж, дунджаар 110,000 ам. долларын зээл авсан байна.
- Бичил санхүүжилтын салбарт тус Банк Монголын хамгийн нэр хүндтэй бичил санхүүгийн байгууллага болох Транскапитал ББСБ-тай хамтран ажиллаж, компаний засаглалын хөтөлбөр, төгрөгийн санхүүжилтын шугамын хүрээнд оролцоогоо нэмэгдүүлсэн болно. ЕСБХБ-ны дэмжлэгтэйгээр дээрх бичил зээлийн байгууллага өөрийн байнгын үйлчлүүлэгчдийн тоог 23%-иар өсгөж чадсан бөгөөд Улаанбаатар хот болон орон нутгийн ядуу хороолол дахь бичил үйлдвэрлэгчид зэрэг банкны үйлчилгээ хүрдэггүй харилцагчдад хүрч ажилласан байна.
- Тус Банк мөн 2016 оноос эхлэн инфляцийг чиглэсэн техник хамтын ажиллагаагаар Монгол Банк (Монголын Төв банк)-ыг дэмжин ажиллаж байна. Үүний үр дүнд, Төв банк бодлогын гол гол шийдвэрүүдийг хэлэлцэн хэрэгжүүлэх үүрэгтэй Мөнгөний бодлогын хороог Банкны тусламжтайгаар албан ёсоор байгуулах боломжтой болсон ба энэ нь дүн шинжилгээ хийх явдлыг сайжруулаад зогсохгүй, шийдвэр гаргах үйл явцын үр дүнтэй, ил тод байдлыг улам батжуулж өгсөн болно.

Хэдийгээр түүхий эдийн үнийн мөчлөг дэх уналт ЕСБХБ-ны харилцагчдад нөлөө үзүүлж байсан үед уул уурхай дахь санхүүжилтын багцын чанарт сорилт тулгарч байсан боловч тус Банк уул уурхайн салбарт **хариуцлагатай уул уурхай болон компаний сайжруулсан засаглалыг** дэмжин ажиллаж ирлээ.

- Банк нийгэм, байгаль орчин, аюулгүй ажиллагааны хамгийн өндөр стандартын шаардлага хангасан, гадаадын сайн чанарын эзэмшил бүхий менежмент сайтай компаниудад төвлөрсөн уул уурхайн төслүүдийг сонгон хөрөнгө оруулалт хийж ирсэн. Тухайлбал, Оюу Толгойн зэсийн уурхайн өндөр нөлөөтэй санхүүжилт нь Монголын хувьд онцгой чухал төсөл бөгөөд гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг сэргээж чадсан. ЕСБХБ 368 сая еврогийн зээл олгож, олон улсын арилжааны банкуудаас нэмэлт 700 сая еврогийн хамтарсан хөрөнгө босгож өглөө.

- Тус Банк “Алтан Рио Материал” компанийн алтны уурхайн төслийн баримт бичгүүдээр дамжуулан хайгуулын жижиг компаниудын дунд Монголын байгаль орчин, нийгмийн харилцааны менежментийн стандарт болон ил тод байдлыг сайжруулах талаар ажиллалаа. Үүний үр дүнд, Монголд бүртгэлтэй, хөрөнгийн биржэд хувьцаа гаргасан компани байгаль орчны жилийн тайлангаа анх удаа олон улсын шилдэг практикийн дагуу гаргасан. Тус компани байгаль орчин, аюулгүй ажиллагааны менежментийн орчин үеийн системийг нэвтрүүлэн хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ЕІТІ)-ын шаардлагыг хангасан үйл ажиллагаа явуулж байна.
- ЕІТІ Санаачилгыг хэрэгжүүлэх үндэсний хүчин чармайлтыг зохицуулах үүрэг бүхий Ажлын албанд тус Банк техник тусламж үзүүлж ирлээ. Тухайлбал, ЕСБХБ ЕІТІ-н тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулах, батлуулахаар парламентад өргөн барих, онлайн “цахим-Тайлан” туршилтын төслийг хэрэгжүүлж дуусах ажлыг дэмжин ажилласан. Үр дүнд нь, түүхий эдийн худалдаа эрхэлдэг хоёр компани орлого, зарлагаа цахим хэлбэрээр нийтэд мэдээлдэг болсон байна. ЕІТІ-н дэд зөвлөлүүдийн хуралдаануудыг уул уурхайн гол гол аймгуудад зохион байгуулж, бүс нутаг, орон нутгийн засаг захиргаа, иргэдийн төлөөлөгчдийн хурлууд, уул уурхайн компаниуд, ТББ-уудыг хамруулан оролцуулсан.
- Банк уул уурхайн төслийг хэрэгжүүлэх явцдаа нөхөн сэргээх, биологийн төрөл зүйлийг хадгалан хамгаалах асуудлаар олон нийтийн мэдлэг, мэдээллийг сайжруулах зорилгоор ТББ-ууд болон уул уурхайн компаниудтай хамтарсан семинарууд зохион байгуулсан болно.

Гэвч хот суурин газрын болоод бүс нутгийн дэд **бүтэцдээ модернизаци хийхэд нь** Монгол улсад туслах тал дээр Банк нөлөө багатай байж ирлээ.

- Хоёр талын байгууллагууд, олон улсын санхүүгийн бусад байгууллага (ОУСБ)-ын зүгээс хямд төсөр, урт хугацааны санхүүжилт олдоц ихтэй байсан болон шинээр байгуулсан Хөгжлийн Банкны шугамаар босгосон төрийн (“Чингис”) бондны хөрөнгийг ашиглаж байсан зэргээс хамаарч, ЕСБХБ-ны санхүүжилт нь Монголын засаг захиргааны хувьд, ялангуяа тээврийн салбарт эдийн засгийн утгаар ашиг багатай харагдаж байлаа. Дээр нь, Төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ-PPP)-ийн эрх зүйн хүрээ тогтоогүй, нийтийн үйлчилгээний компаниудын хувьд зардлаа нөхөхүйц тариф тогтоох нь улс төрийн эмзэг асуудал байсан нь тухайн салбар дахь хувийн хэвшлийн оролцоог дэмжих, арилжааны шийдэл санал болгох Банкны боломжийг хязгаарлаж ирсэн болно.
- Хот суурин газрын салбарын хувьд гэвэл тус Банк нийслэл хот, орон нутгийн дэд бүтцийг дэмжих хэд хэдэн санал (жишээ нь Өмнөговийн бохир ус цэвэршүүлэх байгууламж) тавьсан. Гэвч, засгийн газрын зээлийг орон нутагт дамжуулан зээлдүүлэх эрх зүйн орчин тодорхой биш байсан нь Улаанбаатар хот дахь төслүүдийг эцэслэн шийдэх Банкны хүчин чармайлтыг сааруулсаар ирлээ. Банк засгийн газрын зээлийг орон нутагт дамжуулан зээлдүүлэх асуудлаар шийдэл олох, боломж гаргах талаар Улаанбаатар хот болон Сангийн яамтай нягт хамтран ажилласаар байгаа болно.

1.3 Гол сургамжууд

Үндэсний арилжааны банкуудтай хамтран шууд санхүүжилт хийх, хувь эзэмших, эрсдэл хуваалцах зэрэг хэрэгслээр дамжуулан эдийн засгийн төрөлжүүлэлт хийх нь ашиг тустай болохыг одоогийн стратегийн хугацаанд тус Банкны Монголд олж авсан туршлага үндсэндээ харуулж байна. Гэвч, уул уурхайн салбар нэг хэсэгтээ эдийн засгийн давамгай хөдөлгөгч хүч байсаар байхыг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр Монголын эдийн засгийн тэсвэрлэх чадавхийг бэхжүүлэх талаар ЕСБХБ-ны зүгээс хийж болох хамгийн үр дүнтэй, нөлөө ихтэй ажил нь төрөлжүүлэлт гэж ерөнхийлөн дэмжихээсээ илүү олборлох бус салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах явдал байж болох юм.

Түүний зэрэгцээ, эдийн засагт уул уурхай ач холбогдолтой байгаа үед тус Банк салбарын нэр хүнд бүхий төслүүдийг үргэлжүүлэн дэмжих, ингэхдээ экспортын өндөр потенциалтай, боломжтой бол ашигт малтмалыг илүү гүнзгий боловсруулах чадамжтай төслүүдэд илүү анхаарах, үүгээрээ уг салбартай ханган нийлүүлэх сүлжээгээр холбогдсон дотоодын үйлдвэр, аж ахуйн газруудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах ёстой.

Системийн банкуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх Банкны чадвар нь шаардлага хангасан түншүүдийн тоо цөөн байгаагаар хязгаарлагдсаар байх болно. Олборлох бус салбарын үйлдвэр, аж ахуйн газруудыг санхүүжүүлэх үр дүнтэй суваг болгохоор Банкны зүгээс дэмжин ажиллаж байгаа одоогийн түнш санхүүгийн байгууллагуудтай илүү сайн харилцах замаар банкны салбартай, түүгээр дамжуулан БЖДҮ-үүдтэй харилцан ажиллах явдлыг голлон гүйцэтгэх болно. Мөн тус Банк одоогийн хувийн хэвшлийн үйлчлүүлэгчидтэйгээ хамт зээл босгох боломжууд, түүний дотор урт хугацааны төгрөгийн зээлийн боломжийг хайж ажиллана.

Одоогийн стратегийн хугацааны Банкны туршлагаас харахад, хэдийгээр хязгаарлагдмал хувьчлал хийсэн боловч эрчим хүч, тээвэр (тодруулбал, төмөр зам, агаарын тээвэр) зэрэг дэд бүтцийн гол гол салбар дахь төрийн оролцоо богино болон дунд хугацаанд хүчтэй хэвээр байх төлөвтэй байгаа бөгөөд төсвийн орон зайгаар хумигдахгүй бол төрийн хэвшилд зориулсан хямд санхүүжилт буурахгүй бололтой. Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд, Засгийн газрын зээлжих чадвар хумигдаж байгаа учир санхүүгийн хувьд бие даасан шийдэл олох нь шинэ Засгийн газрын сонирхолд нийцэж болох бөгөөд анхны төслүүд амжилттай болох нь стратегийн шинэ мөчлөгт тийм төслүүд явцтай байна гэсэн сайн дохио өгөх магадлалтай. Тиймээс Банк таниулан сурталчлах өндөр нөлөө бүхий төслүүд боловсруулах зорилгоор хот суурин газар, эрчим хүч, тээврийн дэд бүтцийн асуудлаар холбогдох арилжааны шийдэл олж, богино хугацаанд хамгийн найдвартай боломжууд (ялангуяа Улаанбаатар хотын хувьд) дээр төвлөрөх шаардлагатай. Мөн ТХХТ (PPP)-ийн найдвартай төслүүд, түүний дотор эрчим хүчний төслүүдийг үргэлжлүүлэн дэмжиж, боломжтой нөхцөлд төрийн үйлчилгээний компаниудын тарифын тогтвортой механизм ажиллуулах талаар Засгийн газартай харилцан ажиллах шаардлагатай.

2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЧИН

2.1 Улс төрийн нөхцөл байдал

Монгол Улс шилжилт хийж эхэлснээс хойшхи 20 гаруй жилд олон ургальч ардчилал, зах зээлд чиглэсэн нээлттэй эдийн засагтай болох замд ихээхэн ахиц дэвшил гаргалаа.

Монгол Улс нь либерал Үндсэн хуультай, улс төрийн намуудын өрсөлдөөнт тогтолцоог хөгжүүлсэн, эрч хүчтэй иргэний нийгэм байгуулсан орон юм. Хэвлэл мэдээллийн байгууллагууд нь өргөн олон асуудлаар хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй, хуулийн засаглалыг илүү их баримтлах болсон, хүний эрхийг дээдэлсэн орон боловч олон сорилттой тулгарсаар байна.

Монгол дахь улс төрийн үйл явц тус орны улс төрийн гол хоёр нам болох Монгол Ардын Нам (МАН) болон Ардчилсан Нам (АН)-ын нөлөөнд байсаар ирсэн уламжлалтай юм. МАН нь 2012 оны 6 дугаар сард болсон сонгууль хүртэл парламентад давамгай байр суурьтай хүчин байсан бөгөөд тэр сонгуулиар АН хууль тогтоох байгууллагад харьцангуй олон суудал авсан байна.

Гэвч 2016 оны 6 дугаар сарын 29-ний парламентын сонгуулиар МАН үнэмлэхүй ялалт байгуулж, нэг танхимтай хууль тогтоох байгууллагын 76 суудлын 65-ыг нь авчээ. АН зөвхөн 9 суудал авч чадсан байна. Сонгуулиар ямар нэг томоохон асуудал гараагүй бөгөөд сонгууль чөлөөт, шударга сонгуулийн олон улсын стандартад үндсэндээ нийцсэн гэж ажиглагчид дүгнэжээ.

Сонгуулийн дараа МАН дангаараа бүрдүүлсэн бөгөөд Сангийн сайд асан Жаргалтулгын Эрдэнэбатын толгойлсон Засгийн газар хурдан байгуулагдлаа. Шинэ Засгийн газар хуваагдаж бутарсан АН-ынхтай харьцуулбал илүү тогтвортой ажиллана гэсэн хүлээлт байгаа. АН үргэлж л хувааган явж ирсэн бөгөөд одоо сонгуулийн үр дүнгийн дараа дотроо нухацтай өөрчлөлт хийж, улс орны улс төр дэх байр сууриа сэргээж авах шаардлагатай болоод байна.

Ерөнхийлөгчийн дараагийн сонгууль 2017 оны 6 дугаар сард болно. Одоогийн сөрөг хүчин болох АН-аас 2013 оны ерөнхийлөгчийн сонгуулиар нэр дэвшиж байсан Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж энэ албан тушаалд хоёр удаа сонгогдон ажилласан учир Үндсэн хуулийн дагуу дахин нэр дэвших эрхгүй юм.

Шинэ Засгийн газрын нэг гол сорилт бол эдийн засгийн байдлыг тогтворжуулах явдал юм. Монгол Улсад түүхий эдийн үнэ унасан, төгрөгийн ханш суларсан, хөрш Орос болон Хятад дахь эдийн засаг удааширсан, засгийн газрын тогтворгүй бодлогын улмаас хөрөнгө оруулагчдын сонирхол буурсан зэрэг хүндрэлүүд сүүлийн үед гараад байна. Засгийн газрын 2016-2020 оны Үйл ажиллагааны төлөвлөгөөнд шинэ Засгийн гол гол тэргүүлэх зорилтуудыг тодорхойлсон байна.

Монголын аль ч засгийн газрын хувьд урт хугацааны сорилт нь ядуурлын түвшин өндөр байгаа тус орны байгалийн асар их нөөцөөс бий болох баялгийг хэрхэн ил тод захиран зарцуулах вэ гэдэгт оршиж байна. Монгол Улс эдийн засгийн хувьд Хятадад тулгуурлах болсон бодит үнэнийг улстөрийн хоёр гол намын аль аль нь хүлээн зөвшөөрч байгаа. АН 2014 онд Хятад улстай Иж бүрэн стратегийн түншлэлийн гэрээ

байгуулсан. МАН засгийн эрх аваад Хятадтай ойр дотно харилцаагаа мөн үргэлжүүлсээр байна.

2.2 Макро эдийн засгийн нөхцөл байдал

Монголын эдийн засгийн өсөлт ялангуяа сүүлийн жилүүдэд удааширсаар ирлээ. 2011 онд дээд хэмжээ болох 17,3 хувь хүрч байсан эдийн засгийн өсөлт 2015 онд 2,4 хувь болон буурч, 2016 онд бүр 1 хувь болон удааширсан бөгөөд дотоодын эрэлт хэрэгцээ буурч, хөрөнгө оруулалт өмнөх жилүүдийн уналтаасаа салж, сэргэх гэж оролдож ирлээ. Үндсэндээ уул уурхайн салбарт томоохон хөрөнгө оруулалт хийгдсэний үр дүнд эдийн засгийн өсөлт 2016 оны сүүлийн улиралд ихээхэн сэргэж, жилийн бодит утгаар 9,9%-иар эрчимжин, 2017 оны эхний улиралд 4,2%-д хүрсэн байна. Валютын дарамт 2016 онд ихээхэн нэмэгдэж, монгол төгрөг АНУ-ын долларын эсрэг 20% суларсан бөгөөд үр дүнд нь дотоодын эрэлт хэрэгцээ хумигдаж, хувийн бодит хэрэглээ 11,7%-иар буурсан байна. Эдийн засгийн өсөлт удааширч, валютын ханш суларсан нь 2014 оны 12 дугаар сард 5,0% байсан найдваргүй зээлийн хэмжээ 2016 оны 12 дугаар сард 8,5% болоход хүргэжээ. Төв Банк 15% байсан бодлогын хүүгээ 2016 оны 12 дугаар сард 14% болгон бууруулсан бөгөөд өмнө нь 8 дугаар сард долларын эсрэг төгрөгийн ханшны огцом уналтыг зогсоохын тулд 10,5%-иас 15% болгон өсгөж байсан юм. Дотоодын эрэлт бага байсны үр дүнд инфляци ихээхэн суларч, 2015 онд 6,0% байсан бол 2016 онд дунджаар 0,5% болсон байна.

Монголын гадаад байр суурь сул хэвээр байна. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа удааширснаар 2011-2013 онд ДНБ-ний 26 орчим хувь байсан урсгал дансны алдагдал 2016 онд ДНБ-ний 4,0% орчим болж буурав. Гэвч импорт их хийдэг уул уурхайн томоохон төслүүд сэргэж ирэхэд энэ алдагдал дахиад өсөх хүлээлттэй байна. 2016 онд 2014 онтой харьцуулахад бараа, үйлчилгээний экспорт 16%-иар, бараа, үйлчилгээний импорт 26%-иар буурсан байна. Өрийн өндөр түвшин тус орны гадаад байр сууринд хамгийн том эрсдэл болоод байна. Нийт гадаад өр 2016 оны 12 дугаар сарын байдлаар ДНБ-ний 155% (компани хоорондын зээлийг оролцуулбал 221,8%)-тай тэнцэж байгаа бөгөөд ОУВС-гийн багцын хүрээнд авх шинэ зээлүүдийн үр дүнд цаашид улам өсөх хүлээлттэй байна. Засгийн газар 2017 оны 3 дугаар сард 7 жилийн хугацаатай шинэ бонд гаргаж, гадаад бондын дахин санхүүжилт хийсэн учир төлбөрийн чадварын богино хугацааны дарамт суларсан байна.

Төрийн санхүү муудсаар байна. 2016 оны төсвийн алдагдал төлөвлөж байсан 4%-иас давж, ойролцоогоор 15,4% болон өссөн бөгөөд энэ нь өмнө нь Төв Банкнаас төсвөөс гадуур явуулж байсан зарлагын хөтөлбөрүүдийг тайлан тэнцэлд буцаан тусгаснаас хэсэгчлэн болсон. Үүнд, «Сайн малчин, сайн оюутан, сайн хашаа» гэх зэрэг бодлогын зээлийн хөтөлбөрүүд, Эрдэнэс Таван Толгойн нийтийн хувьцаанаас буцаан худалдаж авах хөтөлбөр багтаж байсан. Засгийн газар 2017 оны 4 дүгээр сард төвийн тодотгол баталж, түүндээ төсвийн алдагдлыг ОУВС-гийн хөтөлбөр батлагдахад шаардлагатай нөхцлүүдийг хангахуйцаар багасгах зорилго бүхий орлого, зарлагын шинэ арга хэмжээнүүдийг тусгасан. Нэмэлт тодотголын дотор хувь хүний орлогын татварын реформ орж байгаа бөгөөд 10%-ийн нэг шатлалтай татварын оронд өсөн нэмэгдэх (прогрессив) олон шатлалтай татварын тогтолцоо нэвтрүүлж байгаа юм. Чухал бусад нэмэлт өөрчлөлтөд тэтгэврийн насыг нэмэх асуудал багтаж байгаа бөгөөд 2018 оноос эхлэн тэтгэвэрт гарах насыг жилд 6 сараар нэмж, эрэгтэйчүүд 2028 оноос, эмэгтэйчүүд 2038 оноос тус тус 65 нас хүрээд тэтгэвэр авах эрх нь нээгддэг болох юм байна.

Шатахууны татвар, импортын тамхины татвар, согтууруулах ундаа, тамхины онцгой татварыг мөн нэмжээ. 2017 оны төсвийн алдагдлыг 10,4% байхаар тогтоосон байна. ОУВС-гийн шаардлагын дагуу төрийн санхүүжилттэй хөтөлбөрийн зарцуулалтыг ихээхэн танаж, төсвийг нэгтгэх арга хэмжээ нь эдийн засгаа эрчимжүүлэх засгийн газрын чадварыг цаашид ч хязгаарлах байх. Харин, олон улсын санхүүгийн байгууллагуудаас олгохоор яригдаж байгаа санхүүгийн тусламжийн багц болон ОУВС-гийн хөтөлбөрийн нөлөөгөөр авсан реформ хийх амлалтыг хэрэгжүүлэх механизмууд нь Монголыг буцаагаад тогтвортой замд оруулах магадлалтай байна. Оюу Толгойн 2 дугаар үе шатны сэргэлт нь төслийн үр нөлөө бодит байдлаар гарч ирэх үед импортын холбогдолтой татвар зэргээр дамжин, төсвийн гүйцэтгэлийг сайжруулах бас нэгэн нааштай алхам болох юм.

Үл хөдлөх хөрөнгийн зах зээл удааширч, макро эдийн засаг болон банкны салбарын эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Сүүлийн жилүүдэд орон сууцны зах зээл, үл хөдлөх хөрөнгийн үнэ ихээхэн өсөлттэй байсан бөгөөд энэ нь Засгийн газрын Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд орон сууцны татаастай зээл олгож байснаас ихээхэн хамаарсан. 2015 оноос өсөлт нь удааширч, орон сууцны үнэ буурч эхэлсэн боловч ипотекийн зээл 2014 онд 45%, 2015 онд 20%-иар өсчээ. Орон сууцны зах зээл 2016 онд улам унасан учир огцом засал хийхэд хүрч, жилээр тооцсон дүнгээр орон сууцны үнэ 2016 оны 10 дугаар сар гэхэд 6%-иар, ипотекийн зээлийн олголт 57%-аар тус тус буурсан байна. Ийм засал нь банкны салбар дахь найдваргүй зээлийн хэмжээ ихсэхэд хүргэж, эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж болох юм.

Стратегийн хугацааны төлөв байдал

Эдийн засгийн өсөлт 2017 онд 1,4% хүрэх, цаашид сайжирч 2018 онд 2,8% болох төлөвтэй байгаа бөгөөд үүнд Оюу Толгойн 2 дугаар үе шатны хөрөнгө оруулалт нэмэгдэх (дорхи хүснэгтийг харна уу), хөрөнгө оруулалтын орчин болон хэрэглэгчдийн итгэл сайжрах, улмаар эдийн засгийн орчин эрүүлжих явдал тус нэмэр болох болно. Уул уурхайн үйлдвэрлэл аажмаар нэмэгдэж, түүний зэрэгцээ түүхий эдийн үнэ сайжрах нь экспорт болон засгийн орлогын аль алиныг нь нэмэгдүүлнэ. Гэвч ОУВС-гийн шинэ хөтөлбөрийн хүрээнд төсвийн нэгдсэн байдлыг хангах арга хэмжээнүүд, мөнгөний хатуу бодлого ачв хэрэгжүүлснээр богино хугацаандаа төрийн болон хувийн хэрэглээнд сөрөг нөлөө үзүүлэхээр байна. 2017-2018 онд төлөвлөсөн өсөлтөд хүрэх, цаашдын эрчимжилтийг хангах чадвар нь тус орны хувьд онцгой шаардлагатай байгаа макро бүтцийн реформ хийх, түүний дотор Засгийн газрын төсөв, зээлийн илүү тогтвортой бодлого явуулах чадвараас шалтгаалах болно. Гадаад талдаа гэвэл, экспортын 90 орчим хувийг эзэлдэг, Монголын нэг гол худалдааны түнш болох Хятад улс дахь эдийн засгийн сорилтууд экспортын эрэлт хэрэгцээг дарангуйлсан хэвээр байх магадлалтай.

Монгол Улс: Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд

		2012	2013	2014	2015	2016 (тооцоо)
ДНБ-ний өсөлт	%, жилээр	12.3	11.6	7.9	2.4	-1.0
Хэрэглээний үнийн индекс	%, дунджаар	15.0	8.6	12.9	6.0	0,5
Засгийн газрын тэнцэл	ДНБ-ний %	-4.8	-6.8	-1.2	-5.0	-15.4
Урсгал дансны тэнцэл	ДНБ-ний %	-27.4	-25.4	-11.5	-4.8	-4.0
Цэвэр ГШХО	ДНБ-ний %	35.9	16.7	2.3	1.6	-36.7
Нийт гадаад өр	ДНБ-ний %	125.2	151.2	171.7	184.4	221,8
Нийт валютын нөөц	ДНБ-ний %	33.6	17.8	13.5	11.3	11.7
Хувийн хэвшлийн зээл	ДНБ-ний %	41.9	56.2	56.2	50.5	52.0
ДНБ нэрлэсэн үнээр	Тэрбум АНУ \$	12.3	12.6	12.2	11.7	11.1
Нэг хүнд ногдох ДНБ	одоогийн АНУ \$	4,329	4,365	4,169	3,946	3,660
Ажилгүйдэл	хувь	8.2	7.9	7.9	7.5	7,9

Оюу Толгойн зэс, алтны уурхай

Дэлхийн хамгийн том уурхайн нэг болох Оюу Толгой (ОТ)-н уурхайн ачаар Монгол улс дэлхийн зэс, алтны томоохон үйлдвэрлэгч болох замд явж байна. Энэ төслийг Монголын Засгийн газар (34%) болон Туркуаз Хилл Ресурс (THR) компани хамтран эзэмшдэг. Рио Тинто THR-ийн 50%-ийг эзэмшдэг ба төслийн менежерээр ажилладаг. Эхний үе шат болох ил уурхайн бүтээн байгуулалт 2010 онд эхэлж, 6 тэрбум гаруй америк долларын хөрөнгө оруулалт хийн, анхны бүтээгдэхүүнээ 2013 онд гаргасан. Хоёр дахь үе шат (ОТ-2)-нд 5 жилийн бүтээн байгуулалт хийж, 2021 он гэхэд гүний анхны бүтээгдэхүүнээ гаргаж, дараа нь 5-7 жилийн дотор бүрэн хүчин чадлаараа ажиллах төсөөлөлтэй байна.

ОТ-2 төслийг эхлүүлэх ажил Рио Тинто болон Засгийн газрын хооронд явагдаж байсан хэлэлцээнээс болж хойшлогдож байсан боловч 2015 оны 5 дугаар сард Засгийн газар, Рио Тинто 6 тэрбум долларын өртөгтэй ОТ-2 төслийг эхлүүлэх гэрээнд гарын үсэг зурсан болно. Тус гэрээгээр өмнө хийсэн аудитын мөрөөр ОТ-н хүлээх татварын тодорхой үүрэг, роялти төлбөрийн тооцоолол, өөр бусад асуудлыг шийдвэрлэжээ. Рио Тинто 2016 оны 5 дугаар сарын эхээр 2 дугаар үе шатны үйл ажиллагааг эцэслэн албан ёсоор баталсан бөгөөд 2016 оны 6 дугаар сарын байдлаар төслийн санхүүжилтын 4,3 тэрбум орчим долларын хөрөнгө босгож чадсан ба ирээдүйд шаардагдах нэмэлт санхүүжилтын 1,6 тэрбум долларын хөрөнгийн эх үүсвэрийг шийдэх боломжтой болжээ. ОТ-2 үе шат сэргэж эхэлснээр импортын татвар авах, ГШХО нэмэгдэх, төслийн үр нөлөө бодитойгоор гарч эхлэх үед хөрөнгө оруулалтын орчин, хэрэглэгчдийн итгэл сайжрах замаар төсвийн гүйцэтгэлд дэмжлэг болох хүлээлттэй байна.

Орон нутгийн нэмэлт ажлын байр (ОТ-д одоо 3,000 гаруй хүн ажиллаж байна) бий болох, орон нутгийн ханган нийлүүлэлт (үйлчилгээний компаниуд, хүнс ундааны ханган нийлүүлэгчид, уул уурхайн тоног төхөөрөмжийн гэрээт компаниуд, тээвэр, засвар үйлчилгээний операторууд)-ийн зарлага нэмэгдэх, орон сууц, нийтийн үйлчилгээнд компаний ажиллагсад хөрөнгө оруулах, мөн тээвэр, эрчим хүчний дэд бүтцэд хөрөнгө оруулах, Монгол даяар төслөөс хэрэгжүүлдэг уул уурхай, техникийн чиглэлийн их дээд сургууль, мэргэжлийн сургалт явуулах замаар хүний чадавхийг сайжруулах зэрэг эдийн засгийн нэмэлт ашиг тус бас ирэх болно.

2.3 Бүтцийн реформ хийх нөхцөл байдал

Тус орон Эдийн засгийг тогтворжуулах 4 жилийн төлөвлөгөө гаргасан, өмнө нь Төв Банкнаас төсвөөс гадуур хэрэгжүүлж байсан хөтөлбөрүүдийг тайлан тэнцэлд тусгах болсон зэрэг макро эдийн засгийн бодлогынхоо зарим аспектиудыг сайжруулах талаар ахиц дэвшил гаргасан боловч төсвийн позиц, засгийн газрын зээл болон мөнгөний бодлого зэрэг салбарт томоохон бүтцийн реформ хийх шаардлагатай байна. Бусад реформын дотор тус орон өөрийн төсвийн зарлагын бодлогоо өөрчилж, илүү тэнцвэртэй төсөвтэй болох, уул уурхайн салбараас орох орлогыг эдийн засгийн өсөлтийг хангах, тэсвэрлэх чадавхийг сайжруулахад зарцуулах стратеги боловсруулж ажиллах явдал орно.

Төв Банк 2016 оны 3 дугаар сард ипотекийн зарим хөрөнгийг, тухайлбал 2016 оны 2 дугаар сард байгуулсан Ирээдүйн тэтгэврийн нөөц сан (FPRF)-г Засгийн газрын балансад шилжүүлэн өгсөнийг УИХ-ын 2016 оны 40-р тогтоолоор Монголбанкинд буцаасан. Шилжүүлсэн хөрөнгө дотор орон сууцны ипотекийн зээлээр барьцаалсан бөгөөд төлбөрийг нь хийх шаардлагатай үнэт цаас, Төв Банкнаас бусад банкуудад олгосон бөгөөд сүүлийн 3 жилд татааст ипотекийн зээлийн хөтөлбөрөөр хугацааг нь сунгасан зээл орж байгаа юм. Ирээдүйн тэтгэврийн нөөц сан (FPRF)-гийн ипотекийн хөрөнгөнөөс гарсан бэлэн мөнгөний урсгалаас банкнаас анх бий болсон ипотекийн татааст шинэ зээлийг санхүүжүүлэх ба ирээдүйн тэтгэврийн төлбөрийг 2030 оноос дэмжих юм.

Тус орны уул уурхайн бодлого салбарын хөрөнгө оруулалт татах чадварыг сайжруулсан. Дээр дурдсанчлан, Засгийн газар болон Рио Тинто 2015 оны 3 дугаар сард 6 тэрбум долларын өртөгтэй Оюу Толгойн 2 дахь үе шатыг эхлүүлэх гэрээ байгуулж, үнэндээ 2013 оноос хойш зогсчихоод байсан төслийг дахин эхлүүлэх болсон. Тус гэрээнд өмнө хийсэн аудитын мөрөөр ОТ-н хүлээх татварын тодорхой үүрэг, роялти төлбөрийн тооцооллын асуудлыг шийдвэрлэжээ. Рио Тинто 2016 оны 5 дугаар сарын эхээр 2 дугаар үе шатны үйл ажиллагааг эцэслэн албан ёсоор баталсанаа зарласан бөгөөд 2016 оны 3 дугаар сард төслийн санхүүжилтын 4,3 тэрбум орчим долларын хөрөнгө босгож чадсан. Энэ нь олборлох салбарт хөрөнгө оруулах сонирхолтой гадаадын бусад хөрөнгө оруулагч нарт нааштай дохио өгч чадна. Нүүрсний бас нэг том уурхай болох, 4 тэрбум долларын үнэтэй Таван Толгойн асуудлаар яриа хэлэлцээ мөн явагдаж байна.

Олон улсын валютын сан (ОУВС) 440 сая ам.долларын Өргөтгөсөн санхүүжилтын хөтөлбөрийг 2017 оны 5 дугаар сард баталсан нь чухал болсон. Тус хөтөлбөрт төсвийн нэгдсэн байдал, мөнгөний бодлого, банкны салбарын реформ зэрэг нөхцлүүд орж байна. Дэлхийн Банк, АХБ зэрэг олон улсын санхүүгийн бусад байгууллага төсвийн дэмжлэг үзүүлэх зорилгоор нийт 5,5 тэрбум ам.долларын багц санхүүжилтын зээлийг хөнгөлөлттэй нөхцлөөр олгох хүлээлт байгаа. Эцсийн дүр зураг ямар гарахаас үл хамааран, Засгийн газар өргөн хүрээний реформ хийх хүсэл эрмэлзэлтэй байгаа нь харагдаж байна. Хөтөлбөрийн гол тэргүүлэх чиглэлүүд нь төсвийн алдагдлыг багасгах, төсвийн сахилга батыг сайжруулах зорилготой хараат бус Төсвийн Зөвлөл байгуулах явдал байх юм. Реформын бусад арга хэмжээ нь банкны системд төвлөрөх бөгөөд тэнд иж бүрэн оношилгоо хийж, шаардлагатай бүтцийн өөрчлөлт, хөрөнгийн дахин зузаатгал хийх болно. Эдгээр дээр нэмээд зохицуулалт, хяналтын хүрээг бэхжүүлэх, мөн хадгаламжийн даатгалын системийг сайжруулах, Мөнгө угаахын эсрэг, Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (AML/CFT) дэглэмийг чангатгах арга хэмжээ авах юм. Бас нэг гол тэргүүлэх зорилго бол Монгол Банкны эрх мэдлийг тодотгох, засаглалыг нь бэхжүүлэх, хараат бус байдлыг нь сайжруулах зорилготой шинэ хууль батлан гаргах явдал. Үнийн тогтвортой байдлыг хангах зорилгын үүднээс мөнгөний бодлого зохих түвшинд хатуу хэвээр байх ба валютын ханш хязгаарлагдмал интервенцийн хүрээнд уян хатан байсан хэвээр байх болно.

2.4 Санхүүжилт олох гарц

Хөрөнгийн хувийн хэвилийн эх үүсвэр

Банкны салбар нь Монголын санхүүгийн систем дэх хамгийн зонхилгогч тоглогч хэвээр байгаа бөгөөд нийт хөрөнгийн 95%-г эзэмшиж байна. Хамгийн том гурван банк банкны салбарын хөрөнгийн бараг 70%-г эзэмшиж байгаагаас харахад төвлөрөл

туйлын өндөр байна. Даатгалын компани, бичил санхүүгийн байгууллага, хуримтлал, зээлийн хоршоо зэрэг банк бус санхүүгийн байгууллагууд хөрөнгийн хэмжээгээрээ тун бага байр суурь эзэлж байна. Компанийн бондын зах зээл Монголд байхгүй бөгөөд ойрын ирээдүйд хөгжих хүлээлт ч алга байна. Учир нь, ихээхэн зээл авагч цөөн тооны компаниуд үндсэндээ банкнаас үйлчилгээ авдаг бөгөөд зээлдэгч, эсвэл хөрөнгө оруулагчдын зүгээс компанийн бондын зах зээл хөгжүүлэх эдийн засгийн хөшүүрэг одоогоор хязгаарлагдмал байна. Хувь хөрөнгийн зах зээл нь цөөн тооны хувьцаа борлуулах төдий бөгөөд нийт эдийн засагт санхүүжилт гаргахад чухал үүрэг гүйцэтгэхгүй байна. Монголын зах зээлд мөн урт хугацааны санхүүгийн эх үүсвэр байхгүй, учир нь урт хугацааны санхүүгийн бүтээгдэхүүнд хөрөнгө оруулах амьдралын даатгалын компани, тэтгэврийн сан зэрэг институцийн томоохон хөрөнгө оруулагч орж ирээгүй байна.

Олон талт, хоёр талын хөгжлийн банкны санхүүжилт ба Европын Холбоо

Азийн хөгжлийн банк (АХБ) нь 1991 оноос хойш Монголын олон талт, хөгжлийн хамгийн том түнш байсаар ирсэн бөгөөд өнгөрсөн 24 гаруй жилийн хугацаанд нийт 1,92 тэрбум америк долларын тусламж үзүүлсэн байна. АХБ-ны ердийн хөрөнгийн эх үүсвэр болох Азийн хөгжлийн сан болон бусад тусгай сангуудаас олгосон зээл, буцалтгүй тусламжийн нийт хэмжээ 1,1 тэрбум долларт хүрчээ. 2015 онд АХБ Монголд зориулсан тусламжаа нэмэгдүүлж, ажлын байр бий болгох, нийгмийн хамгаалал, уур амьсгалын өөрчлөлтөд төвлөрсөн 297,5 сая долларын тусламж шинээр баталжээ. Нийгмийн халамжийн хөтөлбөрүүд танагдахаас сэргийлж, АХБ 150 сая доллароор Нийгмийн халамжийг дэмжих хөтөлбөрийг санхүүжүүлжээ. Бас 50 сая долларын санхүүжилтыг Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төсөлд, 60 сая долларыг Зээлийн баталгааг дэмжих хөтөлбөрт тус тус өгчээ.

Монгол Улс 1991 оны 2 дугаар сард Дэлхийн Банк (ДБ)-ны группийн гишүүн болсон. Тэр цагаас хойш Дэлхийн Банк Монголд 808,17 сая америк долларын тусламж үзүүлжээ. 2016 оны 4 дүгээр сарын байдлаар, ДБ-ны Монгол дахь санхүүжилтын багц 188,14 сая доллар байсан ба үүнд ОУХА-гийн санхүүжилттэй 8 төсөлд 163,45 сая, 12 итгэмжийн сангийн 24,69 сая долларын санхүүжилт багтаж байна. Дэлхийн Банкны төслүүдийн дийлэнх нь дэд бүтцийн хөгжил, эдийн засгийн засаглал, уул уурхайн салбарын институцийн бэхжүүлэлтэд зориулагдсан байна. Дэлхийн Банк зээл, буцалтгүй тусламжаас гадна дүн шинжилгээ хийх, зөвлөгөө өгөх ажлыг Монголд хийж өгдөг бөгөөд энэ нь тус орны дунд, урт хугацааны хөгжлийн зорилтыг дэмжих, гол гол салбар дахь Засгийн газрын реформын стратегийг хэрэгжүүлэх чадавхи бий болгоход чиглэж байна.

Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК) нь өөрийн оффисоо 1997 онд Улаанбаатарт байгуулсан. Тэр цагаас хойш ОУСК 818 гаруй сая америк долларын хөрөнгө оруулалт босгож, хийсэн байна. Монгол дахь ОУСК-ийн стратеги нь ЕСБХБ-ныхтай төстэй бөгөөд Монголын санхүүгийн байгууллагууд, ялангуяа банкуудад хөрөнгө оруулах замаар ЖДҮ-ийн газруудад үйлчилж, санхүүжилтын гарцаар хангадаг. ОУСК нь компанийн засаглал, байгаль орчин, нийгмийн харилцааны олон улсын стандартуудыг хөхиүлэн дэмжиж, сэргээгдэх эрчим хүч, телеком, дунд орлоготой иргэдийн орон сууц зэрэг чухал дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийдэг. Мөн Монголд дэлхийн санхүүжилт, олон улсын технологи, байгаль орчны шилдэг практик нэвтрүүлэх зорилгоор дэлхийн түвшний тогтвортой уул уурхайн төслүүдийг дэмжиж ажилладаг. ОУСК уул уурхайн салбар дахь түншүүдтэйгээ хамтран Өмнөд Говийн цөл газар дахь усны менежментэд анхаарал хандуулах, стандарт нэвтрүүлэхийн төлөө

ажиллаж байна. Мөн агробизнес хөрөнгө оруулж, хүнсний аюулгүй байдлын стандартууд, өрсөлдөх чадварыг сайжруулах урт хугацааны реформыг дэмжиж байна.

Японы Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (ЖАЙКА) нь 1997 онд Монголын салбараа нээсэн. ЖАЙКА 1992 оноос хойш 620 сайн дурынхныг Монголд ажиллуулж, Монголын 4,000 гаруй техникийн ажилтнуудыг Японд дадлагажуулсан. ЖАЙКА нь Монголын хамгийн чухал хоёр талын хандивлагч бөгөөд 500 гаруй сая долларын урт хугацааны засгийн газрын зээл олгожээ. ЖАЙКА-гийн бодлого Үндэсний хөгжлийн төлөвлөгөөгөө зорилтот 3 ангилал, хөгжлийн 5 салбараар биелүүлэхэд нь Монголын Засгийн газарт туслах явдал юм. Энэ бодлого нь Японы Засгийн газраас 2012 оны 4 дүгээр сард зарлан эхлүүлсэн Монголд туслах шинэ чиглэлүүд хэмээх баримт бичигт тулгуурлаж байна. Тусламжийн тэргүүлэх чиглэлүүд дотор: 1) ашигт малтмалын нөөцийн салбарын тогтвортой хөгжил, илүү хүчтэй засаглал, 2) нийтийг хамарсан өсөлтийг дэмжих, болон 3) Төв хот суурин газрын хувьд Улаанбаатар хотын чадавхи, үйл ажиллагааг бэхжүүлэх, гэсэн асуудлууд орж байна.

Европын Холбооны урт хугацааны санхүүгийн байгууллага болох **Европын хөрөнгө оруулалтын банк (ЕХОБ)** болон Монгол Улс 1997 онд Суурь Хэлэлцээр байгуулсан бөгөөд түүний дагуу тус Банк Монголд санхүүжилт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаа явуулж байна. 2014 оноос хойш өдий хүртэл ЕХОБ 50 сая орчим еврогийн хөрөнгө оруулалт хийжээ. Тус Банк Улаанбаатар хотын гэр хороолол дахь хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд тээвэр, бохир усны шугам сүлжээ, эрчим хүчний дэд бүтцийн төслүүдэд гол төлөв төвлөрч ажиллаж ирлээ. ЕХОБ Сайншанд хотын орчимд байгуулах салхины эрчим хүчний станцын хөрөнгө оруулагч болохоор бэлтгэж байна.

Монгол нь 2006 оноос хойш **Европын Комиссын** хөгжлийн тусламжаас авах эрхтэй болсон. ЕХ болон Монголын хооронд 2013 онд гарын үсэг зурсан Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр нь худалдаа, хөгжил, хөдөө аж ахуй, эрчим хүчний салбар дахь хамтын ажиллагааг тодорхойлон гүнзгийрүүлж, үр дүнд нь 2014-2020 оны хугацаанд 85 сая еврогийн буцалтгүй тусламж үзүүлэхээр болсон байна. Үүний нэг хэсэг болох 9,3 сая еврогийн ЖДҮ-ийн хөгжлийн хөтөлбөрийг ЕСБХБ хэрэгжүүлж, жижиг зөвлөх үйлчилгээнээс эхлэн, дотоодын арилжааны банктай хамтарсан санхүүжилтын эрсдлийг багасгах зорилготой алдагдлын барьцаа хүртэлх төрөл бүрийн ЖДҮ-ийг дэмжиж ажилласан. Хамгийн сүүлийн нэг жишээ гэвэл, эдийн засгийн төрөлжүүлэлт, Эдийн засгийн тэгш өсөлтийн төслийг сайжруулахад чиглэсэн Худалдаанд хамаарах тусламж (TRAM)-ийн арга хэмжээ юм.

2.5 Бизнесийн орчин ба эрх зүйн нөхцөл байдал

Бизнесийн орчин

Монгол улс нь хувийн өмчийг хөхиүлэн дэмжих тал дээр харьцангуй өндөр түвшинд хүрсэн бөгөөд зах зээлийн гажуудал үүсэх нь боломжийн хэмжээнд бага байж ирсэн. Дэлхийн Банкны *Doing Business 2017* илтгэлд орсноор тус орон бизнес хийхэд хялбар байдлын эрэмбээр 190 орноос 64-т жагссан байна. Ялангуяа бизнес эхлүүлэх, барилгын зөвшөөрөл авах, цөөнх хөрөнгө оруулагчдыг хамгаалах, татвар төлөх зэрэг чиглэлд өндөр оноо авсан байна. Гэвч цахилгаан эрчим хүч авах, хил дамнасан худалдаа хийх зэрэгт доогуур үнэлгээ авсан нь нийлбэр дүнд сөргөөр нөлөөлжээ. *Doing Business 2017* илтгэлд дурдсанаар Монгол улс татварын бүртгэл, төлөлтийн цахим систем

нэвтрүүлсний үр дүнд татвар төлөлтийн оноогоо ихээхэн ахиулж, 73 дугаар байрнаас 35 дугаар байр луу дэвшжээ.

Дэлхийн Банк / ЕСБХБ-ны Бизнесийн орчин, компанийн гүйцэтгэлийн тойм судалгаа (BEEPS V)-гаар Монголын компаниудын нэрлэсэн бизнес орчны топ гурван саад тотгорт санхүүжилт олох гарц, албан бус сектор дахь өрсөлдөгчдийн үйл ажиллагаа, цахилгаан хангамжийн асуудлууд оржээ. Хэдийгээр банкны зээлтэй компанийн тоо харьцангуй өндөр (48,1%) бөгөөд Төв Азийн болон BEEPS V судалгааны дунджаас дээгүүр байгаа боловч санхүүжилт олох гарц хамгийн өндөр саад тотгор хэвээр байсан байна. Гэхдээ, зээлийн хэрэгцээтэй компаниуд дотроос ЖДҮ-ийн 46,8%, шинэ тулгар компаниудын 65,0% нь зээл авахад хүндрэлтэй, өөрөөр хэлбэл зээл авах хүсэлт гаргах урамгүй болсон, эсвэл хүсэлтийг нь буцаасан байна. Сүүлийн үед олгосон бараг бүхий л зээлд (99,5%-д) баталгаа шаардсан байсан нь BEEPS судалгааны орнууд дотор хамгийн өндөрт орсон байна. Газар олж авах гарц нь ЖДҮ, шинэ тулгар компани болон үйлдвэрийн газрын хувьд бас хамгийн том саад тотгорын нэг байсан бөгөөд том компаниудын хувьд ажиллах хүчний ур чадвар, коррупци санаа зовоосон асуудал байлаа. Транспаренси Интернэшнль байгууллагын 2016 оны Авилгалын индексээр Монгол Улс 168 орноос 87-д эрэмблэгдсэн байна.

Институцийн хүч чадал сул бөгөөд Дэлхийн Банкны *Worldwide Governance Indicators* судалгаагаар тус орон засгийн газрын үр дүнт ажиллагаа, авилгалын хяналт, хуулийн засаглал гэсэн үзүүлэлтээр хамгийн доод 25%-д орсон байна. Компанийн засаглал, бизнесээ авч явах байдлын стандартын хувьд дутуу дулимаг зүйл оршсоор байгаа бөгөөд нүүрсхүчлийн хийн нягтралын түвшин өндөр байсаар байна. Уул уурхайн салбарт төрийн өмчийн хувь хэмжээг тойрсон асуудлууд, төр болон хувийн хэвшлийн хооронд эрсдэл, ашиг орлогыг хуваарилах журам, мөн татварын дэглэм бүгд өөрчлөгдөх, тодорхойгүй байх явдал гарсаар ирсэн байна.

Хууль эрхзүйн нөхцөл байдал

Монгол Улс сүүлийн жилүүдэд бизнесийн хууль эрхзүйн хүрээг сайжруулахад чиглэсэн хэд хэдэн шинэ хууль батлан гаргасан. Гэсэн хэдий боловч хэд хэдэн гол чиглэлээр томоохон реформ хийх шаардлага байсаар байна. ЕСБХБ-ны Компанийн засаглалын үнэлгээ (2015)-нд цохон тэмдэглэснээр авч үзсэн дийлэнх чиглэлд хийвэл зохилтой реформын хүрээг гаргаж өгсөн. Мөн адил, Монголын дампуурлын хууль тогтоомж нь нарийвчилсан заалт, журмын асуудлаар туйлын ядмаг, дампуурал нь компанийнг шинэчлэн байгуулах нэг арга хэрэгсэл болохыг таниулсан цогц реформ хийх шаардлагатай болсон байна. Нөгөө талаар, хөдлөх хөрөнгийн чадавхийн асуудлаар шинэ хууль батлан гаргаснаар санхүүжилт олох гарцтай холбоотой хууль тогтоомж ихээхэн сайжирсан бөгөөд ялангуяа ЖДҮ-т зээл олгох ажлыг хөнгөвчлөх боломжтой болжээ. Гэвч, өр авлагыг (гуравдагч этгээдэд) дамжуулан арилжих (факторинг) тухай хууль (factoring law)-ийн талаар ЕСБХБ-ны үйл ажиллагааны орнуудад хийсэн судалгаа (2016)-наас үзэхэд Монголд тийм хуулийн институцийн болон хууль эрхзүйн хүрээг шинэчлэн сайжруулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

2015 онд Монголын парламент Эрчим хүчний тухай болон Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль батлан гаргасан. Эдгээр хууль нь эрчим хүчний салбарт илүү арилжааны чиглэлээр хандах байдлыг нэвтрүүлэхэд чиглэжээ. Реформын арга хэмжээнүүд дотор үндсэн хураамжийн тариф болон үйлдвэрлэлийн дундаж зардлын хоорондын зөрүүг нөхөх зорилготойгоор эцсийн хэрэглэгчээр авах тусгай «дэмжлэгийн үнэ тариф»

нэвтрүүлэх ажил оржээ. Нэмэлт өөрчлөлт оруулсан хуулиар, цахилгаан эрчим хүч худалдан авах гэрээний хүчинтэй байх хугацааг хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн график хугацаатай нийцүүлэн тогтоохоор мөн заасан байна. Удаан хүлээгдсэн Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийг 2015 оны 11 дүгээр сард баталлаа. Шинэ хуулинд чухал чухал заалтууд орсны дотор эрчим хүчний аудиторуд, эрчим хүчний үйлчилгээний компаниуд, эрчим хүчний хэмнэлтийн менежерүүдийн үйл ажиллагааны үндсийг тавьсан заалт байгаа бөгөөд мөн эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд ногдуулах торгууль шийтгэлийг зааж өгчээ. Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль нь эрчим хүчний аудит хийлгэх, эрчим хүч хэмнэх арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлэх, хуулийн хэрэгжилтийн талаар Эрчим хүчний хэмнэлтийн зөвлөлд тайлагнах тодорхой хэрэглэгчдийн үүргийг зааж өгсөн байна.

Концессийн тухай 2010 оны хуулийг батлах үед Монгол улс Төр, хувийн хэвшлийн түншлэл (PPP – ТХХТ) / концессийн төслүүдийн талаар бараг туршлагагүй байлаа. Хүлээгдэж байгаа төслүүдийн тоо нэмэгдэж байгаа болон институцийн өөрчлөлт байн байн хийгдэж байгаа нөхцөлд ТХХТ-ийн хууль эрхзүйн хүрээг цаашид улам хөгжүүлэх, ТХХТ/концессийн төслүүдийг хэрэгжүүлэх Засгийн газрын чадавхийг бэхжүүлэх шаардлага байсаар байна.

Монголын Засгийн газар шүүх салбарын 2016-2020 онуудын тэргүүлэх зорилтуудыг мөн тодорхойлсон байна. Тухайлбал, маргаан таслах хууль эрхзүйн хүрээг сайжруулах, түүний дотор шүүгчдийг сонгон шалгаруулах процесс, шүүхийн шийдвэрийн чанарыг сайжруулах үүднээс Шүүхээр иргэний хэргийг шийдвэрлэх тухай, Арбитрын тухай хуулиудыг хянан үзэх, мөн Шүүхийн захиргааны тухай хуулийг хянан үзэх асуудлууд тусгагдсан байна.

Төрийн худалдан авалтын тухай хуулийг шинэчлэх, ялангуяа одоогийн шилдэг практик, олон улсын зохицуулалтын стандартууд, тухайлбал Дэлхийн худалдааны байгууллагын Засгийн газрын худалдан авалтын тухай 2012 оны Хэлэлцээр (WTO GPA)-тэй нийцүүлэн шинэчлэх шаардлагатай. Энэ чиглэлд салбарын цогц реформ хийх, ялангуяа өрсөлдөөн, ил тод байдлын зарчмуудыг хэрэгжүүлэх шаардлага байна. Худалдан авалтын шийдвэр гаргах процессыг илүү хариуцлагатай болгохыг зөвлөж байна. Бас процедурыг хялбаршуулах, төрийн худалдан авалт дахь хяналт шалгалт хийх, засаж залруулах шударга процедур тогтоох зорилгоор төрийн худалдан авалтыг хянан үзэх системд реформ хийх шаардлагатай байна.

Хэдийгээр цахилгаан холбооны салбар дахь бүрэн үр нөлөөтэй өрсөлдөөнийг хангасан нийтлэг заалтууд холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд тусгагдаагүй байж болох (жишээлбэл, эрх олгох ерөнхий дэглэм байхгүй, байгууламж хуваалцах боломж, дэд бүтэц ашиглах гарц, шугам сүлжээ тавих эрхийн ойлголт тодорхойгүй) боловч, цахилгаан холбооны зах зээл ерөнхийдээ өрсөлдөөний үндсэн дээр, бүхий л гол дэд салбарууддаа тодорхой хэмжээний өрсөлдөөнтэй байдлаар явж байна.

2.6 Нийгмийн нөхцөл байдал

Монгол Улс НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн 2015 оны Хүний хөгжлийн индекс (HDI)-ээр 188 орноос 90 дэх байранд эрэмблэгдэж байгаа бөгөөд энэ нь «хүний хөгжлийн өндөр түвшин»-тэй орнуудын ангилалд орж байгаа юм. Төв Азидаа бол Казахстан (56 дугаар байр)-ы дараа хоёрт орж, бусад орон (Туркменистан 109, Узбекистан 114, Кыргызстан 120, Тажикистан 129)-оос бол дээгүүр жагсаж байна. 1980-аад оноос хойш

Монгол улс хүний хөгжлөөр ихээхэн сайжирсан бөгөөд Хятадтай ойролцоо хурдтай хөгжсөн байна. Хүний дундаж наслалт нэмэгдсэн (1990 онд 60 байсан бол 2014 онд 69,5 болсон), сургууль сурах боломжит жилүүдийн тоо 14,6 жил болсон зэрэг нь үүнийг нотолж байна.

Дэлхийн эдийн засгийн форумын Өрсөлдөх чадварын индексээр Монгол Улс 140 орноос 104-т жагсаж байгаа бөгөөд энэ нь хүний хөгжлийн холбоотой өндөр үзүүлэлтүүд (жишээ нь, дээд боловсрол, сургалтаар 62-т, эрүүл мэнд, бага боловсролоор 69-т, хөдөлмөрийн зах зээлийн ашигт ажиллагаагаар 41-д)-тэй нь харьцуулбал мэдэгдэхүйц ялгаатай байгаа юм. Үүнээс үзвэл, бүтцийн асуудлууд нь өрсөлдөх чадварт хамгийн их сорилт тулгаж буй нь харагдаж байна. Боловсролд зарцуулсан нийтийн зарлага 2011 онд төрийн нийт зарлагын 12,15% байсан бөгөөд ДНБ дэх боловсролын зарлагын хувь хэмжээ 5,5% байжээ. Боловсролын тогтолцоо тоо хэмжээний хувьд дээрхээс үүдэн өссөн боловч залуу хүмүүсийн сургуулиас ажил руу шилжих байдал улам их асуудал болсон байна. Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO)-ын судалгаагаар, Монгол дахь залуучуудын ажилгүйдэл 2015 онд 14,7%-д хүрсэн (насанд хүрэгчдийн дундах ажилгүйдэл 5,9% байхад) байна. 2013 онд, Монголын 15-29 насны залуучуудын тавны нэг гаруй нь ажил эрхлэлт, боловсрол, сургалт (NEET)-ын алинд нь ч хамрагдаагүй байжээ. Гэхдээ энэ үзүүлэлт нь Төв Азийн бусад оронтой харьцуулахад бага байсан байна. Залуучуудын идэвхгүй байдал нь ялангуяа аймгийн төвүүдэд өндөр байгаа бөгөөд улсын дунджаар 21,1% байгаа энэ үзүүлэлт аймгийн төвүүдэд 27,1% байна.

Бүс нутгуудын хөгжлийн ихээхэн ялгаа байсаар байна. Монгол улс бол дэлхийн хүн амын нягтрал хамгийн багатай орон бөгөөд 3 сая хүн амынх нь 40% нь нийслэл Улаанбаатар хотод суурьшсан. Ядуурлын түвшин хөдөө орон нутагт (22,2%) хот суурин газрынхаас (2,8%) 8 дахин өндөр байна. Үйлчилгээ, түүний дотор ус хангамж, дулаан хангамж, мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц, боловсролд хамрагдах боломж бүс нутгуудын хооронд өндөр ялгаатай байна. Цахилгаан эрчим хүчний хүртээмж, хил дамнасан худалдааны дэд бүтэц хөгжөөгүй байдал нь бизнес хийхэд учирч буй гол саад тоггор гэж тодорхойлсон байна.

Ажиллах хүчин дэх Монголын эмэгтэйчүүдийн оролцооны хувь хэмжээ харьцангуй өндөр буюу 60% орчим байгаа боловч эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүд ажилгүйдэл болон хагас ажилгүйдэлд нэрвэгдэх нь илүү байна. Үүнд ажиллах хүчин дэх хүйсийн тсугаарлалт, төрөлжилт ихээхэн нөлөөлж байна. Эмэгтэйчүүд эдийн засгийн бага бүтээмжтэй салбарт болон хариуцлага багатай, орлого, байр суурь доогуур мэргэжлийн ажилд зонхилон ажиллаж, ахиж дэвших боломж ихтэй, цалин өндөртэй уул уурхай, тээвэр, эрчим хүч зэрэг салбар, мөн менежер, техникийн мэргэжлийн ажилд бага төлөөлөлтэй байна. Мөн цалингийн хүйсийн ялгаа улам ихсэж байгаа бөгөөд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 14,3%-иар бага цалин авч байна. Ажил хөдөлмөрийн «уламжлалт бус» гэх чиглэлийн тухай өргөн тархсан нийгмийн хэм хэмжээ, мөн гэр орон, хүүхдээ харж хандах үүрэг хариуцлага нь албан ёсны хөдөлмөрийн зах зээл дээр гарах тэгш боломжийг нь үгүй хийж байдаг гэр бүл доторхи эмэгтэйчүүдийн дорд байр суурь амь бөх оршсоор байна. Хүйсийн ялгавартай, тэгш бус байдал хот суурин газраас хөдөө орон нутагт илүү илрэх хандлагатай байна. Хэдийгээр санхүүгийн албан ёсны үйлчилгээ авах асуудал дээр хүйсийн ялгаа гарч байгаа тухай мэдээлэл байхгүй боловч баталгаа гаргах боломж байхгүй байгаа нь зээл авахад үүсч буй хүндрэл хэвээр байна. Нас баралтын хувь хэмжээ, эрүүл мэндийн

асуудал ялангуяа эрэгтэйчүүдийн дунд өндөр байгаа бөгөөд энэ нь архи, тамхины хэт их хэрэглээтэй холбоотой нь тодорхой.

2.7 Ногоон эдийн засагт шилжих нь

Монгол улс эрчим хүчний хувьд өндөр эрчимтэй эдийн засаг байсаар байгаа бөгөөд хэрэгцээ нь хурдан өсч байна. ЕСБХБ-ны үйл ажиллагааны орнуудтай харьцуулбал нэг хүн амд ногдох эрчим хүчний дундаж нягтрал нь хоёр дахин, нүүрстөрөгчийн нягтрал нь гурав дахин их байгаа бөгөөд энэ нь Европын Холбооны 28 орны дунджаас 4 болон 5 дахин тус тус өндөр байгаа юм. Анхан шатны эрчим хүчний нийт нийлүүлэлтийн 90 гаруй хувийг нь нүүрс, нефть гаргаж байгаа бөгөөд цахилгаан эрчим хүч, дулаан хангамжийн дийлэнхийг нь сэргээн засварлах, хөрөнгө оруулалт хийх ихээхэн шаардлагатай болсон, насжилт өндөртэй нүүрсний станцууд үйлдвэрлэж байна.

ЕСБХБ өөрийн Ногоон эдийн засгийн шилжилт (GET) бодлогын хүрээнд өнөөг хүртэл 114 сая еврогийн төслүүдийг санхүүжүүлсэн. Сэргээгдэх эрчим хүчний төслүүд нийт үнийн дүнгийн тал гаруй хувийг эзэлж байгаа бөгөөд дараа нь компанийн эрчим хүчний хэмнэлтийн төслүүд (25%) орж байна. Тус Банк тогтвортой эрчим хүчний санхүүжилтын зээлийн анхны шугам болох Монголын тогтвортой эрчим хүчний санхүүжилтын хөтөлбөр (MonSEFF)-ийг 2014 онд эхлүүлсэн бөгөөд энэ нь дотоодын зуучлагч банкуудаар дамжуулан, эрчим хүчний хэрэглээ ихтэй уул уурхай зэрэг томоохон үйлдвэрүүдийн эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээнүүд дэх хөрөнгө оруулалтыг дэмжих зорилготой юм.

Монголын нийт цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл дэх сэргээгдэх эрчим хүчний хувь хэмжээ 3-4%-д дөхөж очиж байгаа (салхиных 2-3%, усан цахилгаан үйлдвэрлэл 1%) ба суурилуулсан хүчин чадлын 8%, үүний дийлэнхийг салхин цахилгаан станц (5%), усан цахилгаан станц (3%) тус тус эзэлж байна. Монголд цаашид сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх боломж, түүний дотор нарны эрчим хүчний нөөц их байна. 2007 онд Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль батлан гаргаснаас хойш Засгийн газар эрчим хүч болон сэргээгдэх эрчим хүчний хуулиудын аль алинд нэмэлт өөрчлөлт оруулж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс цахилгаан үйлдвэрлэх зардлыг нөхөх зорилготой «дэмжлэгийн тариф» нэвтрүүлсэн байна. Монгол улс Үндэсний сэргээгдэх эрчим хүчний хөтөлбөртөө сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн суурилуулсан хүчин чадлыг 2023 он гэхэд 20%-д хүргэх зорилт тавьжээ. Өнөөдөр Монгол улсад ЕСБХБ-ны санхүүжүүлсэн тус бүр 50 мегаваттын хүчин чадалтай 2 салхин цахилгаан станц байна. Энэ нь Салхит (2013 оноос ажиллаж байгаа) болон Цэций (байгуулж байгаа) юм. Одоогийн цахилгаан шугам сүлжээний хүчин чадал улам хурдан өсөн нэмэгдэж байгаа сэргээгдэх эрчим хүч, ялангуяа салхин цахилгаан үйлдвэрлэлийн нийлүүлэлтийг даах эсэх асуудал яригдаж байгаа.

Хөрөнгө оруулалт дутмаг учир Монголын хот суурин газрууд дахь дэд бүтцийн байдал сул дорой хэвээр байна. Гэр хороолол зэрэг зарим бүс дүүрэг төвийн халаалт зэрэг нийтийн үйлчилгээнд холбогдоогүй байгаа бөгөөд энэ нь эдгээр наад захын хэрэгцээг хангах талаар яаралтай шийдэл олохыг шаардаж байна.

Монгол улс уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хүнд сорилттой тулгарч байгаа бөгөөд усны нөөц, хүрэлцээ томоохон асуудал болоод байгаа орон юм. Өнгөрсөн хагас зууны хугацаанд агаарын дундаж температур Цельсийн 2 хэмээр нэмэгдэж, улмаар бороо хур тунадасны тархалт өөрчлөгдөн, цөлжилт газар авч байна. Хуурай цаг

агаарын нөхцөл байдал даамжирч, тэр нь ялангуяа нийт усны хэрэглээний 44 хувь (дараа нь 43%-ийг хэрэглэдэг аж үйлдвэр орно)-ийг эзэлдэг хөдөө аж ахуйн салбарт (мал аж ахуй болон газар тариалан) байгаль орчин, нийгэм-эдийн засгийн онцгой сөрөг нөлөө үзүүлж болохыг судалгаа, тооцоолол харуулж байна. Уур амьсгалын өөрчлөлтийг тэсэн гарах улс орны чадварыг бэхжүүлэхийн тулд газар ашиглалтын илүү сайн практик, усжуулалтын болон усны менежментийн сайн систем, мөн уур амьсгалын технологиудыг өргөн нэвтрүүлэх шаардлагатай. Хот суурин газрын ус хангамж, бохир ус цэвэршүүлэх дэд бүтцүүд хоцрогдсон хэвээр байгаа бөгөөд усаар дамжих өвчлөл зэрэг эрүүл мэндийн эрсдэл хүн амд учруулж байна.

Global Material Flows Database² (Дэлхийн орц материалын урсгалын өгөгдлийн сан)-д дурдсанаар, Монголын материаллаг үйлдвэрлэлийн хөдөлмөрийн бүтээмж (орц материал дутамд гаргаж байгаа эдийн засгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл) 2010 оны байлдаар дэлхийд хамгийн доод түвшинд эрэмбэлэгджээ. Нөөц эх үүсвэр хэмнэх, эсвэл хаягдал багасгах үндэсний зорилт тавиагүй байна. Харин Улаанбаатар хотын хаягдлын менежментийн хөтөлбөрийг 2013 онд баталж, түүндээ гол төлөв айл өрхийн хаягдлыг цуглуулах, дахин боловсруулах тоон зорилтууд тавьжээ. Ерөнхийд нь хаягдал үйлдвэрлэх, боловсруулах талаар салбар салбарын мэдээлэл гаргах найдвартай систем байхгүй. Харин уул уурхайн салбар хаягдлын дийлэнх хэсгийг үйлдвэрлэдэг гэсэн ойлголт байдаг. Монгол улсын парламент Айл өрх, үйлдвэрийн газрын хаягдлын тухай хууль, Аюултай, хортой химийн бодисын тухай хуулийг нэгтгэсэн Хаягдлын тухай хуулийг 2012 онд гаргасан ба 2016 онд хаягдлын менежментийн олон улсын бодлогыг тусгасан өөрчлөлт хийсэн байна. Гэвч аж үйлдвэр, орон нутгийн хот суурин газрын хатуу хаягдлын менежментийг хариуцах ёстой орон нутгийн засаг захиргаанд хүн хүч, санхүүгийн нөөц, мөн холбогдох технологи, мэдлэг туршлага ихээхэн дутмаг байна. Хаягдал тээвэрлэхээс бусад тохиолдолд хувийн хэвшлийн оролцоо огт байхгүй байна. Хортой хаягдлыг айл өрхийн хаягдалтай хамт ил задгай газар хаяж, булж булшилж байна. Олон тохиолдолд, тийм хаягдлыг шаардлага хангаагүй нөхцөлд хадгалж, улмаар байгаль орчин, эрүүл мэндийн ноцтой хохирол учруулж байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хүсэлтээр ЕСБХБ одоо Монгол дахь хорт хаягдлын менежментийн чиглэлд техник тусалцаа үзүүлэх судалгаа хийж байна.

Монгол улс, ялангуяа Улаанбаатар хот бол дэлхийн хамгийн муу агаарын чанартай газрын нэг бөгөөд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тогтоосон тоосонцор (түүний дотор нарийн тоосонцор)-ын стандартаас PM10-ын түвшин 16 гаруй дахин, PM2.5-ын түвшин 3 дахин тус тус их байна. Дэлхийн Банкны 2011 оны «Улаанбаатар хотын агаарын чанарын дүн шинжилгээ, эрүүл мэндийн нөлөөллийн багасгах зорилгоор агаарын чанарыг сайжруулах нь» судалгаанд, агаарын ийм бохирдлын үр дүнд уушиг, зүрхний өвчлөлийн улмаас мянга мянган хүн нас барж, эмнэлэгт хэвтсэний уршгаар Улаанбаатар хотын ДНБ-ны тавны нэг орчимтой тэнцэх хохирол учруулах тооцоо хийсэн байна. PM бодисын өндөр нягтрал нь өргөн тархсан гэр хорооллын зуухнаас гол төлөв үүсдэг бөгөөд дараа нь салхинаас үүдсэн тоос, автомашин, халаалтын бойлороос үүдсэн шаталтын хаягдал, замын тоос, утааны тоосонцор нөлөөлж байна. Банкны хувьд Монгол улсад учирч буй байгаль орчны сорилт, боломжуудыг 3.4 хэсэгт илүү тодорхой тайлбарласан байгаа.

Монгол улс Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц (UNFCCC)-д Монголын оруулах хувь нэмрийн талаархи илтгэл ((INDC)-ээ 2015 оны 9 дүгээр сард

² Vienna University of Economics and Business (WU), www.materialflows.net

илгээсэн бөгөөд Парисын Хэлэлцээрийг 2016 оны 9 дүгээр сарын 21-нд соёрхон баталсан юм. Парламентаар баталсан Үндэсний хувь нэмэр (INDC) баримт бичигт дурдсанаар 2030 он гэхэд хорт бодис ялгаруулалтын хэмжээг ердийнхөөс 14 хувиар бууруулах зорилт тавьсан бөгөөд түүний зардал нь 3,5 тэрбум америк доллар болно гэж тооцоолжээ. Монголын INDC баримт бичгийн концепцийн эх суурь нь 2014 онд баталсан Засгийн газрын Ногоон хөгжлийн бодлого бөгөөд парламентаар 2011 онд баталсан Уур амьсгалын өөрчлөлтийн талаархи үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө (NAPCC) бас хувь нэмэр болсон байна.

3 СТРАТЕГИЙН ЧИГ БАРИМЖАА

3.1 Стратегийн чиглэлүүд

Монгол улс шилжилтийн эхэн үедээ яваа орон бөгөөд байгалийн баялаг ихтэй боловч олборлох салбараас бусад салбарт хувийн хэвшил нь дөнгөж үүсэн бий болж байгаа билээ. Эдийн засаг нь Хятадтай нягт холбогдсон, түүхий эдийн үнийн өсөлт, уналтын мөчлөгөөс гүнзгий хамааралтай юм. Тиймээс улс орны ашигт малтмалын ихээхэн баялгийг ил тод удирдан зохицуулах, үүний зэрэгцээ илүү тэсвэртэй, төрөлжсөн, өрсөлдөх чадвартай эдийн засагт хүрэх бодлогоо тодорхойлох явдал урт хугацааны хөгжлийн ирээдүйд нь амин чухал болоод байна. Ханган нийлүүлэлтийн гинжин сүлжээг сайжруулах, тогтвортой тээвэр, хотын дэд бүтцийг хөгжүүлэх, олборлох үйлдвэрлэлийн дотор болон гадна талд сайн засаглалыг хөхиүлэн дэмжих зэрэг нь бүгд илүү их хөрөнгө оруулалт татах, хувийн хэвшлийн хөгжлийг түргэтгэхэд хэрэгтэй. Тус орон дахь хамгийн том хөрөнгө оруулагчийн хувьд ЕСБХБ нь байгалийн баялгаа үнэ өртөг илүүтэй болгох, эдийн засгаа илүү тэсвэртэй болгох, өргөн хүрээтэй, бүгдэд хүртээмжтэй өсөлт бий болгоход нь Монгол улсад туслах боломж ихтэй юм. Энэ зорилгоор тус Банк олборлох бус салбаруудын өрсөлдөх чадвар, үр ашгийг бүхий л шатанд (менежмент, үйл ажиллагаа, байгаль орчин, ложистик) нэмэгдүүлэх, бие даасан техник хамтын ажиллагаанаас өгсүүлээд шууд санхүүжилт хийх хүртэлх өөрийн олон хэрэгсэлт боломжоо ашиглахад төвлөрөн ажиллаж, эдийн засгийн тэсвэрлэх чадварыг дэмжиж ажиллана. Мөн Монголын бүс нутгуудыг жигд хөгжүүлэх явдлыг хангах зорилгоор хөрөнгө оруулалтыг ашиглах боломжийг хайж ажиллах болно.

Энэ хүрээнд, дараагийн стратегийн хугацаанд Монгол улстай хамтран ажиллах тус Банкны үйл ажиллагааны удирдамж болгож, дорхи стратегийн сэдвүүдийг санал болгож байна. Үүнд:

- **Сэдэв 1: Олборлох бус салбаруудын өрсөлдөх чадварыг сайжруулах, санхүүжилт олох гарцыг хялбаршуулах замаар Монголын тэсвэрлэх чадварыг бэхжүүлэх:** Монголын (бүс нутагтаа хамгийн сайны нэг) хөрөнгө оруулалтын орчин инноваци, энтрепренёр чадвараас хамаарах боловч эдийн засгийн дийлэнхэд нь бага үнэ өртөг нэмсэн, боловсруулаагүй ашигт малтмал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн ноёлсон хэвээр байгаа нь гадаад шок, түүхийн эдийн үнийн мөчлөгт туйлын эмзэг болгож байна. Компанийн засаглал, бизнес үйл хөдлөлийн стандарт доогуур, үнэ өртөг нэмэх гинжин сүлжээ сул хөгжсөн, хөдөө аж ахуйн салбар муу чанар, ариун цэврийн ядуу стандартаас болж хөгжихгүй байна. Ийм нөхцөл байдалд тус Банк Монголын эдийн засгийн суурийг өргөжүүлж, эдийн засгийг нь илүү өрсөлдөх чадвартай, тэсвэртэй болгохыг дэмжих үүднээс олборлох бус салбарыг дэмжиж ажиллахыг эрмэлзэх болно. Ялангуяа орон нутгийн компани,

ЖДҮ-ийн өрсөлдөх чадварыг сайжруулж, инновацийг хөхиүлэн дэмжсэн, ажлын ур чадварт сургасан, компанийн засаглалыг сайжруулсан төслүүдийг санхүүжүүлэн, агробизнес, барилгын материал, хөнгөн үйлдвэр, үйлчилгээний салбарт илүүтэй анхаарч ажиллана. Мөн тус Банк зорилтот зээлийн шугам, эрсдэл хуваалцах механизмаар түнш банкуудаа үргэлжлүүлэн хангах, ЖДҮ, үнэ өртөг нэмсэн гинжин сүлжээ, эрчим хүчний хэмнэлтэд төвлөрөн анхаарах замаар ялангуяа үндэсний валютаар санхүүжилт олох гарцыг сайжруулахад дэмжлэг үзүүлж ажиллах болно.

- **Сэдэв 2: Тогтвортой байдлыг бэхжүүлэх, үнэ өртөг нэмэх ажлыг дээд хэмжээнд хүргэхэд сайн засаглалтай уул уурхайн салбарыг ашиглах:** Өргөтгөх, олборлох томоохон төслүүдийг хэрэгжүүлэх нь ирж буй жилүүдэд эдийн засгийн өсөлтийг хангах гол хөдөлгөгч хүч болох юм. Гэвч тухайн салбарт цаашид реформ хийх, хөрөнгө оруулах шаардлагатай бөгөөд ингэснээр үнэ өртөг шинээр бий болгох, тогтвортой, хүн бүрт хүртээмжтэй өсөлт гаргах явдлыг хангаж чадна. Уул уурхайн салбарын төслүүдийг үр дүнтэй хэрэгжүүлснээр мөн уул уурхайтай ханган нийлүүлэлтийн гинжин сүлжээгээр холбогдсон дотоодын үйлдвэрүүдийн өрсөлдөх чадвар, үнэ өртөг нэмсэн агуулгыг нэмэгдүүлэх боломж гарах юм. Тиймээс тус Банк хариуцлагатай уул уурхайг ялангуяа хөрөнгө оруулалтаар дэмжиж ажиллахаа үргэлжлүүлж, доороос дээш хандсан санхүүжилт (үнэ өртөг нэмэх гинжин сүлжээ, факторинг аль алиных нь) болон дээрээс доошоо чиглэсэн боловсруулалт хийх замаар үнэ өртөг нэмэх гинжин сүлжээний боломжуудыг бий болгохыг эрмэлзэж ажиллах болно.
- **Сэдэв 3: Үр ашгийг нэмэгдүүлэх, арилжааны хэлбэрт оруулах, «ногоон» шийдэл олох замаар дэд бүтцийн үйлчилгээний чанар, тогтвортой байдлыг сайжруулах:** Монгол дахь дэд бүтцийг шинэчлэх, улам хөгжүүлэх нь уул уурхай, бусад салбарийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах, ашигт малтмалын экспортыг хөнгөвчлөх, олборлох бус салбарын хөгжлийг дэмжихэд амин чухал ач холбогдолтой. Тээвэр, хотын болон эрчим хүчний дэд бүтэц бүгд сул хөгжсөн хэвээр байгаа бөгөөд эрх зүй, зохицуулалтын хүрээ сул, төрийн өмчийн компаниуд давамгайлсан боловч үр ашиггүй, үнэ тариф бага тогтоогдсон, хувийн хэвшлийн оролцоо хязгаарлагдмал байна. Тус Банк Улаанбаатар хот зэрэг зээлжих чадвартай субъектуудад засгийн газрын шууд болон дамжуулсан зээл хүргэх бүтэц бий болгохын төлөө ажиллана. Хоёрдугаар зэрэглэлийн хотуудын дэд бүтцийг санхүүжүүлэх ажил засгийн газрын баталгаа шаардсан хэвээр байх ба засгийн газрын зээл авах орон зай байгаа эсэхээс хамаарна. Тус Банк мөн төмөр зам болон авто замын төслүүдээр дамжуулан бүс нутаг дахь хэлхээ холбоо, интеграцийг сайжруулж, хамгийн сүүлийн үеийн технологи, сэргээгдэх (нар, салхи) эрчим хүч нэвтрүүлэх зорилгоор эрчим хүчний салбар дахь ТХХТ (PPP)-ийг дэмжин ажиллахыг эрмэлзэнэ.

3.2 Гол гол сорилтууд ба Банкны үйл ажиллагаа

Сэдэв 1: Олборлох бус салбаруудын өрсөлдөх чадварыг сайжруулах, санхүүжилт олох гарцыг хялбаршуулах замаар Монголын тэсвэрлэх чадварыг бэхжүүлэх:

Шилжилтийн сорилтууд

- Тус орны эдийн засаг олборлох үйлдвэрийн хувь хэмжээ өндөр байдгаас үнийн өсөлт, уналтын мөчлөгт эмзэг хэвээр байгаагийн зэрэгцээ шинэ ажлын байр гол төлөв бусад салбар, түүний дотор үйлчилгээний салбарт бий болж байна. Ашигт малтмал нийт экспортын 80 орчим хувийг эзэлж, үндсэндээ Хятад руу гарч байна. Үндсэндээ, экспортын зах зээлийг илүү өргөжүүлэн төрөлжүүлэх шаардлагатай болжээ.
- Хувийн үйлдвэр, аж ахуйн газрын бизнесийн орчныг цаашид улам сайжруулах шаардлагатай бөгөөд ялангуяа олборлох бус салбарын компанийн засаглал, бизнесийн үйл хөдлөл дээр анхаарах хэрэгтэй. БЖДҮ-ийн газрууд аж үйлдвэр, үйлчилгээний салбарт шинээр орж ажиллах, гарч явахыг дэмжих үүднээс төрийн захиргааны чадавхи, шүүхийн байгууллагыг бэхжүүлэх шаардлагатай.
- Компанийн хөдөлмөрийн бүтээмж, үр ашгийг үнэ өртөг нэмсэн гинжин сүлжээний хамт сайжруулах орон зай байна. Түүний зэрэгцээ, зах зээлд чиглэсэн ур чадвар байхгүй байгаа нь үнэ өртөг нэмсэн үйл ажиллагааг өрсөлдөөнт байдлаар хөгжүүлэхэд саад болж байгаа бөгөөд мэргэжлийн сургалтын систем нь хувийн хэвшлийн хэрэгцээг хангах хэмжээнд очиж чадахгүй байна.
- Үйлдвэрлэл, боловсруулалт, түгээлтийн бүхий л шатан дахь эрүүл ахуй, чанар, дамжлага бүр дэх хяналт бүртгэлийн стандарт сул байгаа ба энэ нь хөдөө орон нутаг дахь стандарт муутай дэд бүтэцтэй нийлээд хөдөө аж ахуйн салбарыг илүү өрсөлдөөнтэй, зах зээлд гарахуйцаар хөгжүүлэхэд ерөнхийдээ саад болж байна.
- Газар эзэмших эрх авах гарц нь BEEPS V судалгаанд дурдсанаар хувийн хэвшлийн хөгжилд гол саад тогтор болсоор байна. Газар арилжих, хөрөнгө бүртгэхтэй уялдаатай авилгалыг арилгах, эд хөрөнгөтэй холбоотой төрийн үйлчилгээг жигдрүүлэх, ил тод байдлыг хангах явдал бүгд чухал байна. Мөн орчин үеийн, дизайн сайтай орон сууц, бизнесийн үл хөдлөх хөрөнгөний олдоц хангалтгүй байна.
- Банкны салбар сул хөгжсөн, хөрөнгө капиталын зах зээл үүсээгүй байдал нь БЖДҮ-ийн газруудад онцгой хүнд дарамт учруулж байна. Хэдийгээр Монголын компаниуд банкны зээлдэгчдийн харьцангуй өндөр хувийг эзэлдэг боловч тэдний хувьд санхүүжилт олох гарц хамгийн том саад тогтор болж байна. Гэвч зээлийн хүү маш өндөр, сүүлийн үеийн бараг бүх зээлд барьцаа шаардсан байгаа явдал нь компаниуд, ялангуяа шинэ тутам байгуулагдсан компанийн хувьд зээл авах боломжийг нь хааж байна.
- Банкны салбар дахь дотоод практик, түүний дотор компанийн засаглал, эрсдлийн менежмент, хэрэглэгчдэд мэдээлэл ил болгох зэргийг бүгдийг нь сайжруулах шаардлагатай. Төв Банкны хяналтын үүрэг ролийг зохицуулалтын хүрээ, зах зээлийн институцийн хамт бэхжүүлэх, түүний дотор Хадгаламжийн даатгалын корпораци, хувийн эзэмшилд байдаг Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг хөнгөвчлөх замаар бэхжүүлэх хэрэгтэй. Төв Банк өөрийн засаглалыг сайжруулах, зорилгоо улам сайн тодорхой болгох талаар ажиллаж байна. Банкны тухай хуулийг 2017 оны эцэс гэхэд шинэчлэн найруулж батлахаар төлөвлөж байна.
- Хөрөнгийн зах зээл нь төлбөрийн чадвар сул, арилжаа бага, клиринг болон маргаан таслах дэд бүтэц хязгаарлагдмал, хангалтгүй хөгжсөн хууль эрх зүй,

зохицуулалтын систем, хөрөнгө оруулагчдын тоо цөөн зэрэг шинж тэмдэгтэй байна.

Үйл ажиллагааны хариу үйлдэл

- Тус Банк компани болон ЖДҮ-ийн аль алинд нь шууд ба зуучилсан өрийн болоод хувь хөрөнгийн санхүүжилт олгох замаар олборлох бус салбарын өрсөлдөх чадварыг дэмжиж ажиллах бөгөөд чингэхдээ агробизнес, барилгын материал, хөнгөн үйлдвэрийн салбар, мөн үйлчилгээнд түлхүү анхаарна. Монгол улс томоохон зах зээлүүд, тухайлбал Хятад руу гарах экспортын нэмэлт бололцоонуудыг давуу байдлаар ашиглаж болох (жишээ нь, агро бүтээгдэхүүнийг сертификатлах, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартуудыг сайжруулах бололцоо нь ноолуур зэрэг баталгаатай экспортын бүтээгдэхүүнд өрсөлдөх давуу байр суурь олгоно) тийм салбаруудыг тус Банк тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн тогтооно.
- ЖДҮ-ийн экспортын чадавхийг бүрдүүлэх, энтрепренер чадварыг нь дэмжих, зах зээлийн хэрэгцээг хангахад нь туслах зорилгоор тус Банкны Жижиг бизнест зөвлөгөө өгөх үйлчилгээгээр хөрөнгө оруулалтыг баяжуулж ажиллана. Энэ үйлчилгээгээр агробизнес (ялангуяа сүүн бүтээгдэхүүн, мах, ноолуур) хөгжүүлэх, үйлдвэрийн газрын эрчим хүчний хэмнэлт нэвтрүүлэхэд онцгойлон хандсан төрөлжсөн сургалт явуулна. Мөн ажлын байр бий болгох хамгийн их потенциалтай хувийн хэвшлийн салбарууд, ялангуяа агробизнесийн салбар дахь ажлын ур чадварын эс зохицолдох байдлыг арилгах үүднээс мэргэжлийн гүнзгийрүүлсэн сургалт, ажил дээр суралцах боломжийг дэмжиж ажиллахыг эрмэлзэнэ. Тус Банк түнш компаниудтай хамтран тэгш бололцоо олгох бодлогын шилдэг практикийг нэвтрүүлэхийг дэмжинэ.
- Тус Банк зах зээл дээр байр сууриа эзэлсэн агрегатор (өөрөөр хэлбэл, экспорт хийх зорилгоор худалдан авалт хийгч, орон нутгийн хүнсний бүтээгдэхүүн боловсруулагч, гэрээт худалдан авагч) компаниуд болон тэдний ханган нийлүүлэгчидтэй хамтран ажиллаж, үнэ өртөг нэмсэн гинжин сүлжээг бэхжүүлэхийг эрмэлзэн ажиллах ба чингэхдээ үнэ өртөг нэмсэн гинжин сүлжээний санхүүгийн бүтээгдэхүүн (нэхэмжлэгийн өмнөх ба дараахь) бий болгож, түнш банкуудаараа дамжуулан худалдааны санхүүжилтын зээлийн шугамаар Монголын экспортлогчдыг дэмжин, уул уурхайн бус салбарын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана. Банк төслүүдээрээ дамжуулан Монголын хувьд шинэ, инноваци болох (түүний дотор мэдээллийн технологийг улам хөгжүүлсэн) боловсруулалт, технологи нэвтрүүлэх, чанарын стандартыг дээшлүүлэх, засаглал, бизнес практикийг сайжруулахын төлөө ажиллана. Агробизнес, анхан шатны хөдөө аж ахуйн салбарт фермерийн шинэ техник, түгээлт / экспортын шинэ суваг шаардлагатай байгаа ба ийм боломжийг тус Банк нэр хүнд бүхий компаниудтай хамтран судална.
- Үүний зэрэгцээ, эдийн засаг дахь төрийн үүрэг роль өндөр байгаа оронд өөрийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг дотооддоо зарж борлуулахад нь хувийн хэвшилд туслах зорилгоор тус Банк ил тод, өрсөлдөх чадвартай нийтийн цахим худалдан авалтын систем бий болгохыг үргэлжүүлэн дэмжиж ажиллана.
- Тус Банк хувийн хэвшлийн санхүүжилт олох гарцыг сайжруулах зорилгоор түнш банкууд болон бичил санхүүгийн байгууллагуудаар дамжуулан, эрсдэл хуваалцах механизм, зээлийн шугам бий болгож, өрсөлдөх чадвар, ЖДҮ, эрчим хүч, нөөц эх үүсвэрийн хэмнэлтийг дэмжсэн арга хэмжээнд төвлөрөн, эмэгтэйчүүдээр толгойлуулсан бизнесийг хувийн хэвшлийн санаачилга (PFI)-аар дамжуулан тусгай

зорилтот санхүүжилтээр дэмжих боломжийг судалж ажиллана. Мөн лизинг, факторинг, Зээлийн товчоо зэрэг ЖДҮ-ийн газрын санхүүжилт олох гарцыг өргөжүүлэх хүрээг дэмжин ажиллана.

- Санхүүгийн салбарын тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор тус Банк долларжуулалтыг багасгах, үндэсний валютаар арилжаа хийдэг хөрөнгийн зах зээлийг цаашид хөгжүүлэхийг дэмжиж ажиллах ба түүний дотор банкууд дахь форексийн хариуцлагын менежментийг хялбаршуулах зорилгоор мөнгөний зах зээл, деривативийн хэрэгслүүдийг бэхжүүлэхэд зөвлөгөө өгнө. Цаашилбал энэ чиглэлээр компаниуд болон түнш санхүүгийн байгууллагууддаа урт хугацааны үндэсний валютын санхүүжилт олгож ажиллахыг зорино. Үндэсний валютаарх санхүүжилтын эх үүсвэрийг төрөлжүүлэх зорилгоор тус Банк монгол төгрөгийн бонд гаргаахыг үргэлжлүүлнэ.
- Тус Банк мөн Монголын Хөрөнгийн биржийн үйл ажиллагааны чадавхийг сайжруулах зорилгоор техник хамтын ажиллагаа эхлүүлнэ.
- ЕСБХБ ОУВС-гийн батлагдсан хөтөлбөр дээр тулгуурлан, төрөлжүүлэлт, эдийн засгийн тэсвэрлэх чадварыг хөхиүлэн дэмжих өргөн хүрээний бодлогын дэмжлэг үзүүлж болох юм. Тус Банк банкны салбарын хяналт удирдлагыг сайжруулах, эрт интервенц хийх практикийг хөхиүлэн дэмжих талаар Төв Банкинд туслахад бэлэн байна. Ялангуяа, өмнөх үеийн бодлогын яриа хэлэлцээний дагуу санхүүгийн бодлого, хууль эрх зүйн хүрээний төрөл бүрийн аспектаар, тухайлбал ипотека, санхүүгийн баталгаа, банк бус санхүүгийн байгууллага, факторингийн хууль, зээлийн корпораци зэрэг асуудлаар хийж буй ажлаа үргэлжлүүлнэ. Одоогийн хүндрэлтэй нөхцөлд банкны салбарт тус дэм болохын тулд чанаргүй зээлийг нөхөн төлүүлэх, хадгаламжийг даатгах, хадгаламж эзэмшигчдийг хамгаалах зэрэг шинэ сэдвүүдийг судалж үзэх болно.

Үр дүнгийн хүрээ. Сэдэв 1: Олборлох бус салбаруудын өрсөлдөх чадварыг сайжруулах, санхүүжилт олох гарцыг хялбаршуулах замаар Монголын тэсвэрлэх чадварыг бэхжүүлэх

	СОРИЛТ	ЗОРИЛТ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЯНАХ ҮЗҮҮЛЭЛТ
1.1	Хувийн хэвшлийн хөдөлмөрийн бүтээмж, өрсөлдөх чадварыг сайжруулах томоохон орон зай байна	Уул уурхайн бус салбарын засаглал, бизнес жаягийн стандартыг нэмэгдүүлэх, өндөр үнэ өртөг нэмсэн ажиллагааг дэмжих	- Шууд ба зуучилсан зээлийн болон шууд хөрөнгө оруулалтын санхүүжилт олгох, ингэхдээ агробизнес, барилгын материал, хөнгөн үйлдвэрийн болон үйлчилгээний салбарт анхаарах - Уул уурхайн бус ГШХО-ыг дэмжих, тогтсон компаниудтай ажиллахаас гадна үнэ өртөг нэмсэн гинжин сүлжээг санхүүжүүлэх - Шинэ, инновацийн боловсруулалт, технологи нэвтрүүлэх, чанарын стандарт, засаглал, бизнес жаягийг сайжруулах, түүний дотор эрэгтэй, эмэгтэй хүнд ажлын байран дахь тэгш бололцоо олгох - ASB (экспортын чадавхи бий болгох төрөлжсөн сургалт явуулах г.м.), мэргэжлийн сургалт, ажил дээрх сургалтын тусламжтайгаар хүний нөөцийн чадавхийг сайжруулахад туслах	- Гадаадын хөрөнгө оруулагчид орж ирснээс үүдэлтэй ГШХО-ын дотогш урсгалын хэмжээ (<i>Суурь үзүүлэлт – 0</i>) - Банкны дэмжлэгтэйгээр шинэ, инновацийн боловсруулалт, технологи нэвтрүүлсэн, чанарын стандарт, засаглал, бизнес жаягийг сайжруулсан, ажлын байран дахь тэгш боломжийг хангасан клиентийн (болон чанарын үзүүлэлт)-ийн тоо (<i>Суурь үзүүлэлт – 0</i>) - Бүтээмж нэмэгдсэнийг тайлагнасан ASB харилцагчдын тоо (<i>Суурь үзүүлэлт – төсөл батлагдах үед тогтооно</i>)
1.2	Банкны салбар сул хөгжсөн, хөрөнгийн зах зээл бараг байхгүй	Банкны салбар дахь практикийг сайжруулахад болон хөрөнгийн зах зээлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх	- LCY зэрэг хувийн санхүүгийн санаачилга (ХСС)-аар эрсдэл хуваалцах механизм, зээлийн шугам бий болгох, өрсөлдөх чадвар, ЖДҮ, экспортлогчид, нөөц хөрөнгийн хэмнэлтэд анхаарах - Төгрөгийн бонд гаргахаа үргэлжүүлэх, боломжтой үед компаниуд болон ХСС-д LCY дэмжлэг үзүүлэх - Долларжилтыг багасгахыг дэмжих, мөнгөний зах зээл, деривитив хэрэгслийг бэхжүүлэх зөвлөгөө өгөх замаар LCY зах зээлийг улам хөгжүүлэх	- ЕСБХБ-ны шууд санхүүжилтээр түнш санхүүгийн байгууллагаас зорилтот чиглэлд (төслийн түвшинд тодорхойлсноор БЖДҮ, эмэгтэйчүүд толгойлсон ЖДҮ, RCY, RE, факторинг) олгосон дэд зээлийн тоо/хэмжээ (<i>Суурь үзүүлэлт – төсөл батлагдах үед тогтооно</i>) - Банкны дэмжлэгтэйгээр өрийн хөрөнгийн зах зээл дээр гаргасан бондын тоо, хэмжээ (<i>Суурь үзүүлэлт – 0</i>) - Шинэ хэрэгсэл (төслийн түвшинд тодорхойлсны дагуу ₮-ийн бонд, мөнгөний зах зээл/деривитивийн хэрэгсэл) нэвтрүүлсэн тоо, хэмжээ (<i>Суурь үзүүлэлт – 0</i>)
Контекст үзүүлэлтүүд: ДЭЗЧУ-ын (Global Clinton Initiative) Сайн зах зээлийн үр ашиг (<i>Суурь үзүүлэлт 2016-2017 оны оноо - 4.0; эрэмбэ – 138-аас 104</i>) Санхүүжилт олох гарц нэг гол саад гэсэн компаниудын % (<i>Суурь үзүүлэлт 2013 – 31.7%, World Bank / EBRD Enterprise Surveys</i>)				

Сэдэв 2: Сайн засаглалтай уул уурхайг ашиглах замаар тогтвортой байдлыг бэхжүүлэх, үнэ өртөг нэмсэн гинжин сүлжээ бий болгохыг дээд хэмжээнд хүргэх

Шилжилтийн сорилтууд

- Уул уурхайн салбарыг хүртээмжтэй, тогтвортой өсөлтийн хөдөлгөгч хүч болгохын тулд салбарын зохицуулалтын практикийг сайжруулах, түүний дотор тусгай зөвшөөрөл олгох ажлыг илүү ил тод болгох шаардлагатай. Цогц байдал, аюулгүй ажиллагаа, байгаль орчны тогтвортой байдлын стандартуудыг сайжруулах шаардлагатай. Сайн ажиллагаатай институциудыг хөгжүүлэх, одоогийн хууль тогтоомжийг тогтвортой, сайн засаглалтай, хөрөнгө оруулагчдад таатай бизнес орчинг хангах чиглэлээр сайжруулах, үр дүнтэй хэрэгжүүлэх явдал мөн чухал байна.
- Байгалийн нөөцтэй холбоотой дотоодын үйлдвэрийн газрууд үнэ өртөг нэмсэн гинжин сүлжээний утгаар сул хэвээр байгаа ба уул уурхайн салбар болон дотоодын ханган нийлүүлэгчдийн хэлхээ холбоо сайн хөгжөөгүй байна. Уул уурхайн төслүүдийг хэрэгжүүлэхэд цаг хугацаа их орох боловч, уул уурхайн салбарын ханган нийлүүлэх гинжин сүлжээний өрсөлдөх чадвар, үнэ өртөг нэмсэн ажиллагааг сайжруулах нь олборлох салбарт шууд оролцдоггүй хувийн компаниудад уул уурхайн салбарын хөгжлийг ашиглах, эдийн засгийг төрөлжүүлэх тааламжтай орчин бий болгох ач тустай юм. Уул уурхайн салбарын үр ашиг хүн амын эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд ашиг тусаа өгөх явдлыг хангах сайн практикийг хөхиүлэн дэмжих нь салбарын хүртээмжийг хангахад бас чухал юм.
- Уул уурхайн салбарын үр дүнтэй зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байгаа бөгөөд үүнийг юуны өмнө орлогын ил тод, тогтвортой менежментийг хангах зохицуулагч байгууллагуудын хараат бус байдал, техникийн чадавхийг бэхжүүлж, төсвийн няг нямбай бодлогоор дэмжиж хийх нь зүйтэй. Сайн боловсруулсан Ирээдүйн өв сан энэ чиглэлд хэрэг болохуйц арга хэрэгсэл болж болох юм.

Үйл ажиллагааны хариу үйлдэл

- Тус Банк олборлох салбар (түүний дотор нефть хангамжийн бие даасан компаниуд) дахь төслүүдийг санхүүжүүлсэн хэвээр байх ба харин тэд Банкны Байгаль орчин, нийгмийн харилцааны бодлогын дагуу, ашиглах боломжтой шилдэг практик (ВАТ)-т нийцсэн үр ашигтай технологи, бохирдлоос сэргийлэх, хяналт тавих арга зам ашиглах замаар Банкны үйл ажиллагаа, байгаль орчны өндөр стандартуудад нийцсэн ажиллагаа явуулдаг байх ёстой. Тогтвортой уул уурхайн практикт үнэнч, нэр хүнд бүхий гадаадын хөрөнгө оруулагчдаас сонгон авч, өрийн болон хувь хөрөнгийн санхүүжилтээр дэмжих, түүний дотор төслийн эхний үе шатны үед дэмжих болно. Гэхдээ, төслийн бэлтгэл ажил урт хугацааны туршид явагддаг учир дунд хугацаанд уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалт мэдэгдэхүйц нэмэгдэх төлөвгүй байна.
- Байгалийн нөөцийн салбар дахь нөхцөл байдал, тус салбар дахь ил тод байдлыг цаашид сайжруулах зорилгоор тус Банк дэлхий дахины Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилга (EITI)-ыг дэмжсээр байх бөгөөд тогтвортой, хөрөнгө оруулагчдад таатай орчинг хангахын тулд одоогийн хууль тогтоомжийг сайжруулахад дэмжлэг мөн үзүүлнэ. ЕСБХБ тус Санаачилгыг хэрэгжүүлэхэд нь Монголд 2010 оноос хойш техник хамтын ажиллагааны буцалтгүй тусламж үзүүлсээр ирсэн. Монгол улс сайн ажиллаж, EITI-н шаардлагыг хангасан анхны

орнуудын нэг болсон. Тус Банк одоогийн явуулж буй үйл ажиллагаан дээрээ тулгуурлан, EITI санаачилгын орон нутгийн түвшин дэх хүртээмж, ойлголтыг нэмэгдүүлэх, түүний дотор олборлох үйлдвэрлэлийн орлогын статистик тоо баримтыг хэвлэх, нийтэд түгээхэд чиглэсэн техник хамтын ажиллагааны гуравдахь үе шатыг эхлүүлнэ.

- Дийлэнх уул уурхайн төслүүдийг бүрэн хэрэгжүүлж дуустал урт хугацаа шаардагддагийг бодолцон, тус Банк доороос дээш чиглэсэн уул уурхайн үнэ өртөг нэмэх гинжин сүлжээ (өөрөөр хэлбэл, хөнгөн тоног төхөөрөмж, ажлын хувцасны үйлчилгээ, хоол хүнс нийлүүлэлт, тоног төхөөрөмжийн лизинг, тээвэрлэлтийн компаниуд)-г хөгжүүлэх, ялангуяа уул уурхайн компаниудтай гэрээгээр ажилладаг ЖДҮ-ийг оролцуулах ажил хийнэ. Тийм ЖДҮ-үүдэд аль болох дотоодын арилжааны банкуудтай хамтран, эсвэл тэднээр дамжуулан шаардлагатай санхүүжилт олгох, мөн тэдний гэрээт ажлын тендэрт амжилттай оролцох өрсөлдөх чадвар, ашигт ажиллагааг сайжруулахад чиглэсэн техник хамтын ажиллагаа явуулах болно.
- Тус Банк мөн экспортын ихээхэн потенциалтай ашигт малтмалыг илүү гүнзгий боловсруулах чадавхийг дэмжих, түүгээрээ салбарын үнэ өртөг нэмсэн ажиллагааг дэмжих бололцоонуудыг хайж ажиллана.
- Уул уурхайн салбарын эрх баригчдын хүсэлтээр, Геологийн мэдээллийн систем (GIS)-ийн өгөгдлийн сан байгуулах, тэгснээрээ улс орны ашигт малтмалын орд газруудын нээлттэй, ил тод зураглал бий болгох талаар техник хамтын ажиллагаа явуулах хувилбаруудыг судалж үзнэ.
- Мөн тус Банк Монголын Ирээдүйн өв сангийн чадавхийг сайжруулах, ялангуяа худалдан авалтын практикт төвлөрөн ажиллахад дэмжлэг үзүүлнэ.

Үр дүнгийн хүрээ. Сэдэв 2: Сайн засаглалтай уул уурхайг ашиглах замаар тогтвортой байдлыг бэхжүүлэх, үнэ өртөг нэмсэн гинжин сүлжээ бий болгохыг дээд хэмжээнд хүргэх

	СОРИЛТ	ЗОРИЛТ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЯНАХ ҮЗҮҮЛЭЛТ
2.1	Байгалийн нөөцтэй холбоотой дотоодын үйлдвэрийн газрууд үнэ өртөг нэмсэн гинжин сүлжээний утгаар сул хэвээр байгаа ба уул уурхайн салбар болон дотоодын ханган нийлүүлэгчдийн хэлхээ холбоо сайн хөгжөөгүй байна	Уул уурхайн хөгжлийг ашиглах, эдийн засгийн төрөлжилтөд таатай нөхцөл бий болгох зорилгоор хангамжийн сүлжээний шат дамжлага бүрт үнэ өртөг нэмэх	- Цогц байдал, аюулгүй ажиллагаа, байгаль орчны тогтвортой байдлын хамгийн өндөр стандартуудыг хангасан компаниудыг санхүүжүүлэх, уул уурхайн салбарт тэгш бололцоог хангасан шилдэг практик нэвтрүүлэх, сонгож авсан гадаадын хөрөнгө оруулагчдад хувь хөрөнгийн болоод өрийн санхүүжилт олгох замаар уул уурхайн салбарын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах - Уул уурхайн компанитай гэрээ байгуулсан ЖДҮ (түүний дотор эмэгтэйчүүд удирдсан)-үүдэд доороос дээш чиглэсэн уул уурхайн үнэ өртөг нэмэх сүлжээ хөгжүүлэхэд нь санхүү, техникийн тусламж үзүүлэх	- Тохиролцсон түвшинд хүрч сайжирсан стандарт, практик (түүний дотор төслийн түвшинд тодорхойлсноор ЕІТІ-н ил тод байдлын стандарт, байгаль орчны менежмент, тэгш боломжийн практик)-ийн тоо (<i>Суурь үзүүлэлт – 0</i>) - ЕСБХБ-ны шууд санхүүжилтээр түнш санхүүгийн байгууллагын уул уурхайн салбар(төслийн түвшинд тодорхойлсноор БЖДҮ, эмэгтэйчүүд удирдсан ЖДҮ) –т олгосон зорилтот дэд зээлийн тоо, хэмжээ (<i>Суурь үзүүлэлт – 0</i>)
2.2	Уул уурхайн салбар дахь зохицуулалтын практикийг сайжруулах, түүний дотор ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай	Сайн засаглалтай, хөрөнгө оруулагчдад таатай орчинг уул уурхайн салбарт бий болгоход тусламж үзүүлэх	- ЕІТІ санаачилгын орон нутгийн түвшин дэх хүртээмж, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн техник хамтын ажиллагааны гуравдахь үе шатыг хэрэгжүүлэх - Геологийн мэдээллийн систем (GIS)-ийн өгөгдлийн сан байгуулах техник хамтын ажиллагаа хэрэгжүүлэх хувилбаруудыг судлах - Одоогийн уул уурхайн хууль тогтоомжийг тогтвортой, хөрөнгө оруулагчдад таатай орчинг хангах зорилгоор сайжруулахад дэмжлэг үзүүлэх	- ЕІТІ санаачилгын хүртээмжийг орон нутагт нэмэгдүүлсэн болон олборлох үйлдвэрлэлийн орлогын тоо мэдээллийн ил тод байдал нэмэгдсэн ахиц дэвшил (<i>Суурь үзүүлэлт – N/A</i>) - Уул уурхайн хууль тогтоомж, журам салбар дэх гарааны тэгш байдлыг дэмжсэн чиглэлээр эрх зүйн хувьд сайжирсан байдал (<i>Суурь үзүүлэлт – N/A</i>)
Контекст үзүүлэлт: ЕІТІ санаачилгад бүртгэгдсэн, орлогоо мэдүүлсэн компаниудын тоо (<i>Суурь үзүүлэлт 2014 он – 992</i>)				

Сэдэв 3: Дэд бүтцийн үйлчилгээний чанар, тогтвортой байдлыг үр ашгийг нь нэмэгдүүлэх, арилжааны хэлбэрт оруулах, «ногоон» шийдэл гаргах замаар хангах

Шилжилтийн сорилтууд

- Ус хангамж болон бохир ус цэвэршүүлэх салбарын аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулалт байхгүйн улмаас сул хөгжсөн, ашиггүй ажилладаг бөгөөд арилжааны хэлбэрт оруулж, компанийн бүтцийн өөрчлөн байгуулалт хийх шаардлагатай болжээ. Зохицуулалтыг сайжруулах, үнэ тариф тогтоох орчин үеийн аргачлал боловсруулж нэвтрүүлэх, хураамж авах түвшинг нэмэх, мөн усны чанар, нөөцийн хэмнэлт, ус хангамж, бохир усны менежмент энэ бүгдийг сайжруулах шаардлагатай.
- Хотын тээврийн салбарт төрийн өмчит компаниуд илүү бие даасан байдалд, түүний дотор хотын захиргаатай гэрээ байгуулж ажиллах хэлбэрт орвол ашиг тустай. Үйлчилгээний чанар, үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулах, байгаль орчны стандартыг өндөрсгөхийн тулд хувийн хэвшлийн оролцоог өргөжүүлэх хэрэгтэй.
- Авто зам барих, арчилж тордох ажил санхүүжилт дутуугаас, мөн гэрээ байгуулах ажилд ил тод байдал, өрсөлдөөн орхигдсоноос болж доголдож байна. Зохицуулалтын практикийг ялангуяа төрийн худалдан авалтын хувьд илүү ил тод болгох ёстой.
- Төмөр замын чадавхи байхгүй байгаа нь эдийн засгийн илүү тэнцвэртэй, тогтвортой өсөлтөд ихээхэн саад, хязгаарлалт учруулж байна. ТХХТ (РРР)-ийн бүтцийн хүрээнд хэсэгчлэн хувийн хэвшлээр санхүүжүүлэх одоогийн төмөр замыг шинэчлэх, шинэ сүлжээ байгуулах, боломжтой газар нь «ногоон» шаардлагыг хангах явдал улам бүр тулгамдсан сорилт болоод байна.
- Цахилгаан үйлдвэрлэх системийг шинэчлэх ажил уул уурхай, бусад салбарын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах, үр ашигтай, байгаль орчны хувьд тогтвортой хэлбэрээр хүн амд үйлчлэхэд мөн амин чухал болоод байна. Төрийн өмчит компаниудыг бизнесийн хэлбэрт оруулах, хоцрогдсон, үр ашиггүй дэд бүтцийг сольж шинэчлэх шаардлагатай. Цахилгаан эрчим хүчний салбарын зохицуулагч байгууллагын хараат бус байдлыг бэхжүүлж, үнэ тариф өртгөө нөхөх түвшинд очихоор аргачлалаа хянан үзэх хэрэгтэй.
- Аж үйлдвэр, хөдөө аж ахуй, дэд бүтэц, эрчим хүчний салбарт «ногоон» шийдлүүд авч хэрэглэх, нийтлэг болгох өргөн орон зай байна. Сэргээгдэх эрчим хүчийг дэмжсэн хууль эрх зүй, институцийн хүрээ хангалтгүй хөгжсөн, эцсийн хэрэглэгчийн төлөх үнэ тариф өртөг зардлаа нөхөх хэмжээнд биш байна. Нүүрсхүчлийн санхүүжилтын төслүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх хэрэгцээ байна.

Үйл ажиллагааны хариу үйлдэл

- Тус Банк засгийн газрын зээл (зээлийн орон зай байгаа эсэхээс хамааран) болон түүнийг Улаанбаатар хотын хувьд дамжуулан зээлдэх үндсэн дээр хотын өмчийн компаниудыг санхүүжүүлэх замаар Монголын хот суурин газрын дэд бүтцийг арилжааны болоод байгаль орчны хувьд тогтвортой хөгжүүлэх шийдлүүд боловсруулахад нь туслана. Үр ашигтай тарифын систем, хураамж авах механизм боловсруулахад нь хотын компаниуд, үйлчилгээний бусад аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх зорилгоор хотын өмчийн компаниудын болоод хотын төсвийн бүтцийн санхүүгийн үр дүнтэй менежментийг дэмжих техник хамтын ажиллагаатай дээрх арга хэмжээг хослуулан хэрэгжүүлнэ. Төслүүдийг аль болох эрт амжилттай

хэрэгжүүлбэл ийм төслүүд үндэслэлтэй болохыг харуулж, цаашдын бололцоонуудыг нээж өгөх бөгөөд тус Банк юуны өмнө үр дүн нь ил харагдах жижиг төслүүдэд төвлөрч, тарифын реформ илүү урт хугацаа шаардахыг ойлгож ажиллана. Үнэ тарифыг аажмаар өртгөө нөхөх түвшинд хүргэхийн тулд хотын төслүүдэд эхний үедээ хөрөнгийн буцалтгүй тусламжийн санхүүжилт оруулах шаардлагатай болно.

- Тус Банк хэдийгээр улсын өр төлбөр их байгаа боловч Засгийн газрын өндөр ач холбогдолтой тэргүүлэх нэг зорилт гэж үзсэн тээврийн дэд бүтэц, ялангуяа төмөр замын дэд бүтэц, явах хөдлөх бүрэлдэхүүнийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжийг хайж ажиллана. Ийм хөрөнгө оруулалт нь ашигт малтмал экспортлогч орны хувьд тус улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлээд зогсохгүй, бүс нутгийн интеграчлалд багтах, хамрагдах үйл явцыг эрчимжүүлэх юм. Мөн Өмнөд Говь дахь уурхайнууд байгаль орчинд ихээхэн сөрөг нөлөө (тоос шороо, түлшний бохирдол, г.м.) үзүүлж буй хүнд даацын автомашины тээвэрлэлтээс хамааралтай байдлыг багасгах юм. Авто замын салбарт ЕСБХБ «Талын зам» тээврийн коридорын хөгжилд хувь нэмэр оруулахыг эрмэлзэж ажиллах бөгөөд чингэхдээ олон улсын бусад хөгжлийн банкууд (түүний дотор, магадгүй Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк)-тай хамтран ажиллаж, боломжтой газар ТХХТ (PPP)-ийн бүтцийг дэмжин ажиллана. Энэ үүднээс тус Банк ТХХТ-ийн эрх зүйн зохистой хүрээ бий болгох, мөн тийм бүтцийг хэрэгжүүлэх засгийн газрын чадавхийг нэмэгдүүлэхэд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлнэ.
- Тус Банк өнөөгийн байдлаар гадаад (гол төлөв Хятадын) зуучлагчдаас хамааралтай байгаа Монгол улсын тээвэр, ложистикийн өсөн нэмэгдэж байгаа зардлын асуудлыг шийдэх боломжтой ложистик, агуулахын төвүүд байгуулахыг дэмжиж ажиллахаа үргэлжлүүлнэ.
- Салхитын салхин цахилгаан станцыг амжилттай хэрэгжүүлж дууссан, тэргүүлэх хөрөнгө оруулагч болох SoftBank-тай хамтран Цэцийн салхин цахилгаан станц (аль аль нь 50 мегаваттын хүчин чадалтай) байгуулах гэрээнд гарын үсэг зурсан байгаа энэ үед тус Банк сэргээгдэх эрчим хүч, тухайлбал салхи, нарны эрчим хүчний салбарт нэр хүнд бүхий хөрөнгө оруулагчидтай хамтран санхүүжилт хийх боломжийг үргэлжлүүлэн хайж ажиллана. Мөн улс орон дотроо болон гадаад руу сэргээгдэх эрчим хүч дамжуулах шугам байгууламжийн маршрут боловсруулах ажлыг бизнесийн бас нэг потенциал гэж үзэн судалж үзнэ.
- Мөн тус Банк 2023 он гэхэд улс орны нийт цахилгаан хэрэглээний 20%-г сэргээгдэх эрчим хүчнээс гаргах Засгийн газрын зорилтыг дэмжиж, сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалтын ил тод, үр ашигтай тендэрийн ажиллагаа бий болгоход тусалж ажиллана. Энэ ажилд ихээхэн буцалтгүй тусламж шаардлагатай болно.
- Тус Банк эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийн талаар санхүүжилтын өмнөх зөвлөгөө өгөх (эрчим хүчний аудит), эрчим хүчний хэмнэлттэй төслийн санхүүжилт авах гарц бий болгох замаар эрчим хүчний нягтрал багатай шийдлүүдийг дэмжиж ажиллана.
- Мөн боломжтой газар ТХХТ-ийн бүтцийг ашиглах замаар хамгийн орчин үеийн, ногоон, нүүрс хүчлийн хий хамгийн бага гаргах эрчим хүчний шийдлүүдийг боловсруулахад хувь нэмэр оруулахыг чармайн ажиллах болно. 450 МВт чадалтай, нүүрсээр ажиллах дулаан, цахилгааны станц болох Улаанбаатарын ДЦС№5 (СНР-5) зэрэг нүүрс түлэхэд тулгуурласан эрчим хүчний шинэ хүчин чадал бий болгох шийдлийн хувьд Банкны аливаа санхүүжилт олгох асуудал нь тус Банкны 2013 оны Эрчим хүчний стратегийн баримт бичгийн шаардлагыг хангасан байх нөхцөлтэй байх болно.

Үр дүнгийн хүрээ. Сэдэв 3: Дэд бүтцийн үйлчилгээний чанар, тогтвортой байдлыг үр ашгийг нь нэмэгдүүлэх, арилжааны хэлбэрт оруулах, «ногоон» шийдэл гаргах замаар хангах

	СОРИЛТ	ЗОРИЛТ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЯНАХ ҮЗҮҮЛЭЛТ
3.1	Компаниуд үр ашиггүй ажиллаж байгаа учир арилжааны хэлбэрт оруулж, компанийн бүтцийн өөрчлөлт хийх шаардлагатай	Монголын хот газрын дэд бүтцийг хөгжүүлэх арилжааны болоод байгаль орчны хувьд тогтвортой шийдэл олоход тусалж дэмжих	- Хотын компаниудад засгийн газрын зээл болон түүнийг дамжуулан зээлдүүлэх үндсэн дээр санхүүжилт олгох - Үнэ тариф, хураамж авах механизмын үр ашигтай хувилбар боловсруулахад нь хотын компани, үйлчилгээний газруудад дэмжлэг үзүүлэх	- Үйл ажиллагааны түвшинд тодорхойлогдох шинэ технологи, ур чадвар, стандарт нэвтрүүлэх замаар илүү хэмнэлттэй ажилласан (зардал, ажиллагсдын тоо багассан) хотын компаний тоо (<i>Суурь үзүүлэлт – 0</i>) - Тодорхойлсон гол үзүүлэлтүүдээр (үйл ажиллагааны түвшинд тодорхойлогдох хураамжийн түвшин, зардлын хэмнэлт, хаягдлын бууралт) гүйцэтгэлийн хувь хэмжээ сайжирсан хотын компаний тоо (<i>Суурь үзүүлэлт – N/A</i>)
3.2	Тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах, төмөр замын хүчин чадал байхгүй байгааг шийдэх зорилгоор хувийн хэвшлийн оролцоог өргөжүүлэх шаардлагатай	ТХХТ, хувийн хэвшлийн оролцоог хангах замаар тээврийн дэд бүтэц, дэмжигч үйлчилгээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	- Төмөр замын дэд бүтэц, явах хөдлөх бүрэлдэхүүнд хөрөнгө оруулах, «Талын зам» тээврийн коридорын хөгжилд бусад хөгжлийн банкттай хамтран ажиллах замаар хувь нэмэр оруулахыг эрмэлзэж ажиллах - Концесс, ТХХТ-ийг санаачилж хэрэгжүүлэх засгийн газрын чадавхийг сайжруулах замаар ТХХТ-ийн зохицуулалтын хүрээлэн буй орчин, нийгмийн бий болгохыг дэмжих - Монголын өсөн нэмэгдэж буй тээврийн зардлын асуудлыг шийдвэрлэх зорилгоор ложистик, агуулах төвүүд байгуулах ажлыг санхүүжүүлэх	- Зорилтот механизм (үйл ажиллагааны түвшинд тодорхойлогдох менежментийн гэрээ, лизинг, ааутсорсинг) ашиглан, гүйцэтгэлд тулгуурласан тохиролцоогоор хувийн хэвшилд шилжүүлсэн тээврийн үйлчилгээ (<i>Суурь үзүүлэлт – 0</i>) - Тодорхойлсон гол үзүүлэлтүүдээр (үйл ажиллагааны түвшинд тодорхойлогдох хураамжийн түвшин, зардлын хэмнэлт, хаягдлын бууралт) гүйцэтгэлийн хувь хэмжээ сайжирсан ложистикийн компани, агуулах үйлчилгээний төвийн тоо (чанарын үзүүлэлт) (<i>Суурь үзүүлэлт – 0</i>) - Үйл ажиллагааны түвшинд тодорхойлогдох хөнгөлөлттэй зээл, ТХХТ-ийн хууль эрх зүй, зохицуулалтын орчин хүрээ сайжирсан байдал (чанарын үзүүлэлт) (<i>Суурь үзүүлэлт – N/A</i>)
3.3	Цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг байгаль орчны тогтвортой байдлаар хангахад эрчим хүчний салбарын шинэчлэл шаардлагатай	ТХХТ-ийн бүтцийг ашиглан, хамгийн орчин үеийн, ногоон эдийн засгийн эрчим хүчний шийдэл боловсруулах utilising PPP structures	- Сэргээгдэх, ялангуяа салхи, нарны эрчим хүчний төслүүдийг нэр хүнд бүхий хөрөнгө оруулагчидтай хамтран санхүүжүүлэх 2023 он гэхэд нийт цахилгаан хэрэглээний 20%-г сэргээгдэх эрчим хүчнээс гаргах Засгийн газрын зорилтыг сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалтын ил тод, үр ашигтай тендэрийн ажиллагаа бий болгох замаар дэмжих	- Банкны дэмжлэгтэйгээр үйлдвэрлэсэн сэргээгдэх эрчим хүч MWh/жил тоогоор (<i>Суурь үзүүлэлт – 0</i>) - Үйл ажиллагааны түвшинд тодорхойлогдох сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалтын тендэрийн процессын зохицуулалтын орчин хүрээ сайжирсан байдал (чанарын үзүүлэлт) (<i>Суурь үзүүлэлт – N/A</i>)
Контекст үзүүлэлт: Хил дамнасан бизнес худалдаа хийх үзүүлэлт (Суурь үзүүлэлт 2017 оны эрэмбэ – 190 орноос 103; DTF – 66.89%) Нүүрсхүчлийн хий ялгаруулах нягтралын Δ (<i>Суурь үзүүлэлт 2014 – 1.59 kgCO₂/ 2010 ДНБ америк доллароор; IEA</i>)				

3.3 Орны стратегийг хэрэгжүүлэхэд гарч болзошгүй эрсдлүүд

Санал болгож буй Орны стратеги нь тус улсын хүчин чадал дээр тулгуурлаж байгаа бөгөөд ЖДҮ-ийн өрсөлдөх чадвар, санхүүжилтын дэд бүтцэд анхаарснаараа бодитой болсон гэж үзнэ. Гэхдээ ЕСБХБ-ны стратегиа хэрэгжүүлэх чадвар нь түүний хяналтаас гадуурхи хэд хэдэн хүчин зүйлийн нөлөөнөөс хамаарна. Боломж байгаа тохиолдолд, ЕСБХБ үйлчлүүлэгчид, олон улсын санхүүгийн түнш байгууллагууд, Засгийн газартай идэвхтэй, тогтвортой хамтран ажиллах замаар тийм эрсдлийг шийдвэрлэх, саармагжуулахын тулд ажиллана.

Стратегийг хэрэгжүүлэхэд гарч болзошгүй онцлог эрсдлүүдэд дараахь орж байна. Үүнд:

- **ОУВС-гийн хөтөлбөр хэрэгжүүлэх.** Макро эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал, өөрийн бондоо боломжийн хүүтэй дахин санхүүжүүлэх Засгийн газар, төрийн агентлагууд (Хөгжлийн банк зэрэг)-ын чадвар ОУВС-гийн хөтөлбөр хэрэгжих найдвар (credibility), хэрэгжих хурдаас дийлэнхдээ хамаарна. Хэрэв хөтөлбөр бүрэн хэрэгжихгүй байх, цагтаа хэрэгжихгүй байвал зах зээл засгийн газрын, эсвэл хагас засгийн газрын бондын дахин санхүүжилтэд оролцох сонирхолгүй болох нь мэдээж бөгөөд ингэвэл форексийн тогтвортой байдал, тус орны зээлжих зэрэглэл, төсвийн тэнцэлд нөлөө үзүүлнэ.
- **Түүхий эдийн үнийн цаашдын уналт.** Монгол нь түүхий эд, ялангуяа нүүрс, төмөр, алт, зэсийн үнээс өндөр хамааралтай. Нүүрсний үнэ улам унавал нүүрс экспортолдог олон компаниуд, мөн төлбөрийн балансад нөлөөлнө. Төмрийн үнийн бууралт арай бага нөлөөлөх боловч ЕСБХБ-ны үйлчлүүлэгч зарим компани, түүний дотор төмрийн хүдрийн экспортлогчдод үйлчилдэг түнш банкуудад ихээхэн дарамт болно. Алт, зэсний байдал муудах нь Оюу Толгойн хэрэгжилтэд саад учруулах магадлалтай бөгөөд энэ нь тус уурхайн хоёрдугаар үе шатны бүтээн байгуулалтад ханган нийлүүлэлт хийж байгаа үндэсний компаниудад нөлөөлнө.
- **Хөрөнгө оруулалтын орчин тогтворгүй байх.** Монголын хөрөнгө оруулалтын хуульд 2012 онд оруулсан өөрчлөлт тус орны хөрөнгө оруулалт татах чадварт ихээхэн нөлөөлсөн. Одоогийн гадаадын хөрөнгө оруулалтын хууль, мөн уул уурхайн хууль хөрөнгө оруулалтын орчинг сайжруулсан бөгөөд харин шинэ өөрчлөлт оруулбал тодорхойгүй байдал бий болгож, улмаар шинэ стратегиа ялангуяа уул уурхайн салбарт хэрэгжүүлэхэд ЕСБХБ-нд амин чухал хэвээр байгаа гадаадын хөрөнгө оруулалтад хохирол учруулж магадгүй юм. Хууль эрх зүйн орчин хүрээ сайжирсан боловч хууль тогтоомж, журам зохицуулалтыг нэг мөр бус, үзэмжээрээ хэрэглэж байгаа нь хөрөнгө оруулагч нарт, түүний дотор ЕСБХБ-нд нэмэлт эрсдэл учруулж байна.
- **Макро эдийн засгийн эрсдлүүд.** Тус улсын эдийн засаг удааширсан байдалд хүргэсэн гадаад дарамтад аажмаар зохицож байна. Гэхдээ, түүхий эдийн үнэ доогуур, Хятадын өсөлт удааширсан, АНУ, ЕХ-ны эдийн засаг сорилтуудтай тулгарсан байгаа нь өсөлтийг дарангуйлсаар байна. Үүний дээр, улс төрийн тогтворгүй байдал хэрэглэгч, бизнес болон хөрөнгө оруулагчийн итгэлд сөрөг нөлөө үзүүлсэн нь байдлыг улам хурцатгасан. Богино хугацаанд, тус орон өсөлтийг хангахын тулд түүхий эдийн экспортод голлон тулгуурласан хэвээр байх болно. Дотооддоо, банкны салбар асуудал болсон хэвээр байгаа бөгөөд тус салбарт урт

хугацааны төгрөгийн зээлийн эргэн төлөгдөх чадвар байхгүй, долларжилтын түвшин өндөр, өвлөгдөж ирсэн (улам өссөөр байгаа) найдваргүй зээл зэрэг асуудалтай тулгарч байна.

- **Үндэсний валютаар хийх санхүүжилтын олдоц хэвээр байх.** Төгрөг болон америк долларын хүүний хэмжээ өндөр хэвээр байгаа ба банкны санхүүжилтын өртөгт дарамт учруулж байна. Төв Банк нь дотоодын банкуудтай урт хугацааны, үнэ өртөг багатай своп тохиролцоо хийх боломжгүй болсон байна. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 12-р сарын 14-ний өдрийн А-341 дугаар тушаалаар “Урт хугацаат своп хэлцлийн журам” шинэчлэгдэн батлагдсан. Уг журмын хүрээнд МБ арилжааны банкуудтай урт хугацаат своп хэлцэл байгуулж байна. Бодлого чангалсан цаашдын аливаа алхам нь Банкны зүгээс дотоодын компаниуд, ЖДҮ-т олгох зээлийн ажиллагаанд болон/эсвэл монгол төгрөгөөр илэрхийлсэн нэмэлт бонд гаргах чадварт хүчтэй нөлөө үзүүлэх болно.
- **Банкны салбар дахь өсөн нэмэгдсэн зээлийн эрсдэл.** Тус Банкнаас илүү олон системийн банктай харилцах чадвар хязгаарлагдмал байгаа нөхцөлд өөрийн зээлийн хөтөлбөрөө одоогийн түнш санхүүгийн байгууллагууд, эсвэл хоёр дахь шатлалын банкуудаар дамжуулах шаардлагатай болно. Гэхдээ, тус Банкны зүгээс банкны салбарын доогуур шатлалын ийм банкуудтай харилцаад эхэлбэл зээлийн нэмэлт эрсдлүүд, жишээлбэл өндөр төвлөрөл, сүүлийн үед гарсан нэгдэл, худалдан авалт, бүтцийн өөрчлөлттэй холбоотой тайлан балансын гажуудал, тогтсон үйл ажиллагааны түүх байхгүй байх эрсдэл үүсч болох юм.

3.4 Банкны санал болгож буй үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн үр дагавар

Монгол улс өөрийн байрлал, уур амьсгал, уур амьсгалын өөрчлөлтийн боломжит нөлөөлөл үргэлжилсээр байгаа, мөн нийгэм-эдийн засгийн хүчин зүйлс, хурдац ихтэй трансформаци хийж байгаа зэрэгтэй холбоотой байгаль орчин, нийгмийн хэд хэдэн сорилтуудтай тулгарч байна. Гол хотууд, ялангуяа Улаанбаатар хот дахь хүн амын өсөлт хөдөө орон нутгаас бөөн бөөнөөр шилжин ирэгсдээс болж хурдан нэмэгдэж байгаа явдал нь хотын байгаль орчны найдвартай дэд бүтэц хөгжүүлэхэд асуудал үүсгэж байна. Дэд бүтцийн асуудлуудын дээр, хотжилт нь мөн гол хотуудын агаарын чанарт ноцтой сөрөг нөлөө үзүүлж байна. Энэ нь төвийн системээс дулаан, цахилгаан үйлдвэрлэхдээ нүүрс хэрэглэж байгаагаас, мөн олонхи хотын захад төвлөрсөн, хот руу шилжин ирэгсэд тус тусын нүүрс хэрэглэдэг зуухтай гэр хорооллоос үүдэлтэй юм. Эдгээр асуудалтай холбоотой хүний эрүүл мэндийн ноцтой үр дагавар гарч байгаа бөгөөд тус Банк үйлдвэрлэгчид, засгийн газар, олон улсын санхүүгийн бусад байгууллагатай хамтран, төсөл, техник хамтын ажиллагааны санаачилгуудаар дамжуулан шийдэл олох талаар ажиллах болно.

Одоогийн стратеги дахь эдгээр гурван сэдэв тус бүр Банкны зүгээс тус оронд ажиллахад үзүүлж болох бөгөөд төслийн хэрэгжилттэй холбоотой шаардлагуудын утгаар болон тус Банкнаас Монголд тавьж буй шилжилтийн зорилтуудыг урагшлуулахад шаардлагатай ТХА-ны дэмжлэг, бодлогын яриа хэлэлцээний утгаар байгаль орчин, нийгмийн үр дагавар агуулж байгаа болно.

- Олборлох бус салбарын тэсвэрлэх чадвар, үр ашгийг сайжруулах ажил нь Монгол дахь үйлдвэрлэл, бизнесийн онцлог мөн чанараас болж ЖДҮ-ийн

салбарт төвлөрөх болно. Энэ салбар дахь үйлчлүүлэгчдийн байгууллагуудын доорхи байгаль орчин, нийгмийн эрсдлийн менежмент чадавхийг бий болгох нь гол зорилго байх бөгөөд төслийн түвшинд ТХА-ны дэмжлэг шаардаж болно.

- Уул уурхайн салбарыг ашиглах явдал биологийн төрөл зүйл, орон нутгийн хүн ам, түүний соёлын өв зэрэг байгаль орчны хэрэглэгдэхүүнд ихээхэн эерэг болон сөрөг потенциал нөлөөтэй цогц төслүүд боловсруулж хэрэгжүүлэхэд хүргэдэг. Тус Банк ийм төслүүдийн талаар одоо ихээхэн туршалагтай болсон бөгөөд тийм эрсдэл, бололцоонуудтай ажиллах саармагжуулах арга хэмжээнүүд, стратеги боловсруулсан байгаа. Энэ талаар дор илүү тодорхой тайлбарласан.
- Тогтвортой дэд бүтэц хөгжүүлэх явдал Хот газрын байгаль орчны дэд бүтэц, тээврийн салбарыг хамруулдаг бөгөөд түүнд, тухайлбал ус хангамж, хаягдал ус цэвэршүүлэх, хатуу хаягдал цуглуулах, боловсруулах, хаях, авто болон төмөр зам барих, ажиллуулах зэрэг багтдаг. Тийм төслүүд хэрэгжүүлэхэд Банкны Байгаль орчин, нийгмийн харилцааны бодлого ашиглахыг шаарддаг байгаль орчин, нийгмийн эрсдлүүд байх нь мэдээж бөгөөд Засгийн газартай яриа хэлэлцээ өрнүүлэх, зохицуулагч байгууллагын дотор чадавхи бий болгох зэрэг сорилтууд бас тулгарна. Хатуу хаягдлын салбарт аль хэдийнэ боловсруулж эхлээд байгаа ТХА-ны дэмжлэг бүх дэд салбарууд дахь дээрх сорилтуудыг шийдвэрлэхэд шаардлагатай болно.

Эрчим хүчний салбарт, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх шинэ хүчин чадал бий болгох, түүний дотор нүүрсээр ажилладаг станц байгуулахад хөрөнгө оруулах асуудлыг авч үзэх хүсэлт тус Банкинд ирж магадгүй. Банкны аливаа үнэлгээг олон улсын санхүүгийн бусад байгууллага, доноруудтай хамтран хийх бөгөөд үүнд альтернатив боломжууд, нүүрсхүчлийн хийг хураан авч хадгалах боломж үндэслэлийг багтаана. Мөн тийм үнэлгээ нь Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн иж бүрэн үнэлгээ (“ESIA”), түүний дотор олон нийтийн оролцоот мэдээллийн ил тод байдал, зөвлөлдөх процессын дагуу хийгдэх ёстой. Дээр нь нүүрсээр ажиллах аливаа цахилгаан үйлдвэрлэлийг Банкны зүгээс санхүүжүүлэх нь 2013 оны Эрчим хүчний салбарын стратегид нийцсэн байх ёстой.

Монгол улсад биологийн төрөл зүйлийн үнэ цэнэ бүхий хуулиар хамгаалагдсан, олон улсын хэмжээнд үхлээн зөвшөөрөгдсөн нутаг дэвсгэрийн талаар гарсан хэд хэдэн санаачилга бий. Эдгээрт Тусгай хамгаалалтын нутаг, Шувууны чухал нутаг зэрэг улс орон даяар тархсан, ялангуяа Говь нутагт оршдог газар ордог бөгөөд тэнд байгалийн нөөц олборлох хэд хэдэн төсөл хэрэгждэг, цаашид ч хэрэгжих болно. Тусгай хамгаалалтын нутгийн статустай нутаг дэвсгэр орчимд ЕСБХБ-ны санхүүжилт авах асуудал яригдаж байгаа төслүүдийг хэрэгжүүлэхдээ аймаг болон төв засгийн газрын түвшний холбогдох эрх баригчидтай зөвлөлдөж, сөрөг нөлөөний эрсдлийг аль болох багасгах, хүч чармайлтаа нэгтгэх, хамтран ажиллах боломжуудыг эрэлхийлж ажиллах шаардлагатай. Тийм хүчин чармайлт нэгтгэх, биологийн төрөл зүйлийг сэргээн бий болгох ажлыг эрчимжүүлэхэд чиглэсэн санаачилгыг янз бүрийн түвшинд дэмжихэд ТХА-ны хөрөнгийг ашиглаж болно. Тус Банк бүс нутгийн түвшинд тийм чадавхи бий болгох санаачилгыг нилээд хэдэн жилийн туршид дэмжиж ажилласан бөгөөд үүнийгээ боломж гарвал бүс нутаг болон орон нутгийн аль аль түвшинд үргэлжүүлэх нь зүйтэй.

Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэнд (OSH)-ийн асуудал аливаа төслийн үнэлгээ хийхдээ ЕСБХБ-наас нягтлан авч үздэг нэг чухал хэсэг юм. Монгол Улс ОУХБ-ын Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндийн холбогдолтой зөвхөн 2 конвенцид нэгдэн орсон бөгөөд ерөнхий OSH, уул уурхайн хамааралтай бусад гол

конвенциуд, тухайлбал барилгын холбогдолтой конвенцид нэгдэж ороогүй байна. Авто замын аюулгүйн стандартуудыг сайжруулах шаардлагатай бөгөөд автын осол гарах нь нийтлэг болоод байна. ДЭХБ-ын тооцоогоор 100,000 хүн ам дутамд ногдох автын ослоор жилд нас барагчдын тоо 21 (дэлхийн дундаж нь 17), авто замын аюулгүй байдлын хууль тогтоомжийг хатуу биелүүлэх байдлаар тус орон (нийт 10 түвшнээс) 3 дугаар түвшинд эрэмбэлэгдсэн байна. Хуулийг хатуу биелүүлэх, техникийн мэдлэг олгох талаархи институцийн чадавхи ийм сул байгаа нь аж үйлдвэрийн олон салбарт бас тэмдэглэгдсэн байна. Хэрэгтэй гэж үзвэл, ЕСБХБ замын аюулгүй байдлыг сайжруулахад нь нутаг дэвсгэр, үйлчлүүлэгчиддээ ТХА-ны хөрөнгөөр дэмжлэг үзүүлэх талаар судалж үзнэ. Ялангуяа нийтийн үйлчилгээний авто хэрэгсэл, ажлын байртай холбоотой замын эрсдлийг анхаарч үзнэ.

Ажил эрхлэлтийн хуулийн тухайд гэвэл Монгол Улс ОУХБ-ын үндсэн 8 конвенцид бүгдэд нь нэгдэн орсон бөгөөд дотоодын хууль тогтоомжоо тэдгээр конвенцид нийцүүлэх арга хэмжээнүүд авсан байна. Энэ чиглэлээр Хүний наймаатай тэмцэх тухай хууль, Хүйсийн тэгш байдлын тухай хууль, Төрийн ажил эрхлэлтийн тухай хууль зэрэг хууль тогтоомж бааталсан буюу өөрчлөлт шинэчлэлт оруулсан байна. Гэхдээ ажиллагсдын шударга ёсонд хандах эрх, ялангуяа ажил эрхлэлтийг цуцлахтай холбоотой суурь эрхийг тойрсон асуудлууд оршсоор байгаа ба Хөдөлмөрийн тухай хуулинд тухайлбал нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай. Хөдөлмөрийн мэргэжлийн хяналтын газарт ажил үүргээ гүйцэтгэх чадавхи, статистик тоо мэдээ дутмаг байдаг боловч 2015 оны 12 дугаар сард Эрүүгийн хуулинд оруулсан өөрчлөлт, Хөдөлмөрийн хуулинд оруулахаар санал болгож буй нэмэлт өөрчлөлтөөс харахад Монгол Улс хөдөлмөрийн салбар дахь засаглалаа олон улсын стандарт, хэм хэмжээд нийцүүлэхийг эрмэлзэн ажиллаж байна. Эмэгтэйчүүд ажиллаж болох боловч ажлын байрны тодорхойлолтоор хүйсээр ялгаварлан гадуурхах заалтууд хууль тогтоомжид байсаар байна. Европын Холбоо GSP+ схемийн хүрээнд Монгол Улс олон улсын холбогдох конвенцийн дагуу авсан заавал тайлагнах үүргээ хэрхэн биелүүлж байгаад мониторинг хийсээр байх болно. ЕХ-ны санхүүжүүлж байгаа «Монголд ажлын байр бий болгохыг дэмжих» (SECiM) хэмээх төсөлд 2015 оны 5 дугаар сард гарын үсэг зурсан бөгөөд холбогдох техник тусламжийг Хөдөлмөрийн яаманд 2016 оны эхний улирлаас эхлүүлсэн байх учиртай. Энэхүү техникийн тусламж нь хөдөлмөрийн зах зээлийн ажиллагааг сайжруулах, чанаартай ажил эрхлэлтийг бэхжүүлэхэд нь Засгийн газарт туслах юм.

Монголын хүн амын гуравны нэг орчим нь амьдарч аж төрөхийн тулд мал маллах ажил эрхэлж байгаа бөгөөд газар хувьчлан авах төслүүд хэдий улс орны зах хязгаарт, эсвэл бэлчээрийн даац хэтэрсэн газарт байлаа ч гэсэн малчдын амьжиргаанд нөлөө үзүүлэх байдалтай байна. Одоогоор газрын холбогдолтой дарамт нийслэл хот болон түүний эргэн тойронд, мөн Өмнөд Говь зэрэг хурдацтай хөгжиж байгаа бүс нутагт төвлөрч байна. Бэлчээр, устай холбоотой хуримтлагдсан дарамт шахалтыг сайтар ойлгох шаардлагатай бөгөөд газар, ус, мал маллагааны тогтвортой менежментийн хэрэгцээнд хандах хамтын хандлагыг тодорхойлж, төслийн холбогдолтой хэрэгжилтэд нэвтрүүлэх шаардлагатай.

Монголын олборлох салбарт ЕСБХБ-ны оролцоо үргэлжилж байгаа бөгөөд байгаль орчин, нийгмийн харилцааны байр сууринаас онцгой анхаарал тавих шаардлага байна. Үүнд, олон улсын сайн практикт нийцүүлэх, талуудын ил тод оролцоог хангах явдал чухал байх болно. Усны нөөц, хаягдлын менежмент, билогийн төрөл зүйл, нутгийн иргэдэд үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой эрсдлүүдийн харилцан үйлчлэлийн утгаар тус

орон Банкны хувьд онцгой ажиллах орчин болж байна. Ялангуяа, ЕСБХБ нь усны нөөц, менежментийн асуудлуудаар (бусад ОУСБ-уудтай хамт) засгийн газар, орон нутгийн удирдлага, салбарын холбоод (Монголын уул уурхайн ассоциаци), хувийн хэвшилтэй хамтран ажиллаж байна. Монгол дахь усны нөөц, хүртээмжийн онцгой нөхцөл байдал (зарим нутагт ус ихтэй боловч заримд нь туйлын дутмаг байна)-ын улмаас цаашид үргэлжлүүлэн оролцох нэг чухал чиглэл мөн бөгөөд тус орны Засгийн газар үндэсний түвшинд усны урт хугацааны төлөвлөлт хийж байгаа өнөө үед тэргүүлэх асуудлууд дээр техник хамтын ажиллагааны хөрөнгө ашиглан ажиллах болно.

Монгол орон соёлын баялаг өв уламжлалтай бөгөөд түүнийг хамгаалах шаардлагатай. Тиймээс ногоон талбайн дэд бүтцийн төслүүд, барилга байгууламжийн ажлыг холбогдох эрх баригчид, нөлөөлөлд орсон иргэдтэй зөвлөлдөн гүйцэтгэх ёстой бөгөөд боломжит сөрөг нөлөөллөөс зайлсхийх буюу саармагжуулахад шаардлагатай арга хандлагыг бодож боловсруулах нь зүйтэй.

Шийдвэр гаргах явцад талуудын санал, тэргүүлэх чиглэлүүдийг ойлгож, тусгасан байхын тулд талуудын өндөр түвшний оролцоог хангаж ажиллах зорилгоор тус Банк өөрийн үйлчлүүлэгчиддээ нийцсэн техникийн дэмжлэг, чадавхийг бэхжүүлэх ажил дээр мониторинг, судалгаа хийж байх болно.

3.5 ЕСБХБ-наас бусад олон талт хөгжлийн банкуудтай хамтран ажиллах нь

Хэдийгээр тус Банкны санхүүжилтын багц 100% хувийн хэвшилд байршиж байгаа боловч Монголд хөрөнгө оруулалт, бодлогын яриа хэлэлцээний аль алинаар нь бусад ОУСБ-уудтай нягт хамтран ажиллаж байна. Тус Банкыг Монголын хувийн хэвшлийг дэмжсэн хамгийн идэвхтэй ОУСБ гэж эрх баригчид болон бусад хандивлагчид үнэлдэг юм.

Бид одоогийн ОУСБ-уудтай хамтын ажиллагааг үргэлжлүүлэх бөгөөд шинээр байгуулагдсан Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк (АИВ)-тай хамтарсан санхүүжилт хийх боломжид нээлттэй байх болно.

Санхүүгийн салбарт, Олон улсын санхүүгийн корпораци (IFC), Азийн хөгжлийн банк (ADB) болон Нидерландын Хөгжлийн санхүүжилтын компани (Financierings-Maatschappij voor Ontwikkelingslanden – FMO) дотоодын банкууд, ББСБ-уудад хувь хөрөнгө оруулалт хийж, зээлийн шугам ажиллуулдаг ба мөн БЖДҮ-ийн газруудыг ЕСБХБ-ны хажуугаар хувь хөрөнгийн сангаар дэмждэг. Европын Холбоо (ЕХ) өөрийн Азийн хөрөнгө оруулалтын механизмын хүрээнд Монгол улсад **ЖДҮ-ийн хөгжлийн** асуудлаар идэвхтэй ажилладаг бөгөөд 9,3 сая еврогийн өртөг бүхий хамтын санхүүжилт, техник хамтын ажиллагаа, жижиг бизнесийн дэмжлэгийн төслүүд хэрэгжүүлж байна (ASB-г 2019 хүртэл санхүүжүүлнэ).

Компанийн салбарт, тус Банк ОУСК-тай хамтран хэд хэдэн төсөл, түүний дотор нэг том уурхай, эмнэлэг, нилээдгүй агробизнесийн төслүүд санхүүжүүлсэн. ЕСБХБ ОУСК-тай хамтран хувийн хэвшлийн томоохон төслүүдийн эрсдэл хуваалцах боломжуудыг эрэлхийлэн ажиллах болно. ЕСБХБ-ны зэрэгцээ, АХБ, Дэлхийн Банк, ОУСК нь **хөрөнгө оруулалтын орчны** асуудлаар хамгийн идэвхтэй ажилладаг ОУСБ-ууд юм. ОУСК 2016 онд хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хуулийн төслийг боловсруулж дууссан бол АХБ төрийн эзэмшлийн аю ахуйн нэгжүүдийн компанийн засаглалыг гол

төлөв дэмжиж ажиллаж байна. Тус Банк өөрийн бодлогын яриа хэлэлцээгээ АХБ, ОУСК-тай нягт уялдуулан ажиллаж, ялангуяа хөрөнгийн зах зээл, зээлийн товчооны хөгжлийн асуудлаар хамтран ажиллана.

Сэргээгдэх эрчим хүчний салбарт, ЕСБХБ Японы Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (JICA) болон FMO-тэй түншлэн ажиллаж байна. ЕСБХБ бүс нутагт болон дотооддоо хэлхээ холбоог сайжруулах зорилготой бөгөөд засгийн газрын зээлийн хүрээнд хэрэгжих хот суурин газрын болоод тээврийн **дэд бүтцийн томоохон төслүүд** дээр АХБ-тай хамтран ажиллахыг эрмэлзэнэ. Тус Банк АДБХОБ (АИВ)-тай дэд бүтцийн төслүүдийг хамтран санхүүжүүлэх боломжийг ашиглаж болох юм. Мянганы сорилын корпораци (МСС) хот газрын дэд бүтцэд төвлөрсөн 2018 оны шинэ Компакт гэрээ байгуулбал, тус Банк засгийн газрын болон дамжуулан зээлдүүлэх зээлийн хөрөнгийг МСС-ийн хөрөнгөтэй хүч хавсарган ажиллахыг зорино.

ХАВСРАЛТ 1 – УЛС ТӨРИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан нөхцөл, шаардлагыг Монгол Улс хангасан хэвээр байна.

Шилжилтийн үеэс хойш 20 гаруй жилийн хугацаанд тус улс олон ургальч ардчилал болон нээлттэй зах зээлийн эдийн засгийг цогцлоох замналд ихээхэн дэвшил гаргаад байна. Монгол Улс ардчилсан (эрх чөлөөг) дээдэлсэн Үндсэн хуультай бөгөөд улс төрийн намын өрсөлдөөнт системийг хөгжүүлж, хүчтэй иргэний нийгмийг цогцлоогоод байна. Өргөн хүрээний сэдвийг хөндөх хэвлэлийн эрх чөлөө тус улсад хангагдсан бөгөөд хуулийн засаглалыг мөрдлөг болгож, хүний эрхийг дээдлэх чиглэлээр ихээхэн амжилт гарч байгаа ч шийдлээ хүлээсэн олон сорилт бэрхшээл мөн оршсоор байна.

Түүхий эдийн үнийн уналт, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийн сулрал болон хөрш улсуудынх нь эдийн засгийн хөгжлийн хурдац саарсан зэрэг шалтгаанаас улбаатай эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлыг тогтворжуулах нь шинэ Засгийн газрын өмнө тулгарч буй томоохон сорилт болж байна. Тус улсын ямар ч засгийн газрын хувьд урт хугацаанд шийдвэрлэх гол сорилт нь байгалийн баялгаас олсон орлогыг нээлттэй, зөв зохистой хуваарилж, ядуурлын түвшин бууруулах явдал юм.

Чөлөөт сонгууль, төлөөллийн засаглал

Чөлөөт, шударга болон өрсөлдөөнт сонгууль

Үндсэн хуулиар бүх ард түмнээс сонгогдсон ардчилсан засаглалыг хуульчилсан.

Монгол Улсын сонгуулийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, 2015 онд батлагдсан Сонгуулийн тухай хууль, 2006 онд батлагдсан Сонгуулийн төв байгууллагын тухай хууль, 2011 онд батлагдсан Сонгуулийн автомат системийн тухай хууль болон Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан дүрэм, журам зэрэг эрх зүйн актаас бүрдэнэ. 2015 оны 12 дугаар сард батлагдсан сонгуулийн тухай шинэ хууль нь сонгуулийн асуудлаарх олон хуулийг нэгтгэсэн ихээхэн дэвшилтэт хууль болсон хэмээн Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын Ардчилсан институт, хүний эрхийн албаны Олон улсын сонгууль ажиглагчдын баг болон Европын Парламент тэмдэглэсэн.³ Хэдий тийм ч 2016 оны 5 дугаар сард гаргасан шийдвэрийн дагуу сонгуулийн холимог системийг мажоритар систем болгон өөрчилсөн нь сонгогчдын дунд талцал үүсгэж, нэг мандаттай 76 тойрог тус бүрд хүчтэй нэр дэвшигч дэвшүүлэх боломжгүй улс төрийн жижиг намуудын парламентад суух боломжийг үндсэндээ хязгаарласан.

2016 оны 6 дугаар сард болсон парламентын сонгууль ихээхэн өрсөлдөөнтэй, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг мөрдлөг болгосон бөгөөд тус улсын дийлэнх хэсэгт сонгуулийн үйл ажиллагаа зохих хэлбэрээр явагдсан хэмээн ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн албаны Олон улсын сонгууль ажиглагчдын баг дүгнэсэн.⁴ Улс төрийн гол сөрөг хүчин байсан МАН уг сонгуулиар үнэмлэхүй ялалт байгуулж 65 суудал авсан бол АН 9

³ OSCE/ODIHR, International Observation Mission, Mongolia - Parliamentary Elections, Statement of Preliminary Findings and Conclusions, 29 June 2016, p.1

⁴ OSCE/ODIHR, International Observation Mission, Mongolia - Parliamentary Elections, Statement of Preliminary Findings and Conclusions, 29 June 2016, p.2

суудалтай болж, үлдсэн хоёр суудал нь Монгол ардын хувьсгалт нам (МАХН) болон бие даан нэр дэвшигчид оногдсон.

Ерөнхийлөгчийн сүүлийн сонгууль 2013 оны 6 дугаар сард болсон бөгөөд АН-аас нэр дэвшигч Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хоёр дахь удаагаа уг албан тушаалд сонгогдсон. Хэдийгээр хангалттай хэмжээний мэдээллийг сонгогчдод түгээх боломжийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хуулиар олгоогүй ч тус сонгуулийн сурталчилгааны кампанит ажил өрсөлдөөнтэй хийгээд үндсэн эрх чөлөөг хүндэтгэсэн уур амьсгалд болж өнгөрсөн хэмээн ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн албаны Олон улсын сонгууль ажиглагчдын баг дүгнэсэн.⁵

Засаглалын эрх мэдлийн хуваарилалт

Монгол Улс нь ардчилсан, бүгд найрамдах засаглалтай, төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс юм. Төрийн тэргүүн нь Ерөнхийлөгч бөгөөд 4 жилийн хугацаагаар бүх ард түмнээс шууд сонгогддог. Ерөнхийлөгчийг 1 удаа улируулан сонгож болохыг Үндсэн хуульд тогтоосон. Ерөнхийлөгч хуульд хориг тавих эрхтэй ч парламентын чуулганд сууж буй гишүүдийн гуравны хоёр нь ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авахгүй тохиолдолд тухайн хууль, тогтоол хүчин төгөлдөр үйлчилдэг. Засгийн газрын тэргүүн нь Ерөнхий сайд. Хууль тогтоох бүх эрх мэдэл 4 жилийн хугацаагаар бүх ард түмнээс сонгогддог 76 гишүүнээс бүрдсэн 1 танхим бүхий парламент болох УИХ-д бий. Шүүх засаглал ерөнхийдөө хараат бус боловч авлигын асуудал анхаарлын төвд байдаг.

Хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх засаглалын эрх мэдлийн хуваарилалтыг Үндсэн хуулиар зааглан тогтоосон. 1992 оны Үндсэн хуульд засаглалын хуваарилалтыг ийнхүү тодорхойлсон хэдий ч 2000 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр парламентын гишүүн засгийн газрын гишүүн байх эрхтэй болсон. Үүний дүнд Засгийн газарт хэт их эрх мэдэл төвлөрч, улмаар парламентын эрхийг хязгаарлаж байна хэмээх хүчтэй мэтгэлцээн 2014 онд парламентын гишүүдийн дунд өрнөсөн. Хэдий тийм ч УИХ Засгийн газарт хяналт тавих үүргээ амжилттай биелүүлж буй бөгөөд засгийн газрын гишүүд буюу сайд нарыг тогтмол дуудаж, сонсгол хийж байна.

Сонгогдсон албан тушаалтны засаглах бүрэн эрх

Сонгогдсон албан тушаалтан аливаа саад тотгоргүйгээр засаглах эрхээ хэрэгжүүлэх өргөн боломжтой.

Цэрэг, арми ард түмний хатуу хяналт доор байх бөгөөд улс төрийн шийдвэр гаргах үйл явцад төдий л оролцдоггүй.

Иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл болон иргэдийн оролцоо

Иргэний нийгмийн хүрээ, хараат бус байдал

Монгол Улс 1990 оны эхэн үед коммунизмаас олон ургальч ардчилсан нийгэмд шилжихэд иргэний нийгэм ихээхэн чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд өдгөө тус улсад харьцангуй зохион байгуулалт сайтай, хүчтэй иргэний нийгмийн тогтолцоо хөгжиж байна. Иргэний нийгмийн дийлэнх байгууллага Улаанбаатар хотноо төвлөрдөг.

⁵ OSCE/ODIHR, Presidential Election 26 June 2013, Mongolia, Election Observation Mission Final Report, 18 September 2013, p. 1

Санхүүгийн дэмжлэг багатай хийгээд мэдээллийн дутмаг байдлаас шалтгаалж малчид, хөдөөгийн ард иргэд иргэний нийгмийн бүлгүүдэд төдий л хамрагдаж чаддаггүй. Харин байгаль орчны асуудлыг үйл ажиллагааныхаа үндсэн чиглэл болгосон иргэдийн идэвхтэй хөдөлгөөн өдгөө хөдөө орон нутагт өрнөх болсон. Уул уурхайн салбарын үйл ажиллагаа идэвхжихийн хэрээр байгаль орчны хамгааллын асуудлаарх сонирхлын бүлгүүдийн тоо өсч байна.

Хүний эрх, эмэгтэйчүүдийн эрхийг дээдэлсэн иргэний нийгмийн байгууллагууд идэвхжиж, түншлэлийн сайн харилцаа хөгжүүлэхийн хамт бодлого тодорхойлогчид, хууль тогтоогчдод нөлөөллөө үзүүлж байна. Иргэний нийгмийн байгууллага болон төрийн байгууллагын хамтын ажиллагааны үр дүн нь тухайн төрийн албан хаагчийн хувийн хандлага болон иргэний нийгмийн байгууллагын төрлөөс ихээхэн хамааралтай байдаг. Иргэний нийгмийн байгууллагын харилцааг зохицуулсан хууль тогтоомж нь харьцангуй ардчилсан (либерал) болов ч Төрийн бус байгууллагын тухай хуулийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын зүгээс зарим хэлбэрээр гажуудал үүсгэх тохиолдол гардаг.

Цензургүй, хараат бус олон ургальч мэдээлэл

Хэвлэл, мэдээллийн салбар тод томруун хөгжиж буй бөгөөд өргөн хүрээний асуудлыг нийтэд чөлөөтэй түгээх эрхтэй. Хэдий тийм ч хэвлэл мэдээллийн зарим хэрэгсэл улс төрчдөөс хараат байгаа ба цахим мэдээллийн үйл ажиллагаанд тавьсан зарим хоригийг цаашид хэрхэх нь тодорхойгүй хэвээр байна. Үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хуулиар баталгаажуулсан хэдий ч улс төрчдийн зүгээс дарамт үзүүлэх болон хэрэглэгч цахим хуудсанд сэтгэгдэл бичих эрхэнд зарим хязгаарлалт тогтоох зэрэг гажуудал байгааг онцлох нь зүйтэй. Салбарын үйл ажиллагааг Харилцаа холбооны зохицуулах хороо чиглүүлэх бөгөөд уг хорооны гишүүдийг Засгийн газраас томилдог.

1998 онд хүчин төгөлдөр болсон Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар төр хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглосон. Ихэнх хэвлэл мэдээллийн хэрэгсэл шууд болон шууд бус байдлаар улс төрчдийн мэдэлд байдаг бөгөөд нийтлэлийн бодлогод нь улс төрчдийн нөлөөлөл тусдаг. Парламентын сүүлчийн сонгуулийн үеэр хэвлэл, мэдээллийн хэрэгсэл сонгуулийн мэдээллийг хангалттай хэмжээнд түгээж байсан ч улс төрчдөд илүү боломж олгосноор мэдээллийн тэнцвэрт байдлыг хангах үүрэг хариуцлагаа умартсан хэмээн ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн албаны Олон улсын сонгууль ажиглагчдын баг дүгнэсэн.⁶

Мэдээлэл түгээх 300 орчим радио, телевизийн суваг, сонин, сэтгүүл Монголын хэвлэл, мэдээллийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй бөгөөд тэдгээрээс телевизийн сувгууд мэдээллийн үндсэн эх сурвалж нь болж байна. Хэвлэл, мэдээллийн олон улсын сувгууд, хэвлэмэл болон дамжуулалтын хувийн өмчит хэвлэл, мэдээллийн хэрэгслийн тоо орон даяар өсч байгаа ч төрийн өмчит Монголын үндэсний олон нийтийн телевиз хөдөө, орон нутагт мэдээллийн үндсэн эх сурвалж болж байна. Интернет хэрэглэгчдийн тоо хурдацтай өсч буй бөгөөд 2009 онд Монголчуудын 10 хувь нь интернет ашиглаж байсан бол 2015 онд 21.4 хувьд хүрчээ.⁷ 2016 оны парламентын сонгуулийн үеэр улс төрчид сурталчилгаандаа цахим сүлжээг өргөнөөр ашигласан.

⁶ OSCE/ODIHR, International Observation Mission, Mongolia - Parliamentary Elections, Statement of Preliminary Findings and Conclusions, 29 June 2016, p.10

⁷ International Telecommunication Union (ITU) Statistics, "Percentage of Individuals Using the Internet," 2000-2015

Төрийн болон улс төрийн байгууллагын үйл ажиллагаанд оролцох олон арга хэлбэр

Засгийн газрын хэрэглээний зардал ил тод байх ёстойг хуулиар тогтоосон. Засгийн газрын хөрөнгийг зарцуулах эрх бүхий албан тушаалтан зарлагын тайлан болон аудитын шалгалтын дүнгээ харьяа яамныхаа цахим хуудсанд байршуулах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн сангийн хөрөнгийг зөв зохистой зарцуулах, төсвийн зарцуулалтын удирдлагын талаарх шийдвэр, үйл ажиллагааг ил тод хэрэгжүүлэх, түүнд олон нийтийн хяналт тавих боломж олгох зорилгоор УИХ 2014 онд Төсвийн ил тод байдлын тухай (Шилэн дансны тухай хууль хэмээн нийтээр нэршиж заншсан) хуулийг баталсан. Уг хууль 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж буй бөгөөд хуулийн дагуу төрийн бүх байгууллага, төрийн өмчит аж ахуй нэгж төсвийн болон санхүүгийн холбогдолтой мэдээллээ олон нийтэд нээлттэй болгох үүрэгтэй юм.

Улс төрийн нам байгуулах, сөрөг хүчин байх эрх чөлөө

Монгол Улс нь олон намын харьцангуй сайн хөгжсөн системтэй бөгөөд сөрөг хүчний намууд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Хараат бус, бие даасан улс төрийн нам байгуулах хууль, эрх зүйн зохицуулалт мөрдөгдөж байна. Тус улс дахь улс төрийн үйл явц МАН, АН хэмээх улс төрийн хоёр гол хүчний үйл ажиллагаагаар үндсэндээ тодорхойлогдож ирсэн бөгөөд уг хоёр нам парламентад харилцан олонх, цөөнх болж ирсэн. Улс төрийн намууд гишүүн элсүүлэх, төрийн албан тушаалын төлөө кампанит ажил явуулах эрхтэй. Засгийн газрын санаачилгыг эсэргүүцэх эрх хуулиар баталгаажсан бөгөөд амжилттай мөрдөгдөж байна.

25 нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай иргэн парламентын сонгуульд нэр дэвших эрхтэй. Парламентын сүүлийн сонгуульд улс төрийн 12 нам, 3 эвсэл Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлэн оролцсон. Бүгд 498 нэр дэвшигч бүртгүүлснээс 69 нь бие даагчид байсан ба МАН, АН хоёр л сонгуулийн бүх тойрогт нэр дэвшигчдээ өрсөлдүүлсэн.⁸

Өдгөө тус улсын парламентад МАН 65, АН 9, МАХН 1 суудалтай ба бие даан сонгогдсон 1 гишүүн бий.

Хуулийн засаглал ба шударга ёсны эрх

Хуулийг дээдлэх ёсон/ хууль бүхнээс дээгүүр байх зарчим

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно хэмээн заасан байдаг.

Иргэн бүр шударга шүүхээр шүүлгэх, албан хүчээр баривчлан саатуулагдахгүй байх эрхтэй.

⁸ OSCE/ODIHR, International Observation Mission, Mongolia - Parliamentary Elections, Statement of Preliminary Findings and Conclusions, 29 June 2016, p.7-8

Цаазаар авах ялыг халах зэрэг олон чухал заалттай Эрүүгийн шинэ хуулийн үйлчлэлийг (2017 оны зун хүртэл) хойшлуулсан асуудлаар Европын Холбоо болон олон улсын засгийн газрын бус байгууллагууд сэтгэл зовниж байгааг илэрхийлж байсан болно.

Шүүх засаглалын бие даасан байдал

Үндсэн хуулиар шүүх засаглалын бие даасан байдлыг хуульчилж, хараат бус байх нөхцөлийг тодорхойлсон. Гэвч иргэний нийгмийн байгууллагууд, иргэдээс шүүх засаглалтай холбоотой авлигын асуудлыг хурцаар тавьж хөндсөөр байдаг.

Шүүх засаглалтай холбоотой хууль тогтоомж нь Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн захиргааны тухай хууль, Иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулиас бүрддэг. Шүүх засаглал нь улс төрийн аливаа нөлөөлөл, танил талаа харж үзэх байдал зэрэгт өртөмтгий байдаг тул Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх шаардлагатай хэмээн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ) тодорхойлсон байна. Шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс санал болгосны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч байнгын хугацаагаар сонгон томилдог. Дээд шүүхийн шүүгчдийг сонгон томилохдоо эхлээд Улсын Их Хурлаар хэлэлцэнэ. Ерөнхийлөгч ШЕЗ-өөс оруулсан саналтай санал нэгдэхгүй бол нэр дэвшигчийг буцааж болно. Түүнчлэн ШЕЗ-ийн бүх гишүүнийг Ерөнхийлөгч томилдог тул ШЕЗ-ийн бүтцийг олон улсын стандартад нийцүүлэх шаардлагатайг ЭЗХАХБ зөвлөмж болгосон.⁹

Засгийн газар, иргэн хуулийн өмнө адил тэгш эрхтэй

Иргэн бүр шударга шүүхээр шүүлгүүлэх эрхтэй ба төрийн албан хаагч ч бай хууль зөрчсөн бол хариуцлага хүлээх талаар хууль тогтоомжид заасан. Хэдий тийм ч хууль зөрчсөн, авлига, хээл хахуульд холбогдсон албан хаагч бодит байдал дээр ихэнх тохиолдолд зохих ял шийтгэлээ хүлээхгүй өнгөрөх явдал гардаг.

Авлигаас урьдчилан сэргийлэхэд үр дүнтэй бодлого, институц

Авлигатай тэмцэх асуудал төрийн байгууллагын бүх шатанд хурцаар тавигдаж байна. Авлигын хэргийг эрүүгийн гэмт хэрэгт тооцох тухай олон улсын стандартад Монголын эрүүгийн хэргийн хууль тогтоомж нийцэхгүй байгаа талаар ЭЗХАХБ дүгнэсэн.¹⁰ Идэвхтэй болон идэвхгүй хэлбэрийн авлигын гэмт хэргийг олон улсын стандартын түвшинд нийцүүлэх үйл ажиллагаа Эрүүгийн гэмт хэргийн тухай хуулийн шинэчлэлтэй холбоотойгоор удаашралтай байгаа талаар ЭЗХАХБ 2016 оны 10 дугаар сарын явцын тайландаа тэмдэглэсэн.¹¹

Авлигатай тэмцэх газар (АТГ) нь авлига, хээл хахуулийн гэмт хэрэгтэй тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулах, олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах эрх бүхий үндсэн субъект юм. Авлигын эсрэг

⁹ OECD, Anti-Corruption Reforms in Mongolia, Joint First and Second Rounds of Monitoring of Istanbul Anti-Corruption Action Plan, report adopted on 9 October 2015, p.96-99.

¹⁰ OECD, Anti-Corruption Reforms in Mongolia, Joint First and Second Rounds of Monitoring of Istanbul Anti-Corruption Action Plan, report adopted on 9 October 2015, p.5

¹¹ OECD, Istanbul Anti-Corruption Action Plan, Fourth Round of Monitoring, Mongolia, Progress Update, October 2016, p. 12-13

хуулиар хуульд заасан этгээд аливаа авлигын хэргийн талаар АТГ-г мэдээлэл өгөх үүрэгтэй бөгөөд АТГ уг мэдээллийн дагуу хянан шалгах үйл ажиллагаа явуулах эрхтэй. Олон нийтээс гомдолдог бас нэг асуудал бол улс төрийн намуудын санхүүжилт, түүнд тавих хяналт сул байгаа явдал бөгөөд энэ нь улс төрийн авлига дэлгэрэх, төрийн байгууллагад хяналтаа тогтоох ашиг сонирхлыг өдөөгч хүчин зүйл болдог. Улс төрийн намын санхүүжилттэй холбоотой өнөөгийн хууль тогтоомж нь амьдрал дээр барагтаа хэрэгждэггүйгээр үл барам түүнийг мушгин гуйвуулах тохиолдол элбэг бий.

Мэргэжлийн ур чадварт суурилан төрийн албанд сонгон шалгаруулах зарчмыг баримтлах санаачилга өрнөж буй хэдий ч төрийн албан хаагчийн томилгоонд уг зарчим төдий л мөрдөгдөхгүй, төрийн албан хаагчийн томилгоог улс төржүүлэх үзэгдэл оршсоор байна.¹²

Transparency International олон улсын байгууллагын Олон улсын авилгалын үнэлгээний 2016 оны индексээр Монгол улсын эрэмбэ 72 дугаар байрнаас 87 дугаар байр болж ухарсан (дэлхийн 168 орноос) байна. Гэхдээ энэ ухралт нь ойролцоо эрэмбийн орнууд дахь үзүүлэлт сайжирснаас улбаатай хэтрүүлэг бөгөөд Монголын үнэлгээ 39-өөс 38 болон зөвхөн нэг нэгжээр буурсан болно. Хэдий тийм боловч, энэ асуудлаар санаа амрах ёсгүй бөгөөд албан тушаалтнууд авлигын гэмт хэрэгт холбогдсон ч, зарим нэг нь ял шийтгэлээс ангидаг байх явдал гарсаар байгаа нь санаа зовоож байна.

Иргэний болон улс төрийн эрх

Үг хэлэх, мэдээлэл авах, шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх, шилжин хөдлөх, эвлэлдэн нэгдэх болон хувийн өмчтэй байх эрх чөлөө

Монгол Улс нь хүний эрхийн асуудлаарх олон улсын гол гол конвенцуудад, нэн ялангуяа Олон улсын хөдөлмөрийн байгууллагын үндсэн конвенцуудад нэгдсэн. Тус улсад Хүний эрхийн үндэсний комисс үйл ажиллагаагаа явуулдаг. Тус комиссын үйл ажиллагааны үндсэн чиглэл нь хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж буй асуудлаарх гомдол, саналыг хүлээн авч, шийдвэрлэх явдал юм.

Иргэд эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, түүнчлэн ажил, хөдөлмөр эрхлэгчид хараат бус эвсэл, холбоог үүсгэн байгуулах, тэдгээрт нэгдэх эрх чөлөөг хуулиар тогтоосон ба жагсаал, цуглаан, хамтын тохиролцоо хийх эрхийг мөн хуульчилсан. Үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд бие даан идэвхтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үндсэн хуулиар итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх эрхийг хүний үндсэн эрх хэмээн тодорхойлсон.

Монгол Улс дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаарх сүүлийн үнэлгээг НҮБ-ын Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн (UPR) хүрээнд 2015 онд хийсэн. Энэхүү мөчлөгийн хүрээнд хамгийн чухал 3 зөвлөмжүүд нь Хүүхдийн эрхийн тухай (27,11%), Эмэгтэйчүүдийн эрхийн тухай (23,49%), Олон улсын инструментүүдийн тухай (18,67%) асуудлуудыг багтааж байлаа. Монгол Улс нийт 166 зөвлөмжийн 91.57 хувийг нь хүлээн авч хэрэгжүүлж байгаа.¹³

¹² OECD, Anti-Corruption Reforms in Mongolia, Joint First and Second Rounds of Monitoring of Istanbul Anti-Corruption Action Plan, report adopted on 9 October 2015, p.6

¹³ United Nations, Universal Periodic Review (UPR), Mongolia and UPR Info Statistics available at http://www.upr-info.org/database/statistics/index_sur.php?fk_sur=115&cycle=2

Эмэгтэйчүүд, үндэстний болон бусад хэлбэрийн цөөнхийн улс төрийн оролцоо

Эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй байх, нэн ялангуяа хөдөлмөрийн хөлсөө адил тэнцүү үнэлүүлэх, боловсрол эзэмших зэргийг Үндсэн хуулиар хуульчилсан боловч эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, тодруулбал ажил болон гэр бүлийн хүрээнд тэднийг ялгаварлан гадуурхахтай тэмцэх асуудал шийдлээ хайсан томоохон сорилт хэвээр байна.

Сонгуулийн тухай хуульд заасны дагуу нам, эвслээс нэр дэвшиж байгаа хүний 20-оос доошгүй хувь нь эмэгтэйчүүдийн төлөөлөл байна. Парламентын сүүлийн сонгуулийн үеэр бүх нам, эвсэл хүйсийн талаарх энэ заалтыг хэрэгжүүлсэн бөгөөд сонгуульд өрсөлдөгчдийн 26 хувь нь эмэгтэйчүүд байсан. Хэдий тийм ч өнөөгийн парламентын 76 гишүүний 13 нь эмэгтэй бөгөөд ЕАБХАБ-аас тодорхойлсон дундаж статистик болох 24.4 хувьтай харьцуулахад эмэгтэйчүүдийн төлөөлөл бага байна.¹⁴ ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн албаны Олон улсын сонгууль ажиглагчдын багийн онцолсноор, сонгуулийн тойргуудын гуравны нэгээс илүүд нь эмэгтэй нэр дэвшигчид огт байгаагүй байна.¹⁵ Улс төрийн гол хоёр хүчин болох МАН, АН-ын эмэгтэй нэр дэвшигчдийн тоо хамгийн бага буюу аль альных нь хувьд 21 хувь байсан бол бусад жижиг намын эмэгтэй нэр дэвшигчдийн хувь харьцангуй өндөр байсныг тэмдэглэх нь зүйтэй. Ерөнхийлөн дүгнэвэл улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцооны түвшин хангалтгүй байна.

Монголын хүн амын 18 орчим хувийг үндэстний цөөнх бүрдүүлдэг. Үндэстний цөөнхүүд улс төрийн оролцоог хязгаарласан хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй. Тус улс дахь үндэстний цөөнхийн эрхийг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг НҮБ-ын Тусгай илтгэгч онцлохын хамт үндэстний цөөнх өөрсдийн хэл дээр мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлснийг сайшаасан. Нөгөөтэйгүүр үндэстний цөөнх Монголын нийгмийн амьдралд бүрэн оролцож чадахгүй байгааг тусгай илтгэгч тэмдэглэсэн.¹⁶ Монголд оршин сууж буй Хятад иргэдийн эсрэг чиглэсэн хааяа нэг гарах хүчирхийллийн шинжтэй хэрэг анхаарлын төвд оршоор байна.

Хүнийг хүйсийн баримжаа, бэлгийн чиг хандлагаар нь ялгаварлан гадуурхахыг хориглосон хууль эрх зүйн зохицуулалт тус улсад байхгүй бөгөөд ЛГБТ (lesbian, gay, bi-sexual and transgender) хүмүүсийг ялгаварлан гадуурхсан, хүчирхийллийн шинжтэй хэрэг явдал бүртгэгдсэн. Ажил хөдөлмөр эрхлэх, боловсрол эзэмших боломж бага зэрэг хүндрэлээс шалтгаалж олон тооны ЛГБТ хүн ядуу байдалд амьдарч байна.¹⁷

Хүчирхийлэл, айлган сүрдүүлэлт, эрүүдэн шүүхээс ангид байх эрх

Хүнийг эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бусаар харьцах, доромжлох, шийтгэхийг хуулиар хориглосон. Хэдий тийм ч цагдаагийн албан хаагчид хоригдлууд болон баривчлан саатуулагдсан хүмүүстэй зүй бусаар харьцсан тохиолдлууд бүртгэгдсэн ба хүний эрхийн асуудлаарх иргэний нийгмийн байгууллагууд энэ талаарх мэдээлэл цуглуулахад зарим саад тотгор гарсан байна. Түүнчлэн саатуулах зарим байрны орчин нөхцөл муу, ачаалал нь ихэдсэн, эмнэлгийн тусалцаа, хувцас, цагаан хэрэглэл, хоол

¹⁴ Parline. 2014. *Mongolia*. http://www.ipu.org/parline-e/reports/2219_A.htm

¹⁵ OSCE/ODIHR, International Observation Mission, Mongolia - Parliamentary Elections, Statement of Preliminary Findings and Conclusions, 29 June 2016, p.2

¹⁶ UN Report of the Special Rapporteur on extreme poverty and human rights, Mission to Mongolia, 30 May 2013, p. 11

¹⁷ UN Report of the Special Rapporteur on extreme poverty and human rights, Mission to Mongolia, 30 May 2013, p. 13

хүнсийг хүртээмжтэй хэлбэрээр олгодоггүй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай нөхцөл байдаггүй зэргийг иргэний нийгмийн байгууллагууд тэмдэглэсэн байна.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо Монголын хоёр дахь тогтмол илтгэлийг 2016 оны 9 дүгээр сард авч хэлэлцээд гаргасан Дүгнэлтэндээ Эрүүгийн байцаан шийтгэх шинэ хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа хойшлогдож байгаад сэтгэл зовниж байгаагаа мэдэгдсэн болно. Тус Хороо шинэ Хуулинд эрүүдэн шүүх ойлголтын тухай тодорхойлолт тусгагдсан хэдий боловч учир дутагдалтай зүйл байсаар байгаа, тухайлбал ял шийтгэлтэй холбоотой дутуу дулимаг зүйл байгааг тэмдэглэсэн байна.¹⁸

¹⁸ United Nations Office of the High Commissioner for Human Rights, Committee Against Torture, Concluding Observations on the Second Periodic Review of Mongolia, September 2016.

ХАВСРАЛТ 2 – ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол Улс

	2011	2012	2013	2014	2015	2016
Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, зарлага	<i>(Бодит утгаарх өөрчлөлтийн %, са.)</i>					
ДНБ	17.3	12.3	11.6	7.9	2.4	-1.0
Хувийн хэрэглээ	15.8	13.0	15.4	6.3	7.2	na
Төрийн хэрэглээ	15.3	19.9	15.8	12.2	-4.7	na
Gross fixed capital formation	66.2	14.7	-7.2	-21.7	-34.4	na
Бараа, үйлчилгээний экспорт	18.2	8.3	12.8	53.2	1.2	na
Бараа, үйлчилгээний импорт	49.5	15.4	7.6	6.8	-11.5	na
Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл	na	na	na	10.2	-5.1	na
Хөдөлмөрийн зах зээл	<i>(% өөрчлөлт)</i>					
Сарын нийт дундаж орлого (жилийн дунджаар)	24.2	31.5	33.6	6.9	7.0	na
Үндэсний валютаарх цалингийн бодит өсөлт	10.2	15.6	10.5	1.9	2.4	na
	<i>(Ажиллах хүчний %-иар)</i>					
Ажилгүйдлийн түвшин	7.7	8.2	7.9	7.9	7,5	7,9
Үнэ	<i>(% өөрчлөлт)</i>					
Хэрэглээний үнэ (жилийн дунджаар)	7.7	15.0	8.6	12.9	6.0	0,5
Хэрэглээний үнэ (жилийн эцсээр)	7.4	14.2	11.2	10.7	1.1	0.5
Төсвийн үзүүлэлтүүд	<i>(ДНБ-ний %-иар)</i>					
Засгийн газрын ерөнхий баланс	-4.8	-6.8	-1.2	-3.9	-5.0	-15.4
Засгийн газрын ерөнхий орлого	33,9	29,8	31,2	27,8	25,1	23,7
Засгийн газрын ерөнхий зарлага	37,9	38,9	40,1	39,1	33,6	40,7
Засгийн газрын ерөнхий өр	na	na	na	na	na	na
Мөнгө, санхүүгийн сектор	<i>(% өөрчлөлт)</i>					
Өргөн мөнгө (M2, жилийн эцсээр)	37.0	18.8	24.1	12.5	-5.5	20,2
Хувийн хэвшилд өгсөн зээл (жилийн эцсээр)	72.8	23.9	54.1	16.1	-6.5	16,2
	<i>(Нийт зээл дэх %-иар)</i>					
Найдваргүй зээлийн пропорци	5.8	4.2	5.3	5.0	7.4	8,5
Хүү, валютын ханш	<i>(Жил дутмын %-иар, жилийн эцэс)</i>					
Үндэсний валютын хадгаламжийн хүү	2.8	2.7	2.6	2.8	2.9	2,8
Гадаад валютын хадгаламжийн хүү	1.1	1.3	1.5	1.5	1.6	1,7
Үндэсний валютын зээлийн хүү	15.5	18.2	17.4	19.5	19.1	19,7
Гадаад валютын зээлийн хүү	12.1	13.5	12.7	12.9	12.0	13,0
Бодлогын хүү	12.3	13.3	10.5	12.0	13.0	14,0
	<i>(₮ / АНУ-ын \$)</i>					
Валютын ханш (жилийн эцсээр)	1,396	1,392	1,659	1,888	1,996	2,148
Валютын ханш (жилийн дунджаар)	1,265	1,360	1,526	1,818	1,971	2,490
Гадаад сектор	<i>(ДНБ-ний %-иар)</i>					
Урсгал данс	-26.5	-27.4	-25.4	-11.5	-4.8	-4.0
Худалдааны тэнцэл	-20.7	-21.6	-20.9	-4.6	2.9	1.7
Барааны экспорт	46.3	35.7	33.9	47.4	39.8	43.1
Барааны импорт	55.8	48.3	44.4	39.2	29.3	31.2
Гадаадын шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	44.4	35.9	16.7	2.3	1.6	37,6
Гадаад валютын нийт нөөц (жилийн эцсээр)	25.3	33.6	17.8	13.5	11.3	11,7
Гадаад өрийн багц	92.5	125.2	151.2	171.7	184.4	221,8
Засгийн газрын гадаад өр	21.3	33.3	37.7	42.4	46.8	60,0
Хувийн хэвшлийн гадаад өр	71.2	91.8	113.4	129.3	137.5	161,8
	<i>(Бараа, үйлчилгээ импортлох сарын тоогоор)</i>					
Нийт нөөц (жилийн эцсээр)	5.8	9.3	5.4	3.1	3.0	2.9
Тойм статистик	<i>(Нэрлэснээр)</i>					
Хүн ам (жилийн эцэс, саяаар)	2.8	2.8	2.9	2.9	3.0	3.1
ДНБ (тэрбум ₮, нэрлэсэн үнээр)	13,173	16,688	19,174	22,227	23,134	23,886
Нэг хүнд ногдох ДНБ (АНУ-ын \$, нэрлэсэн үнээр)	3,736	4,328	4,365	4,169	3,946	3,660
ДНБ дэх аж үйлдвэрийн эзлэх хувь (%-иар)	38.3	35.5	40.0	42.0	37.6	41,6
ДНБ дэх ХАА-н эзлэх хувь (%-иар)	10.3	11.3	13.4	13.3	13.7	13,3
Цэвэр ГШХО (тэрбум АНУ-ын \$)	4.6	4.4	2.1	0.3	0.2	-4,1
Гадаад өр - нөөц (тэрбум АНУ-ын \$)	93.6	149.7	188.0	207.8	214.7	23,3
Гадаад өр/бараа үйлчилгээний экспорт (%)	177.0	287.8	382.0	329.8	407.0	439,3
Өргөн мөнгө (жилийн эцсээр, ДНБ-ний %)	48.7	45.6	49.3	47.9	43.4	42,1

ХАВСРАЛТ 3 – ШИЛЖИЛТИЙН ҮЕИЙН СОРИЛТУУДЫН ҮНЭЛГЭЭ

Зах зээлийн бүтэц	Зах зээлийн институциуд	Гол сорилтууд
КОМПАНИУД		
Агробизнес		
Дунд	Дунд	- Хөдөө орон нутаг дахь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор авто зам, төмөр замын салбар дахь реформыг урагшлуулах; - Өрсөлдөх чадвар, зах зээлд гарах чадварыг сайжруулахын тулд эрүүл ахуй, чанар, явцыг хянах стандартуудыг өндөрсгөх; - ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нүүдэлчний бүтцүүдийн утгаар хамгийн тохиромжтой болгох.
Үйлдвэрлэл, үйлчилгээ (M&S)		
Том	Дунд	- Зах зээлд үйлдвэрийн газар шинээр орох, гарахыг цаашид дэмжих, ЖДҮ-ийн газрын өсөлтийг дэмжих орчин бий болгох зорилгоор төрийн захиргаа, шүүхийн байгууллагыг бэхжүүлэх; - Томоохон групп компаниудын компанийн засаглал, бизнес практикийг бэхжүүлэх; - Санхүүжилт олох гарцыг сайжруулахын тулд барьцааны төвлөрсөн бүртгэлийн систем бий болгох.
Үл хөдлөх хөрөнгө		
Том	Том	- Боломжийн үнэтэй орон сууц, сайн дизайнтай бизнесийн барилгуудын нийлүүлэлтийг ялангуяа Улаанбаатарын оффисын төв хэсгээс гадуур нэмэгдүүлэх; - Үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой төрийн үйлчилгээг цаашид жигдрүүлэх, газрын борлуулалт, хөрөнгийн бүртгэл дэх ил тод байдлыг хангах; - Төрөл бүрийн барилгын стандартыг сайжруулах, ялангуяа эрчим хүчний хэмнэлт, тогтвортой байдалд анхаарах.
Мэдээлэл, холбооны технологи (ICT)		
Том	Дунд	- Суурин холбооны Монголын цахилгаан холбоо компанийн хувьчлах; - Зохицуулалтын журмын хүрээг цаашид хөгжүүлэх; - Телеком дэд бүтэц (томоохон хот суурин газраас хальж гарсан өргөн зурвасын интернэт)-ийг хөгжүүлэх.

Зах зээлийн бүтэц	Зах зээлийн институциуд	Гол сорилтууд
ЭРЧИМ ХҮЧ		
Байгалийн баялаг		
Дунд	Том	- Тусгай зөвшөөрөл олгох процессын ил тод байдлыг сайжруулах; - Төрийн эзэмшлийн компаниудыг эдийн засгийн хараат бус үндсэн дээр ажиллахыг зөвшөөрөх; - Тогтвортой, хөрөнгө оруулагчдад таатай орчин бий болгосон одоогийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, байгалийн нөөцийн орлогоос үүдэлтэй макро эдийн засгийн тогтворгүй байдлыг намжааж чадах сайн ажиллагаатай институциудыг хөгжүүлэх; - Уул уурхайн ханган нийлүүлэлтийн гинжин сүлжээ хөгжүүлэх, эдийн засгийн төрөлжүүлэлтэд таатай орчин бий болгох зорилгод уул уурхайн бум тэлэлтийг ашиглах; - Нефть хангамжийн доош чиглэсэн салбарыг өргөтгөхийг дэмжих, шатахуун түлшний жижиглэн худалдааны үнийн зохицуулалтыг дуусгавар болгох, бензин түгээлтийн салбар дахь өрсөлдөөнийг сайжруулах; - Эрчим хүчний зохицуулах газар (ERA), Ашигт малтмалын газар (MRAM) зэрэг зохицуулагч агентлаг, нефть, хийн аж үйлдвэрийн тусгай зөвшөөрөл олгогч газар болох Газрын тосны газар (РАМ)¹⁹-ын хараат бус байдал, техникийн чадавхийг бэхжүүлэх.
Тогтвортой эрчим хүч		
Том	Дунд	- Эцсийн хэрэглэгчдэд өртөг шингээсэн үнэ тариф ногдуулах; - Тогтвортой эрчим хүчний салбарыг дэмжсэн хууль эрх зүй, институцийн хүрээг боловсруулж хэрэгжүүлэх; - Нүүрсхүчлийн хийн санхүүжилтын төслүүдийг хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх.
Цахилгаан хангамж		
Том	Том	- Төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг компанийн хэлбэрт оруулах явдлыг нэмэгдүүлэх; - Зохицуулагч байгууллагын хараат бус байдлыг бэхжүүлэх; - Эцсийн хэрэглэгчдэд өртөг шингээсэн үнэ тариф ногдуулах, үүний зэрэгцээ эмзэг бүлгийн хэрэглэгчдийг хамгаалах зохистой арга хэмжээ авах.

¹⁹ 2010 он хүртэл MRAM болон РАМ нь Монголын ашигт малтмал, газрын тосны газар (MPRAM)-ын бүрэлдэхүүнд байсан.

Зах зээлийн бүтэц	Зах зээлийн институциуд	Гол сорилтууд
ДЭД БҮТЭЦ		
Ус хангамж, бохир ус цэвэршүүлэх		
Том	Том	■ Зохицуулалтыг сайжруулах (e.g. орчин үеийн тарифын аргачлал боловсруулж мөрдөх); ■ Эзэмшигч/бодлого боловсруулагч болон компанийн хооронд байгуулах гэрээт тохиролцоо боловсруулах; ■ Тариф, хураамжийн түвшинг цаашид нэмэх; ■ Компанийн бүтцийн өөрчлөн байгуулалт хийх, арилжааны хэлбэрт оруулах (ус алдагдлыг багасгах, усны чанарыг сайжруулах); ■ Тоолуур болон тоолуурт үндэслэсэн нэхэмжлэл нэвтрүүлэх.
Хотын тээвэр		
Том	Том	■ Хот нийтийн тээврийн бодлого боловсруулах (i.e. хотын нэгдсэн тээврийн стратеги); ■ Нийтийн эзэмшлийн компаниудын автономит байдлыг нэмэгдүүлэх, хотын захиргаатай байгуулах гэрээт тохиролцоо бий болгох; ■ Үйлчилгээний чанар, үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулах; ■ Хувийн хэвшлийн оролцоог хангахад чиглэсэн алхмуудыг санаачлах; ■ Цахим тасалбарын систем, хураамж авах түвшинг сайжруулах практик нэвтрүүлэх; ■ Хотын авто зам, гудамжны менежментийн нэгдсэн систем боловсруулах.
Авто зам		
Том	Том	■ Гол гол авто замыг чанарын зохих түвшинд арчилж тордох боломж олгохын тулд зам ашиглалтын төлбөрийн системд реформ хийх; ■ Зам барих, арчилж тордох гэрээ байгуулах өрсөлдөөнийг нэмэгдүүлэх; ■ Зохицуулагч үйл ажиллагаа (түүний дотор төрийн худалдан авалт)-ны ил тод байдлыг сайжруулж, нэмэгдүүлэх.
Төмөр зам		
Дунд	Дунд	■ Одоогийн төмөр замыг цаашид арилжааны хэлбэрт оруулах, засаглал, ил тод байдлыг нь сайжруулах; ■ Төлөвлөж байгаа ТХХТ-ийн төслүүдийн зохицуулалтын функц, үйл ажиллагааны амжилтыг хангах.

Зах зээлийн бүтэц	Зах зээлийн институциуд	Гол сорилтууд
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУД		
Банк		
Том	Дунд	- Компанийн засаглал, эрсдлийн менежмент, эрсдлийг зээлдэгчдэд мэдээлэх зэрэг банкуудын дотоод практикийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх; - Гадаадын стратегийн хөрөнгө оруулагчдын үүргийг нэмэгдүүлэх; - Удирдах ажилтнуудын үүрэг ролийг өндөрсгөх, Хадгаламжийн даатгалын агентлаг, хувийн өмчийн Зээлийн мэдээллийн товчооны үйл ажиллагааг дэмжих замаар зохицуулалтын хүрээ, зах зээлийн институцийг сайжруулах
Даатгал, санхүүгийн бусад үйлчилгээ		
Том	Том	- Даатгал авах гарцыг өргөжүүлэх, түүний дотор даатгалын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх - Даатгалын салбар дахь компанийн засаглал, бизнес жаяг, үр чадварын суурийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх; - Хувийн тэтгэврийн салбарт эрх зүй, зохицуулалтын шаардлагатай хүрээ тогтооход дэмжлэг үзүүлэх; - Лизинг, зах зээл дээр байгаа лизингийн бүтээгдэхүүн авах гарцыг өргөжүүлэх.
Бичил, жижиг, дунд үйлдвэрийн газрууд		
Дунд	Том	- БЖДҮ-т төгрөгөөр зээл олгох явдлыг нэмэгдүүлэх; - ЖДҮ-т санхүүжилт олгох лизинг, хувь хөрөнгийн зээл зэрэг бусад эх үүсвэр бий болгох; - ЖДҮ-ийн санхүүжилт олох гарцыг дэмжсэн эрх зүй, институцийн хүрээ, түүний дотор зээлдүүлэгчийн эрхийг хангах, үр ашигтай хувийн зээлийн товчоо хөгжүүлэх явдлыг сайжруулах.
Хувийн хэвшлийн хувь хөрөнгө (PE)		
Том	Дунд	- PE, VC санхүүжилтын тухай ойлголт, Компанийн зүгээс тийм санхүүжилт олох гарцыг сайжруулах, энтрепренёруудад хувийн хувь хөрөнгө татахын ач тусыг таниулах; (ЖДҮ-т төвлөрсөн) PE, VC сан байгуулж, ажиллуулахад дэмжлэг үзүүлэх ; - Хөрөнгө оруулалт авах потенциалтай компанийн засаглалын стандарт, институтчлалыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх; - Нэр хүндтэй олон улсын хандивлагчид, хязгаарлагдмал түншлэл (LPs)-ийн дунд Монголыг сонирхох явдлыг нэмэгдүүлэх.

Зах зээлийн бүтэц	Зах зээлийн институциуд	Гол сорилтууд
Хөрөнгийн зах зээл		
Том	Дунд	▪ Дотоодын хөрөнгийн зах зээл дээрх төлбөрий чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх; ▪ Арилжаа, клиринг, маргаан таслах дэд бүтэц, ажиллагааг сайжруулах; ▪ Хөрөнгийн зах зээлийг зохицуулсан хууль эрх зүй, зохицуулалтын хүрээг сайжруулах.

ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРТЭЭМЖ		
Хүртээмжийн хийдлийн цар хүрээ	Хүртээмжийн хийдэл	Гол сорилт
Бүс нутагт		
Үйлчилгээ авах гарц	Том	Ус хангамж, дулаан, цахилгаан, МХТ-ийн дэд бүтцийн үйлчилгээ авах орон нутгийн гарцыг сайжруулах
Хөдөлмөрийн зах зээл	Дунд	Орон нутгийн төвүүд (аймгууд), хөдөө орон нутаг дахь ажлын байр, сургалтад хамрагдах гарцыг нэмэгдүүлэх
Залуучууд		
Залуучуудын ажил эрхлэлт	Том	- Ажлын байран дээр суралцах боломж (i.e. дадлагажих, сургалтын хөтөлбөрүүд)-ийг бэхжүүлэх, хувийн хэвшил, боловсролын байгууллагын хамтын хүчин чармайлтаар мэргэжлийн сургалт, техник сургалтын үр дүнг ажил олгогчийн шаардлагын дагуу сайжруулах - Ажил олгогчийн шаардлага, олон улсын стандартад нийцсэн чадварт суурилсан сургалтын хөтөлбөр, ур чадварын стандарт, нотолгооны механизм нэвтрүүлэхээр ажиллаж буй Засгийн газрын хүчин чармайлтыг дэмжих
Боловсролын чанар	Дунд	- Хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад илүү нийцсэн техник мэргэжлийн боловсрол, сургалт (TVET), дээд боловсролын чанар, ач холбогдлыг сайжруулах - Боловсролын туршид карьер хийх чиг баримжаа илүү олгох
Хүйс		
Хөдөлмөрийн практик, бодлого	Дунд-Том	- Тэгш бололцоо олгох практик, түүний дотор ижил цалин, ажил эрхлэлтийн боломж, хүүхэд асрах чанартай үйлчилгээ, эмэгтэй удирдагчдын хөтөлбөр нэвтрүүлэх, сайжруулахад хувийн хэвшлийн үйлчлүүлэгчдийг чиглүүлэх - Нийгэм дэх үүрэг роль ялгарч байгааг засахын тулд карьер хийх илүү сайн чиг баримжаа олгох замаар залуу эмэгтэйчүүдийг уламжлалт бус, ирээдүйг харсан ажил эрхлэлтэд бэлтгэж сургахад дэмжлэг үзүүлэх
Эрүүл мэндийн үйлчилгээ	Дунд	Эрүүл, мэндийн чанартай үйлчилгээг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд илүү сайн хүртээмжтэй байлгахыг дэмжих

ХАВСРАЛТ 4 – ХУУЛЬ ЭРХЗҮЙН ШИНЭЧЛЭЛТ

Танилцуулга

Энэхүү хавсралт тус Банкны ирэх жилүүдэд баримтлах хөрөнгө оруулалтын стратегитэй хамааралтай хууль эрхзүйн чухал шинжилгээг агуулж байна. Хууль эрхзүйн шинэчлэлтийн хөтөлбөрийн хүрээнд ЕСБХБ-аас хийсэн худалдаа, арилжаатай холбоотой хууль эрхзүйн баримт бичигт хийсэн дүн шинжилгээнд үндэслэв. Эшлэл болгоход хялбар байлгах үүднээс дүн шинжилгээг үндэсний стратегид, ялангуяа “Бодлогын яриа хэлэлцээ ба техник хамтын ажиллагаа”-ны хүрээнд төлөвлөгдсөн үйл ажиллагаанд үндэслэн үндсэн стратеги чиглэлтэй уялдуулсан болно.

Сэдэв 1: Олборлох бус салбарын өрсөлдөх чадарыг сайжруулах, санхүүжилт авах боломжийг хялбаршуулах замаар Монгол Улсын тогтвортой байдлыг хангах нь

Санхүүжилт авах боломж

Монгол Улс 2017 оны 3-р сараас хэрэгжиж эхлэх Хөдлөх хөрөнгө болон эдийн бус эд хөрөнгийн тухай хуулийг баталснаар хөдлөх болон эдийн бус хөрөнгөтэй холбоотой эрхзүйн орчноо болосронгүй болгож чадсан юм. Одоо мөрдөгдөж буй хууль эрхзүйн орчинд зохицуулалтгүй орхигдсон асуудлуудыг зохицуулахад энэ шинэ хууль хэрэгтэй байгаа болно. Үүнээс гадна хөдлөх хөрөнгийн хамрах хүрээг илүү өргөн болгож өгснөөр барьцаа хөрөнгө болгон ашиглах боломжийг ялангуяа үл хөдлөх хөрөнгө багатай хэдий ч хөдлөх хөрөнгө ихтэй ЖДҮ-ийн хувьд тэлж өгч байгаа юм.

ЕСБХБ 2016 онд үйл ажиллагаа явуулдаг улс орнуудынхаа хүрээнд, үүний дотор Монголыг оролцуулан факторинг чадавхын судалгаа хийсэн юм. Уг судалгааны дүнгээр, Монгол Улсад энэ чиглэлийн хууль, факторингийн олон төрөлд тохирсон нэр томьёо байхгүй, зөвхөн компани орлогоо барьцаалан зээл авах харилцааг хуульчилжээ. Хэрэв факторинготой холбоотой үйл ажиллагааг илүү нарийвчлан тодорхой болговол энэ чиглэлийн санхүүгийн үйл ажиллагаа илүү эрхзүйн үндэслэлтэй болж холбогдох санхүүгийн үйл ажиллагааны өртөг зардал, эрсдэл буурах болно. Санхүүгийн түрээс (лизинг)-ийн тухай хууль санхүүгийн түрээс/лизингтэй холбоотой харилцааг ерөнхийд нь зохицуулдаг хэдий ч уг хууль үйл ажиллагааны түрээс/лизингэд огт хамааралгүй, Иргэний хуульд заасан түрээстэй хамаарах ерөнхий зохицуулалтаас өөр хууль эрхзүйн зохицуулалт алга байна. Уул уурхайн салбарт өсөн нэмэгдэж байгаа энэ үйлчилгээний эрэлт хэрэгцээ үйл ажиллагааны лизинг Монголын хувьд ямар чухал болохыг харуулж байна. ЕССХБ-ны дэмжлэгтэйгээр Монгол Банк санхүүгийн түрээсийн зохицуулалтыг сайжруулах, үйл ажиллагааны түрээсийн хүрээ заагийг тогтоох зорилго бүхий түрээсийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрхзүйн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах төсөл боловсруулсан. Санал болгож буй нэмэлт өөрчлөлтүүд нь хуулийн төсөл өргөн барих, хэлэлцэх, соёрхон батлах шатандаа ороогүй яваа юм.

Шүүгчийн чадавх, гэрээг мөрдүүлэх

ЕСБХБ-ны *Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ 2011* нь бүс нутгийн хэмжээнд худалдааны хуультай холбоотой гаргасан Монголын шүүхийн шийдвэрийн чанар нь тухай бүсийнхээ (ТУХН-ийн орнууд, Гүрж, Монгол) хувьд хамгийн муу үзүүлэлттэй байсан бол ЕСБХБ-ны дэмжлэгтэйгээр хэрэгжсэн бизнес үйл ажиллагаатай холбоотой гарсан алив нэхэмжлэлийг үр дүнтэй шийдэх чиглэлээр чадавх бэхжүүлэх зорилготой сургалтын хөтөлбөрт шүүгчдийг хамруулснаар энэ чадавх сайжирсан. Хэдийгээр шүүгчдийн бизнес үйл ажиллагаатай холбоотой мэдлэг, ур чадвар сайжирсан хэдий ч Монгол Улс шүүгчдээ мэргэжлийн сургалтад хамруулах арга хэмжээг цаашид авах шаардлагатай. Ялангуяа, худалдааны хуулийн тодорхой заалттай холбоотой бизнес үйл

ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэн шүүхийн шийдвэрийн чанар болон иргэд олон түмэнд эдгээр шийдвэр нээлттэй болгох асуудлыг сайжруулах ёстой. ТУХНО, Гүрж, Монгол улсын хууль сахиулагчдын үйл ажиллагааг зохицуулсан байдлын тухай *ЕСБХБ Хууль сахиулагчийн үнэлгээ 2013* судалгаанд Монголын үзүүлэлт тухайлбал, маш чухал үзүүлэлт болох хууль сахиулах зардал болон хурдаар бусад орнуудын дунджаас доогуур байв. Эдгээр асуудлыг шийдэхийн тулд ЕСБХБ бизнесийн үйл ажиллагаатай холбоотой гарсан шүүхийн шийдвэр хангахад шийдвэр гүйцэтгэгчдийн чадавхыг дээшлүүлэх зорилготой техник хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлж эхэлсэн нь одоо үргэлжилж байгаа..

2013 оноос Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль Монголд хэрэгжиж эхэлсэн нь шүүхээс өмнө талуудыг эвлэрүүлэн зуучлах, энэ чиглэлийн үйлчилгээг хувийн өмчийн төвүүд хүргэх үйл ажиллагааг хууль эрхзүйн хувьд баталгаажуулж өгсөн. Тухайн үед хувийн өмчийн ийм төвүүд байдаггүй байсан ба анхны бизнес арбитрын төв ЕСБХБ-ны дэмжлэгтэйгээр МХАҮТ-ын дэргэд байгуулагдсан. Цаашид бизнесийн маргааныг зохицуулах өөр бусад хэлбэр, арга зам хэрэглэхийг сурталчлан таниулах нь чухал байна.

Сэдэв 2: Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах зорилгоор сайн засаглалтай уул уурхайн салбарын хүртээмжийг нэмэгдүүлэх нь

Компанийнн засаглал

2016 онд ЕСБХБ-ны хэвлүүлсэн компанийнн засаглалтай холбоотой хууль эрхзүйн орчин, бодит байдлаар нутагт хийсэн судалгаагаар Монголын хувьд эдгээр асуудал шинэчлэл шаардаж байгаа юм. Хамтарсан хөрөнгө оруулалттай компаниуд нь нэг шатлалт удирдах зөвлөлтэй, гүйцэтгэх захирал, удирдах зөлөлийн даргын албыг нэг хүн хаших боломжгүй, тогтолцоотой байна. Хуулиар удирдах зөвлөлийн гишүүдийн ядаж гураны нэг нь хараат бус гишүүн байх ёстой боловч “хараат бус” гэх тодорхойлолт ямар нэг “эерэг шалгуур” (өөрөөр хэлбэл хараат бус гишүүд юу хийх ёстойг заагаагүй) агуулаагүй. Компанийнн дотоод хяналтыг зохицуулах хууль эрхзүйн зохицуулалт сайн биш байх шиг байна. Хөрөнгийн биржид бүртгэлтэй компани, банкууд хуулийн дагуу бие даасан аудитор гаднаас томилох ёстой хэдий ч хувьцаа эзэмшигчид гэхээс илүүтэй удирдах зөвлөл нь аудиторыг томилдог нь маш их асуудал үүсгэдэг. ЕСБХБ-ны бүсийн хувьд удирдах зөвлөлийн гишүүдийн хүйсийн харьцаа хамгийн тэгш бус. Мөн санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийн ил тод байдлыг хангахыг шаардах хууль эрхзүйн үндэслэл муу байгаа нь томоохон 10 ХК-ны дөнгөж хоёр нь санхүүгийн жилийн тайлангаа интернетээр мэдээлдэгт хүргэжээ. Компанийнн засаглалын кодексыг анх 2007 онд авч хэрэглэн, 2014 онд шинэчилжээ. Шинэ кодекс өмнөхтэйгээ харьцуулахад нарийвчилсан зөвлөмжгүй, зохицуулалтын чухал шаардлагатай заалтуудыг байхгүй болгожээ. Кодексийг хэрхэн биелүүлж байгаа талаар хяналт тавьдаг байгууллага байгаа эсэх нь тодорхойгүй, эдгээр 10 томоохон ХК-ны аль нь ч энэ тухай тайлан гаргадаггүй байна.

Сайн тал нь хуулиар хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах, хурлын хэлэлцэх асуудалд нэмэлт санал оруулах, удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, ерөнхий шалгалт хийх, саналын эрх, давуу эрх зэрэг хувьцаа эзэмшигчдийн үндсэн эрхийг баталгаажуулсан. Өмчлөгч шүүхэд гомдол гаргах журмыг хуульд зааснаас гадна томоохон өөрчлөлт хийхэд дийлэнх олонхын саналаар шийдэхээр хуульд тусгагджээ.

Сэдэв 3: Үр ашигтай ажиллагаа, арилжааны хэлбэрт оруулах, “ногоон” шийдэл ашиглах замаар дэд бүтцийн чанар, тогтвортой байдлыг дээшлүүлэх

Эрчим хүч/Сэргээгдэх эрчим хүч

Салхи, ус, нар зэрэг сэргээгдэх эрчим хүчний шавхагдашгүй баялагтай орон боловч эрчим хүчний салбар нь ДЦС дээр суурилсан, сэргээгдэх эрчим хүчний салбарт ГХО шаардлагатай байгаа юм. 2014 онд УИХ-аар баталсан Ногоон хөгжлийн бодлогын баримт бичигт эрчим хүчний нийт хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь хэмжээг 2023 онд 20%, 2030 он гэхэд 30%-д хүргэх зорилт тавьжээ. 2015, УИХ эрчим хүчний салбарт төрөөс баримтлах бодлогыг батлахдаа 2020 онд 20%-д хүргэх зорилтод 2023 онд хүрэхээр хугацааг хойшлуулсан. Одоогийн нөхцөл байдалд уг зорилт ахадсан мэт боловч бодит тоон үзүүлэлтээр авч үзвэл ач холбогдол багатай юм.

Цаашилбал 2015 шинэчлэл нь эрчим хүчний салбарыг илүү арилжааны хэлбэрт шилжүүлэх зорилготой байж, Эрчим хүчний яамнаас сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, үйлдвэрлэл, шугам сүлжээнд тавих стандартууд болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй хийх цахилгааны холболт, дамжуулалттай холбоотой асуудлыг зохицуулах дүрэм журмыг боловсруулж, баталснаар түгээлтийн системд холбох ажилд дэм болох юм. Хууль эрхзүйн хувьд сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх чухал шаардлагыг баталгаажуулсан зохицуулалт байхгүй байсаар. Монгол Улс хууль эрхзүйн болон зохицуулалтын саад тээгийг авч хаян эрчим хүчний системд хувийн хэвшлийн үүрэг ролийг нэмэгдүүлснээр энэ салбарт өрсөлдөөнийг үүсгэх. Мөн сэргээгдэх эрчим хүчийг түлхүү дэмжих шаардлагатай.

Эрчим хүчний хэмнэлт

Сүүлийн жилүүдэд тодорхой ахиц гарсан хэдий ч дэд бүтэц, тухайлбал цахилгаан дулааны станцууд, дамжуулах шугам сүлжээ хуучирч элэгдсэн, шугамын алдагдал ихтэй байна. Орон сууцаа дулаалах, эрчим хүчний салбарт хэмнэлт гаргах нь үндэсний хэмжээнд чухал ач холбогдолтой. 2014 онд баталсан Ногоон хөгжлийн бодлого нөөц хэмнэх, хаягдал багасгах замаар нүүрс олборлолт, хэрэглээг багасгах, байгаль орчинд ээлтэй технологи дэмжих, ногоон эдийн засгийг хөхиүлэн дэмжих арга механизм бий болгох зэрэг нь стратеги зорилтуудын хэсэг юм. Тодруулбал, ногоон шийдэл нэвтрүүлэх, эрчим хүч хэмнэлттэй шинэлэг технологи стандарт ашиглах, ногоон барилгын гэрчилгээ, эрчим хүчний аудит, эдгээрийг дэмжих хөшүүрэг нэвтрүүлэх арга замаар барилгын дулаан алдагдлыг 2023 онд 20%, 2030 онд 40% бууруулах зорилт тавьсан байгаа.

2015 онд удаан хүлээлгэсэн Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль батлагдан гарч, үүнийг даган эрчим хүчний жилийн хэрэглээ, алдагдалд үндэслэн томоохон хэрэглэгчдийн хэрэглээнд хязгаар тогтоосон Засгийн газрын 294-р тогтоол, эрчим хүчний аудит хийх, аудитын байгууллага, үйлчилгээ үзүүлэгчид тавих шаардлага, аккредитац явуулах, сургалт зохион байгуулах, аудитуудад эрх олгох үйл ажиллагааг зохицуулсан дүрэм журмыг Засгийн газрын 295-р тогтоолоор тус тус баталжээ. Эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр батлагдсан эдгээр хууль тогтоомжийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх нь хамгийн чухал юм.

Төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ)/Концесс

2010 онд батлагдсан Концессын тухай хуулийг олон улсын стандарт, шилдэг туршлагад тулгуурлан боловсруулсан бөгөөд энэ хууль хууль эрхзүйн болон институт тогтолцооны бүх чухал элементүүдийг агуулсан сайн хууль болсон юм. Уг хуульд 2013 онд оруулсан нэмэлт өөрчлөлт болон концессийн хуулийн үндсэн зарчим нийлээд

гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдад харьцангуй тэгш боломж олгох нөхцөл болсон. Эдгээр сайн ажил хийгдсэн хэдий ч ТХХТ/концессээр хэрэгжих төслийн хувьд эрхзүйн зохицуулалтаа улам тодорхой, оновчтой болгох шаардлагатай байна. ТХХТ-ийн хүрээнд хэрэгжих төсөл боловсруулах хэрэгжүүлэх чадвар Монголын хувьд сул, цаашид энэ чиглэлд шинэчлэл хийх шаардлагатай.

ХАВСРАЛТ 5 – ЖЕНДЭРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Онцлох

Монгол Улс эмэгтэйчүүдийн эрх, хүйсийн тэгш байдлыг хангах асуудлаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга зүйг хэрэглэн мэдэгдэхүйц амжилтад хүрсэн орон билээ.²⁰ УИХ-р Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийг 2011 баталж, уг асуудлаар дунд хугацааны стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг 2013 онд баталжээ.²¹ Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт харьцангуй өндөр буюу нийт хөдөлмөрлөх насныхны 60 орчим хувийг эзэлдэг хэдий ч ажил, албан тушаал дээр салбараар ялгаварлаж ханддаг нь хүйсэд чиглэгдсэн сургалтын үйл ажиллагаанд нөлөөлж, уул уурхай, эрчим хүч, тээвэр гм өндөр үр ашигтай, цалин өндөртэй салбарт ажиллах боломжийг хязгаарлаж байгаа юм. Энэ нь (а) эдгээр салбарууд эмэгтэйчүүд ажиллахад тохиромжгүй гэж нийтээр үздэг уламжлалт үнэлэмж, (б) уламжлалт бус, ирээдүйн чиг хандлагад чиглэгдсэн салбарын мэргэжлээр залуу эмэгтэйчүүд сурч боловсрохыг дэмжих сайтар боловсруулсан карьер төлөвлөлт байхгүйтэй холбоотой. Эмэгтэйчүүдийн гэр бүлдээ гүйцэтгэх үүрэг, хүүхэд гаргах асуудалтай нийлээд уг асуудлыг улам ужигруулдаг байна.

Хүйсийн тэгш бус байдал, хүний хөгжил

НҮБ-ын 2015 онд гаргасан Хүний хөгжлийн индекс (ХХИ)-т Монгол Улс дээгүүр байр эзэлдэг.²² Мөн НҮБ-ын Хүйсийн тэгш байдлын индекс (ХТБИ)-р нийт 155 орноос 90-р байр эзэлжээ.²³ SIGI индексээр²⁴ хүйсээр ялгаварлан гадуурхах хууль эрх зүйн болон амьдралын практик маш бага гэж үнэлэгдсэн.

Ажиллах хүчний оролцоо, цалингийн зөрүү

Монгол бусад төв азийн орнуудын нэгэн адилаар хөдөлмөрийн зах зээлд эмэгтэйчүүдийн өндөр оролцоотой буюу 60%²⁵ (Киргиз [56.3%], Тажикистан [59.1%], Казахстан [67.9%]).²⁶ Залуу эмэгтэйчүүд (15-24 насныхан)-ийн ажиллах хүчний оролцоо 31% бол ижил насны эрэгтэйчүүдийнх 41 % байна²⁷. Зарим талаар охидын боловсролд хөвгүүдийнхээс илүү их хөрөнгө оруулдам Монгол чиг хандлага нөлөөлж, их дээд сургуульд суралцаж буй залуучуудын олонх охид байгаатай холбож тайлбарлаж болно. Хэдий ийм боловч хөдөлмөрийн зах зээл дээрх ажил мэргэжлээс хамааран хүйсийн тэнцвэрт байдал алдагдах нь тогтвортой оршсоор байна. Эдийн засгийн хувьд бүтээмж муутай салбарт болон бага цалинтай, эрх мэдэлтэй, хариуцлага багатай ажил албан тушаалд олноороо, эсхүл удирдах, техникийн, уул уурхай, тээвэр, эрчим хүч зэрэг

²⁰ Хүйсээр ялгаварлах бүх хэлбэрийг устгах конвенцид 1981 онд нэгдсэн.

²¹ Швейцарын хөгжлийн агентлаг. *Gender Overview. Mongolia Desk Study*. 2014. Retrieved from <https://www.eda.admin.ch/content/dam/countries/countries-content/mongolia/en/SDC-Gender-%20Overview-Mongolia-%202014-EN.pdf>

²² ХХИ: эрүүл мэнд, боловсрол, амьдралын стандарт гурван үзүүлэлт тооцдог. http://hdr.undp.org/sites/all/themes/hdr_theme/country-notes/MNG.pdf

²³ ХТБИ тухайн улсын хувьд хүйсийн тэгш бус байдлаас үүссэн алдсан боломжийг нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхээ эдлэх боломж, хөдөлмөрийн зах зээлийн оролцоо гэсэн гурван үзүүлэлтээр тооцно.

²⁴ SIGI ялгаварлан гадуурхах нийгмийн институци тогтоглоог тоон болон чанарын үзүүлэлтээр илэрхийлнэ.

²⁵ The World Bank. 2014. *Mongolia*. <http://data.worldbank.org/indicator/SL.TLF.ACTI.FE.ZS/countries>

²⁶ The World Bank. 2014. *Mongolia*.

http://databank.worldbank.org/data/reports.aspx?Code=SL.TLF.CACT.FE.ZS&id=2ddc971b&report_name=Gender_Indicators_Report&populartype=series

²⁷ The World Bank. 2014. *Mongolia*. <http://data.worldbank.org/indicator/SL.TLF.ACTI.1524.FE.ZS?view=chart>

цалин өндөртэй, өсч дэвших боломжтой салбарт цөөн эмэгтэйчүүд ажилладаг.²⁸ Мөн цалингийн зөрүү нэмэгдсээр эмэгтэйчүүд эрчүүдээс 14.3% бага цалин авч байна.²⁹

Хэдийгээр Монгол Улсын Хөдөлмөрийн хуулиар эрэгтэй, эмэгтэй иргэд хөдөлмөр эрхлэх ижил тэгш эрхтэй хэдий ч өнөө үед хоцрогдсон аюултай ажил мэргэжлийн жагсаалтад орсон ажил хөдөлмөр эрхлэхийг хориглодог юм. “Тохиромжгүй, аюултай” гэж тодорхойлсон ажил хөдөлмөр эрхлэхийг эмэгтэйчүүдэд хязгаарладаг нь “хатуу ажил”аас тэднийг хамгаалж буйн илэрхийлэл юм.³⁰

Бизнес эрхлэлт, санхүүжилт авах боломж

2015 оны Бизнесийн орчин, аж ахуйн нэгж (ААН)2ийн үйл ажиллагааны судалгаа (BEEPS)-гаар судалгаанд хамрагдсан ААН-ийн 37.8 хувь нь эмэгтэй эзэнтэй байжээ. Бүх судалгаанд хамрагдагсдын 25%-ийн эзэмшлийн 1/3-ийг эмэгтэйчүүд өмчилж, нийт хөдөлмөр эрхлэгчдийн 42.3%, дээд удирдлагын 35.6% нь эмэгтэйчүүд байв. Удирдах зөвлөлд эмэгтэйчүүдийн төлөөллийн квот байхгүй бөгөөд ЕСББ-ын Ерөнхий зөвлөлийн газраас хийсэн судалгаагаар (2016) томоохон компаниудын удирдах зөвлөлд эмэгтэйчүүд ердөө 3.2% төлөөлөлтэй байгаа нь ЕСББ үйл ажиллагаагаа явуулдаг орнууд дотор хамгийн бага үзүүлэлт юм.

Албан ёсны санхүүгийн үйлчилгээ авахад хүйсийн хувьд мэдэгдэхүйц ялгаа байхгүй байгаа нь банк санхүүгийн байгууллагад нийт эмэгтэйчүүдийн 93.2%, нийт эрэгтэйчүүдийн 90.3% нь данстай байгаагаар нотлогдож байна. Нийт дүндээ банкинд хувийн харилцах данс ашиглах хувь хэмжээ өндөр байгаа юм.³¹ Гэхдээ, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд ялгаагүй барьцаа хөрөнгө байхгүй байгаа нь зээл авахад хамгийн том асуудал үүсгэж байгаа. ЕСББ-ын санхүүжилтээр 2011 онд хийгдсэн хөдөөд жижиг зээл олгоход эмэгтэйчүүдийн оролцоонд хийсэн судалгаагаар баг, хамт олонд зээл олгох нь эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлт, ялангуяа боловсрол нимгэн эмэгтэйчүүдийн хувьд эерэг үр нөлөө үзүүлж байсныг тогтоожээ.³²

Манлайлал, шийдвэр гаргах

УИХ-ын сонгуульд намын жагсаалтаар нэр дэвшигчдийн 20% нь эмэгтэйчүүд байхаар 2011 онд квот тогтоосон.³³ Гэсэн хэдий ч өнөөгийн УИХ-ын 76 гишүүний 13 нь эмэгтэй байгаа нь ЕАБХАБ-ын дундаж үзүүлэлт болох 24.4%-с бага юм.³⁴ Шүүхэд эмэгтэйчүүд илүү олуулаа (24 шүүгчээс 13 нь эмэгтэй³⁵) боловч удирдлага, шийдвэр гаргах түвшинд, ялангуяа хувийн хэвшлийн салбарын удирдлагад эмэгтэйчүүдийн төлөөлөл бага юм.

²⁸ The Asia Foundation. 2015. *Women's Labor Rights: The Road Ahead*. <http://asiafoundation.org/in-asia/2015/04/29/womens-labor-rights-the-road-ahead/>

²⁹ Swiss Agency for Development and Coordination. 2014. *Gender Overview. Mongolia Desk Study*. Retrieved from <https://www.eda.admin.ch/content/dam/countries/countries-content/mongolia/en/SDC-Gender-%20Overview-Mongolia-%202014-EN.pdf>

³⁰ OECD. *SIGI Index. Mongolia*. http://www.genderindex.org/country/mongolia#_ftn5

³¹ The World Bank. *Findex. Mongolia*. <http://databank.worldbank.org/data/reports.aspx?source=1228>

³² EBRD. 2011. *Group lending or individual lending? Evidence from a randomised field experiment in Mongolia*. <http://www.ebrd.com/downloads/research/economics/workingpapers/wp0136.pdf>

³³ Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27.2 заалт. Retrieved from http://anfrel.org/wp-content/uploads/2012/04/20120130_New-Parliamentary-Election-Law_Eng-changed-20120201.pdf

³⁴ Parline. 2014. *Mongolia*. http://www.ipu.org/parline-e/reports/2219_A.htm

³⁵ Supreme Court of Mongolia. <http://www.supremecourt.mn/english/content/7>

Бусад

Хүйсийн ялгарал хот газар гэхээсээ хөдөөд илүүтэй байна. Гэр бүлийн хүчирхийлэл Монголын эмэгтэйчүүдийн хувьд том асуудал хэвээр.

Үүнээс гадна эрэгтэйчүүдийн дунд өвчлөл, нас баралт өндөр байгаа нь тэдний эрүүл мэндийн асуудал санаа зовоох хэмжээнд хүрчээ. Архи, тамхины хэрэглээ, амиа хорлолт, амиа алдах, зам тээврийн осолд өртөх, хүнд хүчир хөдөлмөр эрхлэх хувь хэмжээ өндөр байгаа нь уг асуудлыг зарим талаар үүсгэж буй.³⁶ Их дээд сургуульд суралцагсдын дундах хүйсийн харьцаа алдагдсан нь цаашид ямар үр дагавартай нь одоогоор тодорхойгүй.

³⁶ Swiss Agency for Development and Coordination. 2014. *Gender Overview. Mongolia Desk Study*. Retrieved from <https://www.eda.admin.ch/content/dam/countries/countries-content/mongolia/en/SDC-Gender-%20Overview-Mongolia-%202014-EN.pdf>

ХАВСРАЛТ 6 – ЕСБХБ БА ХАНДИВЛАГЧИД

Буцалтгүй тусламжаар санхүүжсэн Монгол дахь техник хамтын ажиллагаа (ТХА) нь хөтөлбөрийн бэлтгэл ажлын дэмжлэг, түүний дотор дэд бүтцийн хөрөнгө оруулалтын бэлтгэл, боломжит үйлчлүүлэгчдийн чадавхийг бий болгох, зохицуулалт болон шүүх байгууллагын чадавхи бий болгох зэрэг ажлыг гүйцэтгэх боломжийг тус Банкинд олгосон. ТХА-ны тусламжийг мөн ур чадвар дамжуулах, хувийн БЖДҮ-ийн өсөлт хөгжлийг дэмжих, Жижиг бизнесийн санаачилга хөтөлбөрийн нэг хэсэг болох Жижиг бизнест зөвлөгөө өгөх үйлчилгээний хүрээнд үндэсний болоод олон улсын зөвлөхүүд ажиллуулах зэрэгт ашигласан.

Монгол Улс тогтвортой эрчим хүч, санхүүгийн салбарт санхүүгийн урамшуулал, анхны алдагдлын нөхөн олговор хэлбэрээр авсан хамтын хөрөнгө оруулалтын буцалтгүй тусламжаас бас ашиг тус хүртсэн. Эдгээр буцалтгүй тусламжийг уур амьсгалын өөрчлөлтийн олон талт сангууд, олон талт хандивлагчдын тусгай сангуудаас гаргаж санхүүжүүлсэн.

Хандивлагчдын буцалтгүй тусламжийн анхаарал өмнөх дэмжлэгийн түвшинд үлдэх байх гэсэн хүлээлттэй байна. Монгол дахь буцалтгүй тусламжийн 2017 оны хэрэгцээний дүн шинжилгээгээр хот суурин газар, байгаль орчны дэд бүтцийн төслүүд, ногоон эдийн засгийн шилжилтийн чадавхи бий болгох, шүүх байгууллага, зохицуулалтын системийг сайжруулах техник тусамжийн хэрэгцээ өндөр байхаар байна.

Эдгээр эрэлт хэрэгцээг хангахын тулд ЕСБХБ өөрийн хувьцаа эзэмшигчдийн гаргах эх үүсвэрээс гадна, тус Банкны захиран зарцуулдаг, эсвэл гаднаас менежмент хийдэг хандивлагчдын хэд хэдэн сангийн санхүүжилтэд тулгуурлах болно. Үүнд:

- **Хоёр талын** буцалтгүй тусламж – ЕСБХБ Шилжилтийн эхэн үеийн орнуудын сан зэрэг өөрийн олон талт хандивлагчдын сангууд, мөн хоёр талын сангуудаар дамжуулан, хоёр талын хандивлагчидтай хамтран боломж хайж ажиллана.
- **Европын Холбоо** – ЕСБХБ ЕХ-той түншлэлээ үргэлжлүүлж, Монголд суугаа ЕХ-ны Төлөөлөгчийн газартай нягт хамтран ажиллах замаар Монголд ашиглаж болох ЕХ-ны санхүүгийн механизмуудаас хөрөнгө босгох талаар ажиллана.
- **ЕСБХБ-ны Хувьцаа эзэмшигчдийн тусгай сан (SSF)** - Банкны цэвэр орлогоос бүрддэг SSF сан нь хандивлагчдын санхүүжилт дээр нэмэлт эх үүсвэр болдог бөгөөд дэмжлэг дутагдсан, эсвэл олдохгүй байгаа тохиолдолд ТХА-ны болоод ТХА-ны бус дэмжлэг үзүүлэхэд ашиглагддаг юм Гэхдээ түүнийг ашиглах хүрээ нь шилжилтийг урагшлуулах тус Банкны тэргүүлэх зорилтод үйлчлэх ёстой.